

МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ УЛААН ДАНС БА ХАМГААЛАЛ

(Хоёрдугаар хэвлэл)





Захиалагч:



БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Санхүүжүүлж, зохион байгуулан гүйцэтгэсэн:



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН
(WWF)-ИЙН МОНГОЛ ДАХЬ
ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН
ИХ СУРГУУЛЬ



ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ

МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ УЛААН ДАНС БА ХАМГААЛАЛ

Хоёрдугаар хэвлэл

Боть 14



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



Захиалсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Санхүүжүүлсэн:

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-
ИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

Гүйцэтгэсэн:

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ

Зохиогчид:

Ч.Аюушсүрэн, Г.Ганбилэг, А.Цолмон (ерөнхий
бүлэг ба мөргийн баг)

Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан,
А.Түвшинлхагва, С.Пүрэвдорж (дугариг амтан,
хилэм, яргай, цулбуурт, цурхай, алгана, сагамхай,
бүвэрийн баг)

С.Гомбобаатар, Б.Мэндсайхан, Ч.Аюушсүрэн
(бүлгүүдийн эмхэтгэл)

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий редактор: С.Гомбобаатар, Д.Батболд,
Б.Чимэддорж, Ц.Уранчимэг

Бүлгийн редактор: Г.Баасанжав, С.Гомбобаатар,
Д.Нарангарвуу, С.Пүрэвсүрэн

Зүйлийн тархцын зургийг боловсруулсан:

Г.Ганбилэг, Ч.Аюушсүрэн, А.Цолмон,
С.Гомбобаатар, Г.Ганбилэг.

Хавтас, хавчуулга зураг: © Л.Жаргалсайхан,
ДБХС/Б.Гантулга, ДБХС/Д.Ганбаатар

Гэрэл зураг: © Л.Жаргалсайхан, Ч.Аюушсүрэн,
Г.Ганбилэг

ДАА: 639
ННА: 47
М-692

ISBN: 978-9919-9323-3-6

Зүйлүүдийн үнэлгээ хийсэн:

Б.Мэндсайхан 2.1-2.9, 3.1-3.3, 3.5-3.10, 4.2,
4.3, 4.5, 4.7, 4.15, 4.19, 4.20,
4.25, 4.29, 4.42, 4.56

Б.Мөнхзориг 2.1-2.9, 3.1-3.3, 3.5-3.10, 4.2,
4.3, 4.5, 4.7, 4.15, 4.19, 4.20,
4.25, 4.29, 4.42, 4.56

П.Цогтсайхан 2.1, 2.2, 2.4, 2.5, 2.6, 2.8, 2.9,
3.1, 3.5, 3.7-3.10, 4.2, 4.3,
4.5, 4.15, 4.19, 4.20

А.Түвшинлхагва 3.6, 4.7, 4.25, 4.42

С.Пүрэвдорж 2.7, 3.2, 3.3

Ч.Аюушсүрэн 1.2, 1.3, 3.4, 4.1, 4.4, 4.6, 4.8-
4.14, 4.16-4.18, 4.21-4.24,
4.26-4.28, 4.30-4.41, 4.43-
4.55, 4.57

Г.Ганбилэг 1.2, 1.3, 3.4, 4.1, 4.4, 4.6, 4.8-
4.14, 4.16-4.18, 4.21-4.24,
4.26-4.28, 4.30-4.34, 4.35-
4.41, 4.43-4.55, 4.57

А.Цолмон 1.2, 1.3, 3.4, 4.1, 4.4, 4.6, 4.8-
4.14, 4.16-4.18, 4.21-4.24,
4.26-4.28, 4.30-4.41, 4.43-
4.55, 4.57

Зохиогчийн эрх:

© Монгол Улсын Их Сургууль

© Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн
Яам

© Шинжлэх Ухааны Академи

© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн
Монгол дахь хөтөлбөрийн газар

©2025. Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан
бөгөөд уг номыг худалдан борлуулахыг хориглоно.
Сургалт, судалгаа, хамгаалал, сурталчилгааны
чиглэлээр ашгийн бус зорилгоор эх сурвалжийг
дурдаж, талархал илэрхийлэн ашиглаж болох
ба зураг, газрын зураг, бичвэр, номын агуулга,
бүтцийг олон нийтийн сүлжээнд байршуулах,
онлайн болон оффлайн аппликейшн, бусад
платформд ашиглах, зөвлөх үйлчилгээ болон
бусад зорилгоор ашиглахдаа зохиогч, зохиогчийн
эрх бүхий байгууллагуудаас ашиглах эсэх тухай
зөвшөөрөл заавал авна. Дээрх болон бусад
зорилгоор ашиглуулах, зохиогчийн эрхийн
асуудлыг оролцогч талууд хамтран шийдвэрлэнэ.



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



Эшлэх загвар:

Аюушсүрэн, Ч., Ганбилэг, Г., Цолмон, А. (бүлгийн зохиогч). 2025. *Монгол орны загасны улаан данс ба хамгаалал (мөргийн баг ба ерөнхий бүлэг)*. Хоёрдугаар хэвлэл. Боть 14. Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Академи, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Мэндсайхан, Б., Мөнхзориг, Б., Цогтсайхан, П., Түвшинлхагва, А., Пүрэвдорж, С. (бүлгийн зохиогч). 2025. *Монгол орны загасны улаан данс ба хамгаалал (дугариг амтан, хилэм, яргай, цулбуурт, цурхай, алгана, сагамхай, бүвэрийн баг)*. Хоёрдугаар хэвлэл. Боть 14. Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Академи, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Гомбобаатар, С., Мэндсайхан, Б., Аюушсүрэн, Ч. (бүлгийг эмхэтгэсэн). 2025. *Монгол орны загасны улаан данс ба хамгаалал*. Хоёрдугаар хэвлэл. Боть 14. Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Академи, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Хандах хаяг:

Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Биологийн тэнхим

Профессор С.Гомбобаатар

Утас: +(976)-90112244

Цахим шуудан: gomboo@num.edu.mn

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Хаяг: Интер оффис, Амарын гудамж-4, 8-р хороо, СБД, Улаанбаатар хот 14200

Утас: +(976)-11-311659

Цахим шуудан: info@wwf.mn

Вэбсайт: <https://mongolia.panda.org>

Энэ ном нь цөөн тоогоор хэвлэгдсэн бөгөөд цахим хувилбарыг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дээрх вэбсайтаас үнэ төлбөргүй татаж авна уу.

УДИРТГАЛ.....	06
ӨМНӨХ ҮГ.....	08
ТАЛАРХАЛ.....	09

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ	
ЗАГАСНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ,	
ХОВОРДЛЫН ШАЛТГААН.....11	
1.1. Танилцуулга ба тайлбар.....	12
1.2. Монгол орны загасны өнөөгийн төлөв байдал	25
1.3. Монгол орны загасны зүйлүүдийн ховордлын шалтгаан	28

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ	
ОРНЫ УСТАЖ БАЙГАА (CR) БОЛОН	
УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN) ЗАГАСНЫ	
ЗҮЙЛҮҮДИЙН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН	
ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ..... 29	
2.1. Амарын хилэм	30
2.2. Шивэр хилэм	32
2.3. Алтайн давжаа сугас	35
2.4. Амарын хадран	38
2.5. Говийн сахалт эрээлж.....	40
2.6. Дархадын цагаан загас.....	42
2.7. Ердийн тул.....	45
2.8. Зүүнгарын сугас	48
2.9. Хөвсгөл хадран	50

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ	
ЭМЗЭГ (VU) БОЛОН ХОВОРДОЖ	
БОЛЗОШГҮЙ (NT) ЗАГАСНЫ ЗҮЙЛҮҮДИЙН	
БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ,	
ХАМГААЛАЛ..... 53	
3.1. Енисейн хадран	54
3.2. Монгол хадран	56
3.3. Монхор хоншоорт зэвэг	59
3.4. Шаргал үхэрдээ.....	61
3.5. Шивэр хадран.....	63
3.6. Шөвгөр хоншоорт зэвэг	66

3.7. Бух сугас.....	69
3.8. Хатгуурт харваа	71
3.9. Хорхой загас.....	73
3.10. Цагаан хадир.....	75

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ	
ОРНЫ АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ	
(LC), МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD) БОЛОН	
ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ (NA) ЗАГАСНЫ	
ЗҮЙЛҮҮДИЙН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН	
ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ..... 77	
4.1. Амарын моголзой.....	78
4.2. Амарын цулбуурт	80
4.3. Амарын цурхай.....	82
4.4. Арнолдын эрээлж.....	84
4.5. Голын алгана	86
4.6. Ердийн варлан	88
4.7. Ердийн цурхай.....	90
4.8. Мөнгөлөг хэлтэг	92
4.9. Наймас эрээлж.....	94
4.10. Потанины алтайн сугас	96
4.11. Шивэр сахалт эрээлж	98
4.12. Шивэр сугас.....	100
4.13. Шивэр чимхүүр загас	102
4.14. Эгэл улаан нүдэн	104
4.15. Амарын зантгар.....	106
4.16. Амарын сугас	108
4.17. Амарын хавчигас.....	110
4.18. Амарын хөөлөнхэй.....	112
4.19. Амарын эрээн живэрт.....	114
4.20. Байгалийн омуль.....	116
4.21. Буйрын монхор гүрц	118
4.22. Булуу цагаан.....	120
4.23. Голубцовын сахалт эрээлж	122
4.24. Дух давжаа.....	124
4.25. Ердийн гутаарь.....	126
4.26. Ердийн гүрц.....	128
4.27. Завханы сахалт эрээлж.....	130
4.28. Карабановын сахалт эрээлж.....	132

4.29. Кесслерийн зантгар	134	4.48. Ханхын гүрц.....	172
4.30. Конилобусын сахалт эрээлж	136	4.49. Хятадын хуурамч гүрц	174
4.31. Лаговскийн варлан	138	4.50. Цагаан амар	176
4.32. Манжуурын сугасан гүрц	140	4.51. Цагаан догтор.....	178
4.33. Монголын улаан далбаат	142	4.52. Чекановын варлан	180
4.34. Морин тавхарал	144	4.53. Чоя чимхүүр загас.....	182
4.35. Нуурын варлан	146	4.54. Шивэр гүрц	184
4.36. Өлгөр цагаан	148	4.55. Алтлаг хэлтэг.....	186
4.37. Савадигийн сахалт эрээлж	150	4.56. Амарын бүвэр	188
4.38. Сахалт гүрц	152	4.57. Найман сахалт гүрц	190
4.39. Солдатовын уруулт гүрц.....	154		
4.40. Сэлэнгийн алтайн сугас.....	156	ЭШ ТАТСАН БҮТЭЭЛ.....	192
4.41. Тачановын гүрц	158		
4.42. Тогтмолын цоохлой.....	160	ХАВСРАЛТ	201
4.43. Толбот морин загас.....	162	Хавсралт 1. Дэлхийн байгаль хамгаалах	
4.44. Тэсийн эрээлж.....	164	холбоо (IUCN)-ны ховордлын зэрэглэлийн	
4.45. Улаан живэрт.....	166	үнэлгээний товч тайлбар (IUCN, 2012)....	201
4.46. Хадаасан гүрц	168	Хавсралт 2. Монгол орны загасны	
4.47. Халбаган жараа	170	зүйлүүдийн үнэлгээний нэгтгэл.....	203

Монгол орны Сибирийн тайгаас Төв Азийн хээр, говь цөл хүртэлх өндөр уулсын өвөрмөц систем, ус, намгархаг газар зэрэг экосистемийн нэн олон янз байдал нь 144 зүйл хөхтөн, 519 зүйл шувуу, 25 зүйл мөлхөгч, 7 зүйл хоёр нутагтан, 80 зүйл загас амьдрахад тааламжтай орчныг бүрдүүлдэг.

Дэлхий нийтээр биологийн зүйл бүрийн байгаль хамгаалал, нийгэм, эдийн засаг, соёлын үнэ цэнийг тогтоох, тухайн экологийн систем дэх оролцоог тодруулах, шинжлэх ухааны өгөгдлийг цуглуулах, нэгтгэх, ховордлын зэрэглэлийг тогтоох, хамгааллын төлөвлөгөө боловсруулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэх зорилгоор Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны зэрэглэл, шалгуураар зүйлийг үнэлэх ажлыг Монгол Улсад Дэлхийн банк, Нидерландын Вант Улсын санхүүгийн дэмжлэг, Байгаль орчны яамны бодлогын дэмжлэг, Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн техникийн туслалцаатай Степ форвард хөтөлбөр, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль (МУИС), Шинжлэх Ухааны Академи (ШУА), Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС), Хөдөө Аж Ахуйн Их Сургууль (ХААИС) болон бусад төрийн ба төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачид хамтран 2006 онд боловсруулж, улмаар тэр жилдээ Монгол орны загас, хоёр нутагтан, мөлхөгч, хөхтөн амьтад, 2011 онд шувууны Улаан данс болон хамгааллын төлөвлөгөөг гаргасан нь Азидаа нугаламт амьтдыг үнэлсэн анхны улс орон болж байлаа. Үүнээс хойш Монгол орны гуурст ба гуурсгүй ургамлын Улаан данс, хамгааллын төлөвлөгөөг боловсруулж, олны хүртээл болгосон билээ.

Монгол орны биологийн зүйлийн үнэлгээний үр дүнг эрдэмтэн судлаачид, төрийн захиргааны төв байгууллагатай хамтран Монгол Улсын хууль болон бодлого, эрх зүйн баримт бичигт тусгахаар ажиллаж, улмаар ургамал, амьтны чиглэлийн шинээр батлагдах хууль, тогтоомжийн төсөлд тусгалаа олж буй нь энэ чиглэлээр ажилладаг эрдэмтэн судлаачид болон төрийн захиргааны төв байгууллагын хамтын ажиллагааны чухал үр дүн гэж үзэж байна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах зорилго тавин, амьтан, ургамлын Улаан дансыг шинэчлэн шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлэхээр” үйл ажиллагаагаа төлөвлөсөн нь бидний хамтын ажиллагааны нэгэн чухал үр дүн мөн.

Хүн төрөлхтний олон талт үйл ажиллагаанаас улбаалсан уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, бохирдол, хууль бус агнуур, амьдрах орчны алдагдал зэрэг хүчин зүйлсээс хамааран биологийн олон зүйлүүд устах, мөхөх эрсдэлд орж байна. Монгол орны амьтны зүйлүүдийг улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлэх хугацаа 6 жил байдаг ч санхүүгийн хүндрэл бэрхшээлээс хамааран 19 жилийн дараа Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамнаас олон талуудыг оролцож, дэмжиж хамтран ажиллахыг уриалж, бүхий л нөөц бололцоогоороо дэмжлэг үзүүлж ажилласан бол Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн сацуу энэ багц ажлын олон үе шатны зохион байгуулалт, бүтээлийн эцсийн үр дүнг хүлээлгэн өгөх ажлыг

хариуцаж, МУИС, ШУА, МУБИС, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын эрдэмтэн, судлаачидтай хамтран Монгол орны 76 зүйл загас, 7 зүйл хоёр нутагтан, 25 зүйл мөлхөгчид, 140 зүйл хөхтөн амьтдын зүйлүүдийн үнэлгээг шинэчлэн хийж, анги тус бүрээр нэгтгэсэн бүтээлийг гаргаж байна.

Байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлтэй, экологийн хувьд эмзэг Монгол орны амьтны Улаан дансны үнэлгээг шинэчлэн боловсруулах ажил нь зүйлүүдийн ховордлын шалтгааныг тодорхойлж, цаашид амьтны талаар төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг улам бүр боловсронгуй болгох, сайжруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх арга замыг тодорхойлж, ялангуяа ховордлын зэрэглэлтэй амьтдын талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэгийг олон нийтэд хүргэх, хүн ба байгаль зэрэгцэн оршиход бүх талын оролцоо чухал болохыг ойлгуулахад эдгээр бүтээл нь үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэ бүтээлийг дэмжиж, хамтран ажилласан эрдэмтэн, судлаачид, байгууллага, хамт олонд тусгайлан ТАЛАРХАЛ илгээв.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
Б.БАТБААТАР

Цэнгэг усны экосистем нь дэлхийн гадаргын өчүүхэн хэсгийг эзэлдэг ч манай гарагийн нийт амьд биесийн 10 хувийнх нь орлошгүй амьдрах орчин, 90 хувийнх нь оршин тогтнох эх үндэс болдог. Гэвч сүүлийн жилүүдэд цэнгэг ус болон ус намгархаг газрын экосистем нь эх газрынхтай харьцуулахад илүү хурдацтайгаар доройтож, түүний биологийн төрөл зүйл 1970 оноос хойш өнөөг хүртэл 84 хувиар буурсан байна. Тухайлбал, цэнгэг усны сээр нуруутны гол төлөөлөл загасны 30 хувь нь устах аюулд оржээ. Дэлхийн цэнгэг усны экосистем, түүний биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлж буй байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой голлох хүчин зүйлст уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, эрчимтэй загас агнуур, хууль бус загасчлал, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, уул уурхай, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хотжилт болон харь зүйлийн түрэмгийлэл ордог.

Манай орны нуур, голуудын экосистемд ч дээрх асуудлууд сүүлийн жилүүдэд эрчимтэйгээр нэмэгдсээр байна. Жишээ нь, томоохон голуудын сүлжээ бүрд хаалттай усан санг сэргээгдэх эрчим хүч, усны нөөцийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн усан хангамжийн шийдлийг олох зэрэг зорилгоор байгуулж байгаа болон байгуулахаар төлөвлөсөн нь цэнгэг усны экосистемийг доройтуулах, улмаар түүний биологийн олон янз байдлыг бууруулах, устах аюулд хүргэх юм. Түүнчлэн байгалийн болон хүний үйл ажиллагааны гаралтай доройтлоос хамаарсан усны биологийн төрөл зүйлийн шууд хорогдол ажиглагдах, давтамж нь нэмэгдэх хандлагатай болж байна. Иймээс эдгээр сөрөг нөлөөг олж тогтоох, үнэлэх, бууруулах, арилгахын тулд Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны шалгуураар зүйлийн үнэлгээг хийж, зэрэглэл тогтоож, бүс нутгийн загасны улаан дансыг боловсруулж хамгааллын бодлогод суурилсан арга хэмжээний үндсэн баримт болгох шаардлага гарсан.

Бид 2006 онд Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуураар зүйлийн үнэлгээг хийж, загасны Улаан дансыг анхлан боловсруулахдаа Монгол оронд уугуул тархалттай 64 зүйлээс 48 зүйлийг нь зэрэглэж, 16 зүйлийг нь үнэлэх боломжгүй хэмээн авч үзэж байсан бол түүнээс хойших 20 жилийн загасны судалгааны үр дүнг үндэслэн 2025 онд нийт 77 зүйлийг үнэлсэн нь энэхүү бүтээлийг шинэчлэн эмхэтгэсний гол ололт болж байна.

Хойшид ч орчин үеийн судалгааны шинэлэг, дэвшилттэй арга зүйд суурилсан мэдээ, материал нэмэгдэхийн хэрээр загасанд нүүрлэж буй аюул заналыг тодорхойлох, тэдгээрийг бууруулах, хамгааллын менежментийг хэрэгжүүлэх ажил улам сайжирч, бодлого боловсруулахад үндсэн баримт бичгүүд болж, олны хүртээл болох нь дамжиггүй билээ.

Уг бүтээлийг боловсруулахад оролцсон судлаачид, мэргэжилтнүүд болон холбогдох байгууллагуудад гүн талархал илэрхийлье. Бидний хамтын хүчин чармайлтаар бүтээж буй энэхүү улаан данс нь Монгол орны загасны олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ,
БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
Загас судлаач
ДОКТОР Г.БААСАНЖАВ

Энэхүү “Монгол орны загасны Улаан данс ба хамгаалал” ном нь Монголын загас судлаачдын биет оролцоо, дэмжлэггүйгээр гарах боломжгүй бөгөөд олон судлаачдын хамтын бүтээл юм.

Тус бүтээлд өөрсдийн олон жилийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, оюун ухаан, мэдлэг туршлага, үнэт цагаа сэтгэл харамгүй зарцуулж өмнөх болоод өнөө үеийн эрдэмтэн, судлаачдын судалгааны ажил, бүтээлүүдийг шүүн судалж, зүйлийн бичиглэлийг боловсруулан, үнэлгээг хийж, нэгтгэн танилцуулсан доктор Б.Мэндсайхан, доктор Ч.Аюушсүрэн, Г.Ганбилэг, А.Цолмон, доктор П.Цогтсайхан, Б.Мөнхзориг, А.Түвшинлхагва, С.Пүрэвдорж нарт болон уг бүтээлийг мэргэжлийн хувьд хянан засварласан эрдэмтэн Г.Баасанжав, улаан дансны зэрэглэл, шалгуур, үнэлгээ, бичвэрийг хянасан профессор С.Гомбобаатар, дэд профессор Д.Нарангарвуу нарт онцгойлон талархал илэрхийлье.

Мөн Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлүүдийн тархцын зургийг боловсруулах нарийн чимхлүүр ажлыг нягт нямбай гүйцэтгэсэн Ж.Номундарь, профессор С.Гомбобаатар, доктор Д.Өсөхжаргал нарт баярлалаа.

Өөрсдийн олон жилийн хүч, хөдөлмөр, үнэт цагаа зарцуулан, сэтгэл оюунаа чилээн байж буулгасан, олдоц ховортой зүйлүүдийн гэрэл зургаа харамгүй хандивласан Л.Жаргалсайхан болон загас судлаач, гэрэл зураг сонирхогч нарт талархлаа.

Монгол орны загасны Улаан данс ба хамгаалал бүтээлийг дэмжин ажилласан дараах байгууллагууд болон хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Үүнд:

Монгол Улсын Их Сургууль (МУИС). Төрийн болон төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг хангаж, удирдан зохион байгуулсан, тус төслийн удирдагч МУИС-ийн Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор, профессор С.Гомбобаатар, энэ төслийн хүрээнд шат дараатай нэгдсэн болоод бүлгийн уулзалт, хэлэлцүүлгүүдийг амжилттай зохион байгуулж, арга аргачлал, заавар мэдээллээр хангаж, зүйлийн бичвэрүүдийг нэгтгэж, хянасан МУИС-ийн Биологийн тэнхимийн дэд профессор Д.Нарангарвуу, доктор Д.Өсөхжаргал, уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах бүхий л боломжоор хангаж, хамтран ажилласан тус сургууль болон нэр бүхий тэнхимийн нийт хамт олонд,

Шинжлэх Ухааны Академи (ШУА). Монгол орны загасны зүйлүүдийг Улаан дансны зэрэглэл, шалгуураар үнэлэх, хэлэлцэх, нэгтгэн боловсруулах бүхий л үе шатны үйл ажиллагааг дэмжиж, арвин их мэдлэг туршлагаа хуваалцаж, идэвхтэй оролцсон ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн доктор Б.Мэндсайхан, доктор Ч.Аюушсүрэн, Г.Ганбилэг, А.Цолмон болон тус хүрээлэнгийн нийт хамт олонд,

Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС). Тус бүтээлд онцгой ач холбогдол өгч, эрдэмтэн, судлаач нараа өргөнөөр оролцуулж, хэлэлцүүлэг өрнүүлж, мэдлэг туршлагаа хуваалцан, идэвхтэй хамтран ажилласанд,

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN). Уг номыг туурвихад шаардлагатай холбогдох мэдээ, материал, шалгуур болон мэдээллийн санг ашиглах боломж олгож, техникийн тусалцаа үзүүлсэнд,

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. Монгол орны загасны зүйлүүдийг Улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэн боловсруулах санаачилгыг гаргаж, 2012 оноос хойш хөрөнгө мөнгө босгох нөр их ажил дээр хичээнгүйлэн зүтгэж, тус ажлын санхүүжилтийг бий болгож, зохион байгуулсан тус хөтөлбөрийн газрын захирал Д.Батболд, Байгаль хамгааллын захирал Б.Чимэддорж, доктор Б.Гантулга, С.Пүрэвдорж, мөн тус бүтээлийг “Монгол орны загасны Улаан данс ба хамгаалал” хэмээн нэрийдэж энэ номын болон зүйлийн бичиглэлийн агуулга, чиглэлийг боловсруулах, нэгтгэн хянаж сайжруулах, хэвлэлд бэлтгэх зэргийг бүхий л үе шатанд хариуцан ажилласан зөвлөх С.Пүрэвсүрэн болон тус байгууллагын нийт хамт олонд тусгайлан талархсанаа илэрхийлье.

Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам (БОУАӨЯ). Монгол орны хөхтөн амьтдыг улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэн боловсруулах ажлыг бодлогоор дэмжихийн сацуу цаг заваа зориулж, мэдлэг оюунаа чилээн олон талуудад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг уриалж, албан бичиг хүргүүлэх, уулзаж ярилцах, мөн ажлын ерөнхий чиглэлийг боловсруулан хүргүүлж захиалах, шаардлагатай баримт, материалаар хангах, санал солилцох зэргээр бүхий л үе шатанд удирдлагаар хангаж идэвхийлэн оролцож, нягт хамтран ажилласан БОУАӨЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг болон мэргэжилтэн Б.Хандармаа, тус яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын ахлах мэргэжилтэн Ж.Мөнхдөш, яамныхаа нийт хамт олонд гүн талархал илэрхийлье.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ
БАЙДАЛ, ХОВОРДЛЫН ШАЛТГААН**



1.1. ТАНИЛЦУУЛГА БА ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6.1-д “Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилт”-ын 6.2-т “Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилт”-ын хүрээнд “Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэн шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ” хэмээн тусгаснаас гадна, Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”-т биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, мөн биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх, тогтвортой ашиглах нөхцөлийг хангах, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийг баримтлахаар тодорхой тусгасан.

Монгол Улс нь 2025 оны байдлаар байгаль орчныг хамгаалах чиглэлийн арван найман олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон байгаа бөгөөд тэдгээрээс дөрөв нь биологийн олон янз байдлыг хамгаалах, ялангуяа амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглахтай холбоотой гэрээ, конвенц байна. Үүнд “Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)”-оор өнөө болон хойч үеийнхээ тусын тулд биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах явдлыг хэлэлцэн тохиролцсон бол “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)”-оор манай улс нь нутаг дэвсгэрийнхээ хилийн дотор амьдрах буюу нутгаар нь дамжин өнгөрч байгаа зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг ивээн хамгаалагч байх ёстойг хүлээн зөвшөөрч, “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-оор ус, намгархаг газар нь усны горим болон ургамал ба амьтны аймаг, ялангуяа усны шувуудын амьдрах орчны экологийн зохицуулагч болдог үндсэн үүрэгтэйг харгалзан усны шувууд улирлаар хил дамнан нүүх учир түүнийг олон усны нөөц баялгийн нэгэн адил үзэх ёстойг хүлээн зөвшөөрч, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-оор зэрлэг амьтан, ургамлын аймаг нь энэ ертөнцийн байгалийн тогтолцооны орлуулаггүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийг хамгаалж өнөөгийн болоод хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх, түүнчлэн зэрлэг амьтан, ургамлын зарим зүйлийг олон улсын хэмжээнд хэтрүүлэн ашиглах явдлыг зохицуулахад олон улсын хамтын ажиллагаа нэн шаардлагатайг хүлээн зөвшөөрч тус тус нэгдэн орж, олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээсэн байдаг.

Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, багц хуулийн хэрэгжилтийг хангах, амьтан, ургамлын нөөцийг зохистой ашиглах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг зорилтуудыг тавьсан.

Тэдгээрийн хүрээнд Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай хамтран Амьтны тухай хууль тогтоомжид болон “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулсан ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомжид удаа дараа нөлөөллийн шинжилгээ хийлгэж (2018; 2021), мөн “Монгол орны нэн ховор, ховор амьтад, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хэрэглээ, худалдаа ба хуулийн хариуцлага (2021)” зэрэг бүтээлээр дамжуулан амьтныг хамгаалах талаар холбогдох харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин нь давхардал, хийдэл, зөрчилтэй, эдгээр асуудлыг засаж сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг тогтоож, холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлж,

хамтран ажиллаж байна. Эдгээр ажлын үр дүн гарсаар байгаа бөгөөд тухайлбал, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2024 оны А/240 дүгээр тушаалаар Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын үндэсний Удирдан зохицуулах зөвлөлийн ажиллах журам болон Шинжлэх ухааны зөвлөлийн ажиллах журмууд батлагдан хэрэгжиж байна.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2023 оны А/158 дугаар тушаалаар Амьтны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, улмаар Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн сайдын 2024 оны А/808 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулав. Амьтны тухай хуульд тодорхойлсон нэн ховор, ховор амьтдыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн шалгуур үзүүлэлтээр, мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын өргөн оролцоотойгоор үнэлэн тогтоож, тодорхой давтамжтайгаар (тухайлбал, 6 жил тутамд) үнэлгээг шинэчлэн хийх нь тулгамдсан асуудал болоод байна. Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамнаас уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад шаардлагатай Монгол орны хөхтөн, мөлхөгч, хоёр нутагтан болон загасны Улаан данс (2006)-уудыг шинэчлэн боловсруулах, энэ хүрээнд амьтны зүйлүүдийн үнэлгээг дахин хийж, хамгаалах арга хэмжээг тодорхойлж, тэдгээр цуврал бүтээлүүдийг олны хүртээл болгохоор Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Аам (хуучнаар)-ны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын даргын 2024 оны 06/2375 тоот албан бичгээр тус багц ажлын ерөнхий чиглэлийг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газарт ирүүлснээр энэ ажлын хамтын ажиллагаа эхлэв.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагаар Монгол орны хөхтөн, мөлхөгч, хоёр нутагтан болон загасны зүйлүүдийг олон улсын улаан дансны шалгуураар үнэлж, хамгааллын арга хэмжээг боловсруулах багц ажлыг санхүүжүүлж, зохион байгуулсан бөгөөд олон талууд хамтран гүйцэтгэлээ. Анх 2006 онд Монгол орны хөхтөн, мөлхөгчид, хоёр нутагтан болон загасны зүйлүүдийн тархац, тоо толгой, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлж, хамгааллын төлөвлөгөөг боловсруулснаас хойш даруй 18 жил өнгөрсөн бөгөөд тухайн хугацаанд дээрх зүйлүүдийн тархац, тоо толгой, учирч буй аюул занал ихээхэн өөрчлөгдсөн нь тодорхой тул зүйлүүдийг дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэв.

Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан данс нь дэлхий дээрх амьтан, ургамлын зүйлүүдийн популяцийн нөхцөл байдлыг үнэлдэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичиг юм (Baillie, Groombridge, 1996). Улаан данс нь ангилал зүйн хувьд өөр хоорондоо ялгаатай зүйлүүдийн устах эрсдэлийг үнэлэх чухал арга хэрэгсэл болсон төдийгүй ховордож буй зүйлд тавих анхаарлыг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалахад нэн түрүүнд хийх шаардлагатай ажлыг тодорхойлох анхны арга хэмжээ болдог (Lamoreux *et al.*, 2003). Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуурыг олон улсын стандартыг хангасан гэдгийг хүлээн зөвшөөрч дэлхийн олон улс орнууд болон янз бүрийн байгууллагууд нийтээрээ ашиглаж байна (IUCN, 2001).

Энэ удаагийн “Монгол орны загасны Улаан данс ба хамгаалал” бүтээлийн зүйлийн бичиглэлийн агуулгыг боловсруулахдаа, 2006 онд хэвлэгдсэн Монгол орны загасны Улаан данс болон Монгол орны загасны хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл гэсэн хоёр бүтээлийн агуулгыг нэгтгэн оруулснаас гадна, зарим сэдвүүдийг нэмж, улам бүр баяжуулж нэлээд агууламжтай бүтээл болгосон. Үүнд:

Ангилал зүй. Тухайн зүйлийн монгол болон латин буюу шинжлэх ухааны нэр, мөн баг, овгийн монгол ба латин нэр, бас ижил нэр (хэрвээ тухайн зүйлийн латин, англи, монгол синоним нэр байгаа тохиолдолд таслалаар зааглаж оруулах г.м) зэргийг оруулав.

Ангилал зүйн тойм сэдэвт тухайн зүйлийн ангилал зүйд гарсан өөрчлөлтийг тоймлон бичсэн. Тухайлбал, салбар зүйлээс бие даасан зүйл болгон салгасан тухай баримт, бие даасан зүйлийг хэд хэдэн салбар зүйл болгон ялгасан тухай эсвэл тухайн зүйлийн монгол болон шинжлэх ухааны нэр өөрчлөгдсөн тохиолдолд тайлбарыг хадлаа.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (хуучнаар)-аас Монгол Улсын Их Сургууль (МУИС), Шинжлэх Ухааны Академи (ШУА), төрийн ба төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачдын оролцоотой байгуулсан “Монгол орны Биологийн олон янз байдлын ангилал зүйн зөвлөл”-өөс нэгтгэн боловсруулж, улмаар амьтдын Монгол нэрийг өөрчлөх, шинээр оноох, тэдгээр нэрийг хянах ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын зөвлөл, Улсын нэр томьёоны комисстой хамтран гүйцэтгэсэн *“Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт (Тэргүүн боть) (Редактор: С.Гомбобаатар, С.Шар, У.Айбек, Г.Гэрэлмаа, С.Баярхүү) (2019)”* бүтээлийг үндэслэл болгож, Аюушсүрэн, Мэндсайхан нар (2019)-ын эмхэтгэснийг баримталж, тухайн зүйлийн Монгол нэр болон шинжлэх ухааны нэрийг оруулсныг дурдах нь зүйтэй.

Ер нь цаашид судалгаа, хамгаалал, бодлогын болон хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд энэ бүтээл дээр оноосон тухайн зүйлийн Монгол нэр (мөн шинжлэх ухааны нэр)-ийг баримталж, нэгмөр мөрдөн хэвшүүлэх нь зохистой. Учир нь эрдэмтэн, судлаачид, төрийн албан хаагчид бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрдэм шинжилгээ, судалгааны олон янзын бүтээлд нэг зүйлийг өөр өөрөөр бичих явдал түгээмэл байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

Таних шинж. Тухайн зүйлийг таних биеийн галбир, өнгө зүс, онцлог шинж болон төсөөтэй харагдах зүйлээс ялгарах шинж, мөн бие, сүүл, толгойн урт, өргөн, биеийн жин зэрэг хэмжилтүүд, тухайн зүйлийн шинжийг харуулсан гэрэл зургийг багтааснаараа бүтээл онцлог болов.

Үнэлгээ ба үндэслэл. Олон улсын үнэлгээнд Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн сан (<https://www.iucnredlist.org>)-г ашигласан. Уг мэдээллийн санд Улаан дансны шалгуураар тухайн зүйлийн дэлхийн популяцийн үнэлгээ болон үндэслэлийг оруулсан байдаг. Бүс нутгийн үнэлгээнд Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуур үзүүлэлтүүдээр тухайн зүйлийн Монгол орон дахь популяцийн үнэлгээг шинэчлэн хийж, оруулав. Хэрвээ тухайн зүйлийн бүс нутгийн үнэлгээг өмнө нь хийж байгаагүй бол шинээр хийж, зөвшилцсөн болно.

Энэ удаагийн бүс нутгийн Улаан дансны үнэлгээг “Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны бүс нутгийн түвшний шалгуурын удирдамж: 4.0 хувилбар” (IUCN, 2012)-ын дагуу хийв. Бүс нутгийн хэмжээнд устах эрсдэлийн үнэлгээг үнэн бодит гаргахад удирдамж нь дараах хоёр чухал үүрэгтэй. Нэгдүгээрт “Бүс нутгийн хэмжээнд устсан” болон “Үнэлэх боломжгүй” гэсэн 2 зэрэглэл нэмэгдэнэ (Хүснэгт 1). “Бүс нутгийн хэмжээнд устсан” гэсэн зэрэглэлд дэлхийд тархсан ч тухайн бүс нутагт тохиолдохгүй болсон зүйлийг багтаана. Харин “Үнэлэх боломжгүй” зэрэглэлд тухайн зүйлийн үнэлгээг хийх хангалттай мэдээ, баримт байхгүй тохиолдолд энэ зэрэглэлээр үнэлдэг.

Хүснэгт 1. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны үнэлгээнд ашиглаж буй зэрэглэлийн тодорхойлолт (IUCN, 2012)

УУСТСАН EXTINCT (EX)	Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг Устсан гэсэн зэрэглэлээр үнэлнэ. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчныг тохиромжтой цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж, тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг Устсан гэсэн зэрэглэлд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
БАЙГАЛЬД УУСТСАН EXTINCT IN THE WILD (EW)	Тухайн ангилал зүйн нэгжийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржүүлж байгаа эсвэл тухайн зүйлийн популяциуд түүхэн тархац нутгийн гадна байгалийн нөхцөлд нь байгаа бол Байгальд устсан гэсэн зэрэглэлд оруулдаг. Тухайн ангилал зүйн нэгжид хамаарах бодгалиудыг тохиромжтой цаг хугацаа (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан)-нд нарийн судалж, мөн тухайн зүйлийн уугуул нутагт судалгаа хийсэн ч нэг бодгаль илрүүлээгүй тохиолдолд Байгальд устсан гэсэн зэрэглэлээр үнэлдэг. Судалгааг тухайн зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД УУСТСАН REGIONALLY EXTINCT (RE)	Тухайн ангилал зүйн нэгжийн хамгийн сүүлчийн бодгаль үхсэн эсвэл үзэгдэхээ болсон бөгөөд дахин энэ нутагт шилжин ирэх боломжгүй тохиолдолд Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн зэрэглэлд багтаадаг. Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн зэрэглэлд тухайн зүйлийг оруулахаас өмнө цаг хугацаанд ерөнхий дүрэм тавих боломжгүй. Энэ нь зүйлийн талаарх судалгаа хэр хийгдсэнээс хамаарах болно.
УСТАЖ БАЙГАА CRITICALLY ENDANGERED (CR)	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар Устаж байгаа гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл туйлын их байгааг илтгэсэн Устаж байгаа гэсэн зэрэглэлд хамааруулна.
УСТАЖ БОЛЗОШГҮЙ ENDANGERED (EN)	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар Устаж болзошгүй гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгаа гэсэн агуулгатай.
ЭМЗЭГ VULNERABLE (VU)	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар Эмзэг гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгаа гэж үзэн Эмзэг гэсэн зэрэглэлд хамааруулна.
ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ NEAR THREATENED (NT)	Тухайн ангилал зүйн нэгжийг А-аас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд, Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг гэсэн ховордлын зэрэглэлээр үнэлэх боломжгүй ч богино хугацаанд ирээдүйд устаж, ховордох эрсдэл их байгааг харгалзан Ховордож болзошгүй гэсэн зэрэглэлд багтаадаг.

АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ LEAST CONCERN (LC)	Тухайн ангилал зүйн нэгжийг А-аас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд, Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож болзошгүй зэрэг зэрэглэлийн аль нэгээр үнэлэх боломжгүй тохиолдолд Анхааралд өртөхөөргүй зүйл гэж үзнэ. Өргөн тархац нутагтай, элбэг зүйл энэ зэрэглэлд хамааруулна.
МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ DATA DEFICIENT (DD)	Тухайн ангилал зүйн нэгжийн популяцийн төлөв байдал болон тархцыг үндэслэн устах эрсдэлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээ, баримт хангалтгүй байгаа нөхцөлд Мэдээлэл дутмаг гэсэн зэрэглэлд хамааруулдаг. Тухайн зүйлийн элбэгшил, тархцын талаар мэдээ, баримт дутмаг байж болно. Мэдээлэл дутмаг гэх энэ зэрэглэл нь устах, ховордох эрсдэлийг илэрхийлсэн агуулга биш юм. Зүйлийг энэ зэрэглэлд оруулах нь тухайн зүйлийн талаар илүү мэдээ, баримт хэрэгтэйг илэрхийлдэг төдийгүй тухайн зүйлийн талаар ирээдүйд судалгаа хийж, тухайн судалгаа нь тэр зүйлийг устах эрсдэлтэйг нотлох боломжтой. Өнөөгийн байгаа мэдээ, баримтыг ашигтайгаар хэрэглэх нь нэн чухал. Тухайн зүйлийг Мэдээлэл дутмаг, мөн устах эрсдэлтэйг илэрхийлсэн зэрэглэлийн алинд нь хамааруулахаа маш анхааралтай шийдэх хэрэгтэй. Хэрвээ тухайн зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал, тухайн зүйлийг олон жилийн тэртээд судалсан бол тэр зүйлийг ховордох, устах эрсдэлтэй зэрэглэлд оруулах нь зайлшгүй зөв шийдвэр болно.
ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ NOT EVALUATED (NE)	Бүс нутгийн хэмжээнд үнэлэх шаардлага хангаагүй ангилал зүйн нэгжийг Үнэлэх боломжгүй гэсэн зэрэглэлд багтаадаг.

Энэхүү үнэлгээ нь хоёр шатны үйл явцаас бүрдэх ба эхлээд Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны зэрэглэл, шалгуур (IUCN, 2012)-аар тухайн популяцийг дэлхийн популяцийн төлөөлөл гэж үзэн бүс нутгийн популяцийн мэдээлэлд тулгуурлан үнэлгээ хийнэ (Хавсралт 1-ийг харна уу).

Тухайн популяцид бүс нутгийн гадна байгаа популяци нөлөө үзүүлж байвал үнэлгээг өөрчилнө. Жишээ нь, бүс нутгийн хэмжээнд ховордож байгаа тухайн зүйлийн популяци нь хөрш зэргэлдээ орноос нүүдэллэн ирдэг бодгалиудаар тэтгэгддэг бол тухайн популяцийн бүс нутгийн устах эрсдэл буурч, улмаар үнэлгээ ч мөн буурна. Хэрвээ бүс нутаг дахь тухайн зүйлийн тоо толгой болон популяцийн хэмжээ буурч байгаа бөгөөд тухайн популяци хөрш зэргэлдээ орны популяцийн бодгалиудаас сэлбэгдэх боломжгүй бол бүс нутгийн үнэлгээг ахиулж ховордлын зэрэглэлийг дээшлүүлэх зэрэг байдлаар энэ удаагийн үнэлгээг хийдэг. Үнэлгээний үндэслэл хэсэгт дээр дурдсан Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны зэрэглэл, шалгуур үзүүлэлтүүдээр тухайн зүйлийн бүс нутгийн үнэлгээг шинээр эсвэл шинэчлэн хийж, тогтоосон зэрэглэлийн үндэслэл, судалгааны баримтуудыг аль болох тодорхой тайлбарлаж оруулахыг хичээсэн болно.

Үнэлгээг хийсэн эрдэмтэн, судлаач нар тухайн зүйлийн талаарх өөрсдийн судалгааны үр дүн, мөн өмнөх болон өнөө үеийн эрдэмтдийн судалгааны ажлын үр дүн, бүтээлүүдийг судлан шүүж, тухайн зүйлийн бичиглэлийг боловсруулж, үүн дээрээ үндэслэн зүйлийн бүс нутгийн үнэлгээг дээрх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хичээнгүйлэн хийж, багаараа хэлэлцэн шийдвэрлэж, улмаар дараа дараагийн шатны үнэлгээний хяналтаар оруулан хэлэлцүүлж, хамтран ажиллав.

Харин үнэлгээг хянасан эрдэмтэд тухайн зүйлийн үнэлгээг хийсэн эрдэмтэн, судлаач нарын үнэлгээ, үндэслэл, судалгааны баримт, материалуудыг Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн санд тулгуурлан олон улсын үнэлгээг нягтлан шалгаж, улмаар бүс нутгийн үнэлгээний үнэн бодит эсэхийг давхар хянан нягталж, баталгаажуулав.

Ер нь энэ удаагийн Монгол орны загасны зүйлүүдийг Улаан дансны зэрэглэл, шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх ажлыг зохион байгуулахдаа аль болох олон талыг оролцуулж, тухайн ажлын хэсгийг ангилал зүйн бүлэг (анги, баг, төрөл г.м)-үүдээр багуудад хуваан ажиллуулж, зүйл тус бүрийн үнэлгээг хийсэн бөгөөд үүний дараа тэдгээр багийг хариуцсан эрдэмтэд, мөн бүлгийн ахлагч нар давхар үнэлээг хянах байдлаар зохион байгуулсан тул тодорхой зүйлийн үнэлгээг хийсэн болон хянасан эрдэмтэн, судлаачид олуулаа байгааг зүйл тус бүр дээр харж болно. Тухайлбал, Амарын хилэм загасны үнэлгээ хийсэн Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан нар бол үнэлгээг хянасан С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу нар гэх мэт.

Дэлхийн тархац. Дэлхийн олон оронд баримталж байгаа хэлбэр, агуулгаар баруунаас зүүн тийш чиглэсэн байдлаар тухайн зүйл тархсан улс орон, газар нутгийн нэрийг тодорхой дурдсанаас гадна, өргөн дэлгэр тархсан зарим зүйл амьтдыг тив, бүс нутгийн нэрээр тархац нутгийн тодруулан оруулсан болно.

Монгол орны тархац, амьдрах орчин. Тухайн зүйлийн Монгол орон дахь тархац, байршил нутгийг баруунаас зүүн тийш гол мөрний ай сав, газар усны нэрээр тодорхой дурдаж, тайлбарлав. Монгол орны гол, мөрөн, нуурууд нь урсгалынхаа чиглэлээс хамааран гурван том ай савд хуваагдана (Зураг 1). Монгол орны хойд хэсгийн гол, нуур болон бусад ус, намгархаг газрууд **Хойд мөсөн далайн ай савын** нэгээхэн хэсэг болно. Энэ ай савд Сэлэнгэ мөрөн, Идэр, Чулуут, Дэлгэр мөрөн, Бүгсэйн гол, Хануй, Орхон, Тамирын гол, Туул, Хараа, Ерөө, Эгийн гол, Шишхид голууд болон Хөвсгөл, Өгий, Тэрхийн цагаан нуур хамаарна. Монгол орны зүүн хэсгээр гадагш урсах гол, мөрнүүд нь **Номхон далай буюу Амар мөрний ай савд** багтах бөгөөд Агнуурын тэнгис болон Номхон далайд хүрнэ. Энд Онон, Барх, Хурах, Шуурс, Улз, Халх, Дэгээ, Хэрлэн зэрэг голууд болон Буйр нуур хамаарна. Монгол орны нутаг дэвсгэрийн хамгийн томоохон усан сан бүхий бүс нутгийг **Төв Азийн гадагш урсгалгүй ай сав** бүрдүүлэх бөгөөд энэ нь баруун болон төв Азийн ихэнх хэсгийг хамарсан асар том хаалттай ай сав юм. Үүнд Монгол орны баруун хэсгийн Их Нууруудын хотгор болон түүнтэй холбоо бүхий гол, мөрөн, нуурууд, мөн манай орны өмнөд хэсгийн хээр, говь, цөлийн бүсийн нуур, голууд энэ ай савын хэсгийг бүрдүүлнэ.

Харин Монгол орны баруун хилийг даган урсах Булган гол нь хэдийгээр Төв Азийн гадагш урсгалгүй хаалттай ай савд хамаарах боловч Хойд мөсөн далайн ай савын амьтны аймагтай ихээхэн төсөөтэй олон зүйлийн амьтад тохиолддог өвөрмөц онцлогтой. Иймд энэ бүс нутгийн усны ай савыг Алтайн уулсын системээр тусгаарлагдсан Хойд мөсөн далайн ай савын нэгээхэн хэсэг гэж заримдаа үзэх нь бий.

Зураг 1. Монгол орны Хойд мөсөн далай, Номхон далай болон Төв Азийн гадагш урсгалгүй гэсэн гурван ай савыг харуулсан ус зүйн сүлжээний тойм зураг



Үүнээс гадна зүйл тус бүрийн тархцыг сүүлийн үеийн мэдээ, баримтаар баяжуулж, боломжит хэмжээнд нарийвчлан газрын зургаар харуулав. Гэвч нэлээд олон зүйлийн тархцын мэдээ, баримт дутмаг, хангалтгүй байсныг дурдах нь зүйтэй. Газрын зургийг боловсруулахдаа тухайн зүйлийн тархцыг амьдрах орчин, өндөршил, ургамал, амьтны газарзүйн мужлал, засаг захиргааны нэгж (аймаг) болон Монгол орны гадаргын усан сүлжээний зургуудтай давхцуулан боловсрууллаа.

Тухайн зүйлийн түгээмэл тархсан эсвэл шүтэн амьдардаг амьдрах орчны хэлбэрүүдийг тайлбарлан оруулахдаа Дэлхийн байгаль хамгаалах холбооны боловсруулсан амьдрах орчны төрөл (Habitat type)-үүдийг кодын хамт оруулсан. Тухайлбал, тогтмол урсгалтай голын (5.1) тогтуун урсгалтай хэсэг, эрэг доогуур, улирлын чанартай байнгын бус гол (5.2), цэнгэг уст нуур (5.5), шорвог нуур (5.14), улирлын чанартай байнгын бус давсархаг нуурын (5.15) эрэг орчмын гүехэн хэсгээр амьдарна гэх мэт.

Амьдралын онцлог. Тухайн зүйлийн амьдралын хэлбэр, идэвхжил, идэш тэжээл, ороо хөөцөө, үржил хөгжил, ичээлэх хугацаа зэрэг онцлогуудын талаар судалгааны мэдээ, баримтад тулгуурлан тодорхой тайлбарлав. Гэвч зарим зүйл амьтдын хувьд маш бага судлагдсан эсвэл судлагдаагүй учир судалгааны мэдээ, баримт маш хомс, тодорхойгүй байсныг дурдах нь зүйтэй.

Тоо толгой, нягтшил. Тухайн зүйлийн бүс нутгийн популяцийн хэмжээ, тоо толгой, нягтшил, нөөцийн талаарх мэдээ, баримтыг судалгааны бүтээл, ном зохиол болон бусад баталгаатай эх сурвалжийг ашиглаж, тоо баримттай тайлбарлан (тухайн зүйл амьтны популяцийн хэмжээ, тусгаар популяциудын нөхцөл байдал, популяци/иудын өсөх, буурах, тогтвортой байдал, хандлага г.м) оруулахыг хичээв. Гэвч зарим зүйл амьтдын хувьд мэдээ, баримт тун хомс. Харин тухайн зүйлийн дэлхийн тархац, популяцийн хэмжээ, тоо толгой, төлөв байдал, хандлагын талаарх мэдээ, баримтад Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн сан, бүтээлүүдийг ашигласан болно.

Ховордлын шалтгаан. Тухайн зүйлийн тоо толгой, тархац нутаг, нүүдэл шилжилт, амьдрах орчинд сөргөөр нөлөөлж, ховордуулж буй гол шалтгаануудын талаарх мэдээ, баримтуудыг судалгааны бүтээл, ном зохиол, эх сурвалжийг ашиглаж, тайлбарлан оруулахад ихээхэн анхаарав. Түүнчлэн Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан аюул заналын

жагсаалт (threat list)-аас аль тохирохыг нь сонгож кодын хамт орууллаа. Тухайлбал, бух сугас загас нь дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, бохирдол (1), тороор (4.1.2) агнаж (1.3.2) ахуйн хэрэгцээнд (1.3.2.1) ашигладаг, эрчимтэй агнуурын нөлөөгөөр (1.3.2) нөөц нь багасаж байгаа зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Тухайн зүйл амьтан “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)” болон олон улсын бусад гэрээ, конвенц, баримт бичгүүдэд хэрхэн үнэлэгдэж, хэддүгээр хавсралтад нь бүртгэгдсэнийг тодруулж, оруулав. Үүнд Монгол оронд одоогоор тэмдэглэгдээд буй 80-аад зүйл загаснаас Шивэр хилэм, Амар мөрний хилэм хэмээх хоёр зүйл дээрх нэр бүхий 2 конвенцын II хавсралтад тус тус бүртгэгдсэн байдаг. “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын англи хэл дээрх товчлол болох CITES гэсэн нэрээр олны танил болсон байдаг. Энэ конвенц нь тодорхой зүйл болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааг хянахад чиглэнэ. Конвенцод хамаарах зүйлүүдийн импорт, экспорт, ре-экспорт нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, үе шатны дагуу хийгдэх ёстой. Конвенцод нэгдэн орсон тал, нэгдэж ороогүй аль нэгэн улстай зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн худалдаа хийх тохиолдолд энэ конвенцын заалтыг мөрдөх үүрэг хүлээдэг.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц” нь дараах гурван хавсралттай бөгөөд хавсралт бүр нь ховордсон ургамал, амьтны зүйлийг агуулна. Үүнд:

CITES I ХАВСРАЛТ	Олон улсын худалдаа нь тухайн зүйлийн оршин тогтноход нөлөө үзүүлж байгаа эсвэл нөлөө үзүүлж болох, устах аюулд орсон бүх зүйл хамаарна. Энэ конвенцын I хавсралтад орсон зүйлийн худалдааг хатуу хяналт зохицуулалттайгаар явуулдаг бөгөөд арилжааны зорилгоор худалдаалахыг үндсэндээ хориглож, судалгаа шинжилгээний зорилгоор экспортлох болон импортлоход экспорт, импортын баримт бичиг бүрдүүлэхийг шаарддаг.
CITES II ХАВСРАЛТ	Эдүгээ устах аюулд ороогүй ч тухайн зүйлийн цаашид оршин тогтноход харшлахаар ашиглалт явуулахгүй байх үүднээс олон улсын худалдааг хяналт зохицуулалттай явуулахгүй бол устах аюулд орж болзошгүй зүйлүүд багтана. Энэ конвенцын II хавсралтад багтсан зүйлүүдийг арилжааны зорилгоор худалдаалж болох бөгөөд экспортлох, импортлоход экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.
CITES III ХАВСРАЛТ	Аль нэгэн тал өөрийн улсын нутаг дэвсгэрийн дотор зохицуулах шаардлагатай гэж тодорхойлсон ба тэдгээрийн худалдааг хянахад бусад талуудтай хамтран ажиллах шаардлагатай хэмээн үзэж байгаа зүйлүүд багтана. Экспортлох, импортлоход гарал үүслийн гэрчилгээ болон тухайн зүйлийг энэ хавсралтад оруулсан улсаас экспортолж байгаа тохиолдолд экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцыг анх талуудын уулзалтыг зохион байгуулсан газрын нэрээр Боннын конвенц хэмээн товчлох бөгөөд тус конвенцын хүрээнд нэгдэн орсон талууд өөрийн улсын нутаг дэвсгэрт амьдардаг, мөн дайран өнгөрдөг шувууд, далай тэнгисийн болон хуурай газрын зүйлүүдийг амьдрах орчных нь хүрээнд хамгаалах үүрэг хүлээнэ. Уг конвенцод одоогоор 133 тал (132 улс, Европын холбоо) нэгдэн

ороод байна (www.cms.int/en). Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцын I ба II хавсралтуудыг тайлбарлавал:

ЗЭРЛЭГ АМЬТДЫН НҮҮДЛИЙН ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CMS) I ХАВСРАЛТ	Тархац нутагтаа эсвэл тодорхой нэг хэсэгт нь устаж үгүй болох аюул нүүрлэсэн нүүдлийн зүйлүүдийг энэ конвенцын I хавсралтад оруулдаг. Аливаа улс эдгээр амьтад болон амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нүүдэллэхэд нь саад болдог бэрхшээлийг багасгах, мөн тэдэнд аюул болж болохуйц бусад хүчин зүйлийг хянах ёстой байдаг.
ЗЭРЛЭГ АМЬТДЫН НҮҮДЛИЙН ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CMS) II ХАВСРАЛТ	Тодорхой нэг зүйл амьтныг хамгаалах үйл ажиллагаанд олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн зүйлийг энэ конвенцын II хавсралтад оруулдаг. Иймээс уг конвенцын зүгээс II хавсралтад орсон нэг зүйл эсвэл ихэвчлэн нэг хэсэг бүлэг зүйлийн хамгаалал болон менежментийн асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг хангах зорилгоор дэлхийн хэмжээний эсвэл бүс нутгийн хэмжээний гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллахыг шаарддаг.
Шаардлагатай бол зарим зүйлийг I ба II хавсралтын хоёуланд нь оруулж болдог.	

Загас нь Монгол орны амьтны аймгийн салшгүй бүрэлдэхүүн бөгөөд экологи, генетик, шинжлэх ухаан, соёл боловсрол, аялал жуулчлал, амралт, гоо зүй, агнуурын үлэмж ач холбогдол бүхий амьтад юм.

Амьтны тухай хуулиар тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах, Генетик нөөцийн тухай хуулиар амьтны генетик нөөцийг хамгаалах, судлан хөгжүүлэх, ашиглах, мөн Зөвшөөрлийн тухай хуулиар амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох зэрэг харилцааг зохицуулсан бол Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, бусад хууль тогтоомжид ч амьтны аймагтай холбогдох заалтууд бий.

Эдгээрээс Амьтны тухай хуулийн зүйлийн хамгааллын статус, ашиглах зориулалт, зөвшөөрөл, агнах, барихыг хориглосон хугацаа болон амьтныг агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл, амьтны аймагт учирсан хохирол, нөхөн төлбөр, хариуцлага зэргийг товчлон тайлбарлав. Ингэхдээ энэ хуулиас бүрэн эхийг нь дэлгэрүүлэн уншихад хялбар байлгахыг зорьж хуулийн зүйл, хэсэг, заалтыг хураангуйлж хашилтад “()” дотор бичсэн.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлд амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах (6.1.3), амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах (6.1.4), үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх (6.1.7), өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах (6.1.9), амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг гаргахад чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх (6.1.10), иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах (6.1.11) зэрэг хэлбэрээр хамгаална гэжээ.

Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нэн ховор амьтанд Амарын хилэм (Хар мөрний хилэм), Шаргал үхэрдээ хэмээх хоёр зүйл загас орсон бол энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад Ердийн тул (Тул) загас орсон байна.

Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болох (7.2) бөгөөд энд зааснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглодог (7.3).

Ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1), Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн (7.5.2), мөн тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор (7.5.3) зөвхөн агнаж, барьж болно.

Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар (9.2.3) дархадын цагаан загасыг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл, (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл, (9.2.5) омор загасыг жил бүрийн 8 дугаар сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл, (9.2.6) зарам загасыг жил бүрийн 9 дүгээр сарын 05-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл, (9.2.7) алтайн сугас загасыг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, (9.2.8) энэ хуулийн 9.2.3-9.2.7-д зааснаас бусад загасыг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, тусгайлан (9.8.6) тул загасыг жил бүрийн 10 дугаар сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглосон байна.

Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглосон бол энэ хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар (11.1.11) үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих бүх төрлийн торны нүдний хэмжээ 50х50 мм-ээс доош байхаар заажээ.

Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд (25.1) иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулахаар, (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгохоор тус тус заасан байна.

Мөн энэ хуулийн 28 дугаар зүйлд зааснаар ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад зөвшөөрөл бүхий иргэн (28.1) зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд (28.2) ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичигт иргэний овог, эцгийн нэр, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заана гэжээ. Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих нэг удаагийн эрхийн бичгийг Монгол Улсын иргэнд (28.3.1) шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног, (28.3.2) энэ хуулийн 28.3.1-д зааснаас бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хонгийн хугацаагаар олгох бөгөөд (28.4) энэ хуулийн 28.3-т заасан иргэнд нэг удаагийн эрхийн бичгээр агнах, барихыг зөвшөөрөх агнуурын амьтны тоо хэмжээ нь туурайтан амьтан нэг, тарвага тав, бусад үслэг ан нэг, хөтүү, ятуу, ногтруу шувуу тус бүр арав, ой, хээр, ус, намгийн бусад агнуурын шувуу тав, бусад агнуурын загас арван ширхгээс илүүгүй байна, мөн (28.5) Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн Монгол Улсын иргэний адил хэмжээний төлбөр төлж, ахуйн зориулалтаар зөвхөн загас барьж болно хэмээн тус тус заажээ.

Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг (37.1) бөгөөд энэ нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин өсгөж тогтоох (37.2) ба энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (39.2) байна.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-нд 78 зүйл загасны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоож, батлуулсан байгаа нь тун сайшаалтай байлаа. Ингэснээр, амьтны нөөц ашигласны төлбөр, хураамж, амьтны

аймагт учруулсан хохирол, нөхөн төлбөрийг тооцох суурь үнэ цэн болох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Иргэд, олон нийт хамгийн түгээмлээр ашигладаг зориулалтыг харгалзан Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т зааснаас зөвхөн ахуйн зориулалтаар агнасан амьтны төлбөрийг тухайн амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийн доод, дээд хязгаарын хувь, хэмжээг тогтоох заалтыг баримталж, тайлбарласан болно. Тухайлбал, алтлаг хэлтэг загасны экологи-эдийн засгийн үнэлгээ 14,500 төгрөг бөгөөд ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө гэх мэтчилэн.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг (1.1) ашигласан, (1.2) барьсан, (1.3) агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно хэмээн тус тус заасан.

Энэ хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

3 дахь хэсэгт ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

4 дэх хэсэгт агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

5 дахь хэсэгт агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно хэмээн тус тус заажээ. Энэ хуулийн 7.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

7 дахь хэсэгт харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

8 дахь хэсэгт энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн

этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

9 дэх хэсэгт амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тус тус заасныг анхаарах нь зүйтэй.

Үүнээс гадна, Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэжээ.

Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх; 2 дахь хэсэгт нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус заасныг анхаарууштай.

Манай зарим иргэд сонин гойд өнгө зүс бүхий жижиг загас, жараахайг аквариумд тэжээх, амьтны дэлгүүрүүдэд худалдаалах, өөр хоорондоо солилцох явдал байх бөгөөд тэдгээр нь тодорхой зөвшөөрөлтэй явагдах үйл ажиллагаа гэдгийг анхаарвал зохистой.

Амьтны тухай хуульд заасанчлан(4.1.24) амьтны жам ёсны эрхийг дээдэлж идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байлгах зарчмыг хүндэтгэн үзэж, (34.2) амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглогсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулж, зөвлөгөө тусламж авч, хамтран ажиллах нь зүйтэй.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг Засгийн газар, харин 1.3-д заасан амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, 1.8 дахь генетикийн нөөц, генетикийн нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, 1.15 дахь ховор амьд амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрлүүдийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгодог бол энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.20-д заасан олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох тусгай зөвшөөрлийг конвенцын Удирдан зохицуулах зөвлөл олгодог.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг онцгойлон авч үзэж, энэ хуульд заасан ангиллаар тухайн зүйлийн тархац нутгийн тодорхой хувь, эсвэл бүхэлдээ юм уу хэсэгчлэн улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан эсэхийг тодорхой оруулахыг хичээсэн болно. Тухайлбал, шаргал үхэрдээ загасны үндсэн тархац нутаг Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газарт хамрагджээ гэх мэт. Ингэж тухайн зүйлийн тархац нутаг нь улсын

тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан эсэхийг онцгойлон авч үзсэний учир нь нэн ховор, ховор амьтан эсэхээс үл хамааран дээр дурдсанчлан Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан ... бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн заасан бөгөөд гэмт хэргийн шинжийг агуулах тул үүнийг олон нийтэд анхааруулж, ойлгуулахыг зорьсон хэрэг юм. Монгол орны ихэнх зүйл загасны тархац нутаг ямар нэгэн хэмжээгээр улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан байх тул зүйл болгон дээр энэ талаар тайлбарлах нь дахин давтагдаж нуршуу болох учир энд тайлбарлан орхив.

Ер нь дээр дурдсанчлан холбогдох хууль тогтоомжуудад Монгол орны загасны зүйлүүдийг ашиглах зориулалт, хэлбэр, зөвшөөрөл, төлбөр хураамж, хамгаалах хэлбэр, агнах, барихыг хориглосон хугацаа болон агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл, амьтны аймагт учирсан хохирол, нөхөн төлбөр, хариуцлагын талаар тодорхой заасан байх бөгөөд хуулиас дэлгэрүүлэн үзэж, олон нийтэд сурталчлан таниулах нь тун чухал юм.

Монгол Улсын Улаан ном (1987; 1997; 2013; 2016)-д тухайн зүйл амьтан орсон эсэхийг шүүн үзэж, хэрвээ орсон байвал тэр тухай дурдсан болно. Тухайлбал, шаргал үхэрдээ загас Монгол Улсын Улаан ном (2013, 2016)-д нэн ховор зүйлээр бүртгэгджээ.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орон дахь тухайн зүйлийн ховордлын шалтгааныг бууруулах, ирээдүйд тус зүйлийг өсөн үржих, тархац нутгаа тэлэх боломжийг хангахад чиглэгдсэн хамгааллын арга хэмжээг оруулахдаа Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан Үндэсний түвшинд авч хэрэгжүүлэх хамгааллын арга хэмжээнүүдийн жагсаалт (Conservation actions)-аас тухайн зүйлийн хамгаалалд илүү нийцэх юм уу хамгийн чухал гэсэн арга хэмжээнүүдийг түүвэрлэн авч, кодын хамт оруулсан. Тухайлбал, Бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр “Эмзэг” хэмээн үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2), ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гений сан бүрдүүлэх (5.7.2), энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэх мэтээр санал дэвшүүлэв.

Энэ бүтээлийг улс орны хэмжээнд болон орон нутгийн түвшинд бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, аливаа төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж буй төрийн албан хаагчид, их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын эрдэмтэн, судлаач, багш нар, оюутан, сонсогч, залуус, хууль сахиулах болон байгаль орчны байгууллагуудын албан хаагчид, мэргэжилтэн, улсын байцаагч, байгаль хамгаалагч, мэргэжилтэн, экспертүүд болон Монгол орны амьтны аймгийг сонирхон судлагч хүн бүхэнд зориулав.

1.2. МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол орны загасны ховордлын зэрэглэлийг анх 2006 онд Дэлхийн байгаль хамгаалах холбооноос эрхлэн гаргасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу бүс нутгийн түвшинд үнэлсэн билээ. Тухайн үед манай оронд тархсан 64 уугуул зүйлээс 48 зүйлийг нь үнэлэн зэрэглэж байв.

Монгол орны загасны Улаан дансны анхны эмхэтгэл хэвлэгдсэнээс хойших 19 жилийн хугацаанд Монгол орны загасны судалгааны мэдээ, баримт, материал генетик, молекул биологи болон филогенетикийн олон тооны үр дүнгээр улам бүр баяжиж, шинэчлэгдсэнээс гадна, шинэ зүйл, тархалтын шинэ цэгүүд ч тэмдэглэгдсэн байна.

Түүнчлэн олон улсад мөрдөгдөж буй нэршил, ангилал зүйн систем ч зарим зүйлийн хувьд өөрчлөгдсөн. Тухайлбал, өмнөх Улаан дансанд багтсан Солдатовын гүрц (*Gobio soldatovi*) нь олон улсын нэршлийн системийн дагуу Солдатовын уруулт гүрц (*Sarcocheilichthys soldatovi*) болж, цагаан сэлүүрт гүрц (*Gobio tenuicarpus*) нь сахалт гүрц (*Romanogobio tenuicarpus*) болж тус тус өөрчлөгдөв. Харин нохой сугас (*Oreoleuciscus angusticephalus*) нь Потанины Алтайн сугас (*Oreoleuciscus potaninii*)-ны морфологийн хувьд ялгаатай хэлбэр болохыг нь генетикийн судалгаагаар тогтоосон. Мөн 2006 оны эмхэтгэл гарснаас хойш 2007 онд Савадигийн сахалт эрээлж (*Barbatula sawadai*), 2016 онд Завханы сахалт эрээлж (*Barbatula dsapchynensis*), Конилобусын сахалт эрээлж (*Barbatula conilobus*), 2018 онд Карбановын сахалт эрээлж (*Barbatula karbanowi*) зэрэг зүйл тус тус шинжлэх ухаанд шинээр тэмдэглэгдлээ. Мөн найман сахалт гүрц (*Gobiobotia rappenheimeri*) болон охор толгойт хадран (*Thymallus brevicephalus*)-ийн тархалтын шинэ цэг манай оронд тэмдэглэгдэв.

Дэлхийн байгаль хамгаалах холбооны зэрэглэл, шалгуур үзүүлэлтийн дагуу бүс нутагт уугуул бус тархалттай, харь зүйлийг үнэлэхгүй гэсэн зарчим ёсоор Оросоос 1978-1986 онд Завхан аймгийн Улаагчины Хар нуур, Өвөрхангай аймгийн Найман нуур, Хөвсгөл аймгийн Тарган нуурт нутагшуулсан цагаан зарам (*Coregonus peled*) болон Сэлэнгэ мөрний саваар дамжин тархац хүрээгээ тэлэн тэмдэглэгдсэн ердийн зоодой (*Abramis brama*), шалгуур хангах мэдээлэл дутмаг охор толгойт хадран (*Thymallus brevicephalus*) зэрэг зүйлийг энэхүү Улаан дансны үнэлгээнд оруулаагүй болно.

Өмнө нь шивэр эрээнживэрт (*Cottus sibiricus*) гэж тодорхойлогдож байгаад олон улсын нэршлийн дагуу шивэр зантгар (*Paracottus knerii*) хэмээн нэрлэгдэх болсон энэ зүйлийг Сэлэнгэ мөрний савд тохиолдох магадлалтай гэж үзээд Монгол орны нийт загасны зүйлийн бүрдэлд багтаасан ч биологи, экологийн судалгааны мэдээ, баримт дутмаг учир үнэлээгүй болно.


Монгол оронд тэмдэглэгдсэн 80 зүйл загаснаас 76 зүйлийг нь үнэлэв. Үнэлгээ хийсэн 76 зүйл загасны дотор бүс нутгийн хэмжээнд Устаж байгаа (CR) 2 зүйл, Устаж болзошгүй (EN) 7 зүйл, Эмзэг (VU) 6 зүйл, Ховордож болзошгүй (NT) 4 зүйл, Анхааралд өртөхөөргүй (LC) 14 зүйл, Мэдээлэл дутмаг (DD) 40 зүйл болон Үнэлэх боломжгүй (NE) 3 зүйл загас байлаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Монгол орны загасны зүйлүүдийн үнэлгээ

№	Зэрэглэл	Зүйлийн тоо	Эзлэх %
1	УСТАЖ БАЙГАА (CRITICALLY ENDANGERED) (CR)	2	2.6
2	УСТАЖ БОЛЗОШГҮЙ (ENDANGERED) (EN)	7	9.2
3	ЭМЗЭГ (VULNERABLE) (VU)	6	7.9
4	ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (NEAR THREATENED) (NT)	4	5.3
5	АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (LEAST CONCERN) (LC)	14	18.4
6	МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DATA DEFICIENT) (DD)	40	52.6
7	ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ (NOT APPLICABLE) (NA)	3	3.9
Нийт		76	100

2006 болон 2025 оны Монгол орны загасны Улаан дансанд үнэлгээ хийсэн нийт зүйлийн тоо ялгаатай тул ховордлын зэрэглэлийг шууд харьцуулах нь учир дутагдалтай. Иймд доорх зурагт зүйлүүдийн ховордлын зэрэглэлийг оноор нь ялган харьцуулан харуулав (Зураг 2).

Зураг 2. Монгол орны загасны Улаан дансанд үнэлгээ хийгдсэн зүйлүүдийн ховордлын зэрэглэл: (А) 2006 оны үнэлгээ, (Б) 2025 оны үнэлгээ




Дээрх зургаас харахад 2006 онд нийт үнэлгээ хийгдсэн зүйлүүд дотор Үнэлэх боломжгүй (NA) зэрэглэлтэй зүйлүүд 25%-ийг эзэлж байсан бол 2025 оны үнэлгээгээр энэ зэрэглэлд хамаарах зүйлүүд 3.9%-ийг эзлэх болж буурсан нь бүс нутгийн загасны үнэлгээ, зэрэглэлийг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлж, тусгасныг илтгэж буй юм.

Дэлхийн байгаль хамгаалах холбооны зэрэглэл, шалгуурын дагуу Монгол оронд бүртгэгдсэн 76 зүйл загасны дэлхийн популяцийн чиг хандлагын хамгийн сүүлийн үеийн буюу 2024 оны баримтыг шүүж үзэхэд, үнэлэгдсэн нийт зүйл загасны 18.4% буюу 14 зүйлийн популяцийн чиг хандлага дэлхийн түвшинд буурч байгаа бол 7.9% буюу 6 зүйлийнх өсөж байна.

Популяцийн тоо толгойн хувьд тогтвортой 27.6% буюу 21 зүйл байгаа бол 25% буюу 19 зүйлийнх тодорхойгүй. Харин 21.1% буюу 16 зүйл загас популяцийн чиг хандлагын хувьд ямар нэгэн үнэлгээ байхгүй (Зураг 3). Эдгээр зүй тогтол нь бүс нутгийн хэмжээнд харьцангуй ижил төсөөтэй ч цаашид судалгааны шинэ мэдээ, баримтуудыг тухай бүрд нь энэ үнэлгээний зэрэглэл, чиг хандлагад тусгаж байх шаардлагатайг харуулна.

Зураг 3. Монгол оронд тархсан 76 зүйл загасны дэлхийн популяцийн чиг хандлага



1.3. МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ЗҮЙЛҮҮДИЙН ХОВОРДЛЫН ШАЛТГААН

Манай орны нуур, голуудын загасны популяцид голлон учирч буй ховордлын шалтгааныг Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуураар үнэлэн үзвэл, нийт үнэлэгдсэн зүйлийн 26 нь ховордож байгаа эсэх нь тодорхойгүй, 27 зүйл нь уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагаанаас үүдсэн амьдрах орчны алдагдал, доройтол болох усны түвшний өөрчлөлт, хөдөө аж ахуй, уул уурхай болон үйлдвэрлэлийн гаралтай газар ашиглалт, барилга угсралтын ажлуудад өртөж байна. Мөн уугуул бус зүйлийн загасыг амьд өгөөш болгон ашиглах, судалгаа, үнэлгээгүйгээр нэг усан сангаас нөгөөд нутагшуулах үйл ажиллагаа үргэлжилсээр байгаа нь уугуул зүйлүүдийг түрэмгийлэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн 34 зүйл нь загас агнуур тэр дундаа хэт загасчлалын нөлөөнд илүүтэй өртжээ.

Манай орны томоохон гол мөрний эх, голдирлын дагууд алт олборлолтын үйл ажиллагаа эрчимтэй өрнөж байгаатай холбоотойгоор усны бохирдолд загасны зүйлүүд олноор өртөж байгаа ба түүнчлэн мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн шууд болон дам сөрөг нөлөө ихтэй.

Уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагаанаас хамаарсан байгалийн гамшгийн давтамж сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна. Ялангуяа, жилийн дөрвөн улиралд унах хур тунадасны хэмжээ тогтворгүй болсноор нуур, голын усны түвшин, голдирол өөрчлөгдөж, энэ нь цэнгэг усны экосистем, загасны олон зүйлд ноцтой аюул учруулсаар байна. Түүнчлэн үерийн давтамж нэмэгдсэн нь усны тунгалагшилт, өөрөө цэвэрших процессыг саармагжуулсаар цэнгэг, хүйтэн усанд тархан амьдрах загасны зүйлүүдийг хязгаарлагдмал тархацтай болоход нөлөөлжээ.

Монгол орны хуурай газрын томоохон сээр нуруутны төлөөлөгчдийн хувьд төрийн захиргааны төв байгууллагаас төлөвлөсөн бодлогын хүрээнд 5 жил тутамд тэдгээрийн тооллого зохион байгуулж, тоо толгойн нягтшилыг бодитоор гаргаж, үнэлгээ хийх тогтолцоо аль хэдийн хэвшсэн. Энэ нь тухайн зүйлийг зөв зохистой ашиглах, хамгаалах, тоо толгойн зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэхэд маш чухал. Загасны хувьд популяцийн тоо толгойн хандлагыг тоон үнэлгээний аргаар гаргаж, боловсруулсан судалгаа, мэдээ, баримт хомс хэвээр байна.

Монгол орны загасны судалгааг Оросын аялагчид эхлүүлсэн цагаас загасны ангилал зүйн судалгаа харьцангуй өргөн хүрээнд хийгдсээр өдийг хүрлээ. Манай орны мөрөгийн овгийн зарим зүйл загасны ангилал зүйн асуудал тодорхойгүй хэвээр. Агнуур, аж ахуйн ач холбогдолтой зүйлүүдийн биологи, экологийн судалгаа харьцангуй өргөн хүрээнд хийгдсээр ирсэн бол тэдгээрийн идэш тэжээлийн гинжин хэлхээнд өндөр ач холбогдолтой олноор сүрэлгэн амьдрах, жижиг биетэй, ёроолын зүйлүүдийн экологи, биологийн судалгаа харьцангуй бага зохион байгуулагджээ. Түүнчлэн Монгол оронд 2003 оноос хойш тэмдэглэгдсэн уугуул (эндемик) зүйлүүдийн хувьд энэ төрлийн судалгааг тусгайлан гүйцэтгэх шаардлага их байна.

Загасны олон янз байдалд чиглэсэн хамгааллын арга хэмжээг тодорхойлж, төлөвлөн хэрэгжүүлэхийн тулд тэдгээрт учирч буй сөрөг нөлөө, ховордлын шалтгааныг үнэлэхэд шаардлагатай баримт, мэдээ цуглуулах, нэгтгэх, боловсруулах, биологи, экологи болон популяцийн судалгааг үе шаттайгаар гүйцэтгэх шаардлагатай.

Монгол орны агнуурын загасны тархац, тоо хэмжээ, нягтшилын судалгаа хангалтгүйн зэрэгцээ, хяналт бүртгэлийн нэгдсэн систем хүртээмжтэй бус нь цаашид загасны зохистой агнуурыг төлөвлөхөд хүндрэл учруулахаар байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай буй загасны гэнэтийн хорогдлын шалтгааныг тогтоох судалгааг эхлүүлэх нэн чухал юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ УСТАЖ БАЙГАА (CR)
БОЛОН УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN) ЗАГАСНЫ
ЗҮЙЛҮҮДИЙН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ,
ХАМГААЛАЛ



2.1. АМАРЫН ХИЛЭМ

Acipenser schrenckii

(Brandt, 1869)

Баг: Хилэм (Acipenseriformes)

Овог: Хилэм (Acipenseridae)

Англи нэр: Amur sturgeon

Ижил нэр: *Acipenser baeri schrenckii*, *Sturio schrenckii*, *Acipenser multiscutatus*.



Ангилал зүйн тойм. Оросын нутаг дэвсгэрт хамаарах Онон голд тархсан (Соколова, 1983) бөгөөд Монгол орны Онон, Балж, түүний цутгал голуудад тархах боломжтой (Дашдорж нар, 1977; Dulmaa, 1999) гэж тэмдэглэжээ. Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт хамаарах Онон голоос барьсан бодгалийг Г.Баасанжав, Я.Цэнд-Аюуш нар (Баасанжав, Цэнд-Аюуш, 2001) *Huso dauricus* байх магадлалтай гэж үзсэн (Kottelat, 2006).

Таних шинж. Бие урт, ээрүүл хэлбэртэй. Биеийн урт 2.9 м, жин 200 кг (Берг, 1948) боловч ихэнхдээ 1.7 м урт, жин 40 кг (Решетникова, 2003). Хошуу урт, хурц. Ам толгойн доод хэсэгт байрлана. Доод уруул сэтэрхий. Толгойн доод талд хөндлөн эгнээ бүхий 4 сахалтай. Нурууг дагасан нэг эгнээ, биеийн хоёр тал, хэвлийг дагасан хоёр эгнээ бүгд 5 эгнээ ясажсан товхтой. Нурууны товхны тоо цөөн буюу 11-17 (Дашдорж нар, 1970). Заламгайн өргөс дэвүүр шиг биш, гөлгөр, ганц нарийн үзүүрээр төгсөнө. Сүүлний сэлүүрийн дээд далбан нь доод далбангаасаа урт.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж байгаа (CR), A2bd. XIX зууны сүүл үеэс дэлхийн хэмжээнд загас агнуурын нөлөөгөөр тоо толгой нь буурсаар байгаа бөгөөд сүүлийн 115 жилийн хугацаанд популяцийн хэмжээ 95%-аар буурсан тул Устаж байгаа гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock et al., 2006). 2025 онд Устаж байгаа (CR), A2bd; B2ab (ii,iii,v). Бүс нутгийн популяцийн хэмжээ тодорхойгүй. Тархац нутгийн хэмжээ 10 км²-аас ихгүй. Оросоос нүүдэллэн ирэх популяци

буурсан ч тус бүс нутгийн популяци нь “Дагавар” популяци биш гэж тодорхойлсон (Осcock et al., 2006). Монголд 1976 оноос хойш тэмдэглэгдээгүй (М.Эрдэнэбат, аман мэдээ) байсан бол 2018 онд Онон голын адаг орчим ажиглагджээ (Mark, аман мэдээ). Энэ зүйлийн судалгаа сүүлийн 50 гаруй жилд хийгдээгүй тул Устсан зэрэглэлээр үнэлэх боломжгүй, мөн Орос-Монголын хил орчим Соходинскийн дархан цаазат газарт Онон голоос 2003 болон 2007 онд тэмдэглэгдсэн (Antonov et al., 2019) бөгөөд нүүдэллэн ирэх боломжтой тул энэ зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Орос, Хятадын Амар мөрний сав газар, Шилк, Аргун, Сунгур, Уссур гол, Ханх нуур болон Онон гол (Берг, 1948; Никольский, 1956), мөн Сахалины эргээр тархсан (Решетникова, 2003).

Монгол орны тархац, амьдрах орчин. Номхон далайн ай савын Онон голын адаг орчим. Тогтмол урсгалтай голын (5.1) элс, лаг шавартай гүн хэсэг, цутгал голуудын бэлчир (5.13) бараадан амьдарна.

Амьдралын онцлог. Атуух (эрэгчин) 8-10, атуу (эмэгчин) 11-14 насанд үржилд орно. 4-р сарын сүүлчээр усны температур 6-7°C хүрэхэд гол төлөв 5-р сарын сүүлчээс 7-р сарын дунд хүртэл голын ширүүн урсгалтай, 2-3 м гүнтэй хэсгийн хайрга чулуунд дунджаар 27,600-434,000 түрс гаргана (Расса, 1983). Жараахай 2 см хүрэхэд ёроолын жижиг амьтдаар, гол төлөв жингэнүүр ялааны авгалдайгаар, бие гүйцсэн загас усны



ёроолын шавжийн авгалдай, гүрц, морин загасны жараахай болон зөөлөн биетнээр хооллоно (Никольский, 1956).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн хэмжээнд агнуурын үнэтэй загасны тоонд орох бөгөөд Амар мөрний сав газарт XIX зууны үед 6000 ц, 1930-аад оны үед 140-300 ц, 1945 онд эрчимтэй агнуур, хууль бус загасчлалын нөлөөгөөр тоо толгой нь 8 ц хүрч буурч байжээ. 1958 онд Амар мөрний сав газарт агнуурыг бүрмөсөн хориглох арга хэмжээ авсны дүнд 1970-аад оноос Амар мөрний доод хэсэгт бие гүйцсэн 3000 бодгаль тэмдэглэгджээ (Крыхтин, 1979). Орост агнахыг хуулиар хориглосон ч Хятадын нутаг дэвсгэрт хууль бусаар агнасаар байна (Решетникова, 2003). Монгол орны популяцийн хэмжээ тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийг үржлийн үед нь хууль бусаар (1.3.2) болон хууль бус арга, хэрэгслээр (4.1.1.2) агнаснаар хүний шууд нөлөөнд өртөж (10), тоо толгой нь буурч байна. Дэлхийн дулаарлаас (6.1.1.) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), ихсэлт (7.2), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), хожуу бэлгэ боловсордог, нөхөн төлжилт муу (9.2) зэрэг хүчин зүйлс, өсвөр насны бодгалиуд нь махчин загасны идэш болох (8.2), тоо толгойн хэлбэлзэл ихтэй (9.8), залуу бодгалиудын үхэл хорогдол их (9.3) зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар орсон бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний зориулалтаар

агнаж, барьж болно. Мөн загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын хилэм 1,200,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Монгол Улсын Улаан ном (2013)-д нэн ховор зүйлээр бүртгэгдсэн. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралт, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын II хавсралтад тус тус бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; UN Environmental Programme - World Conservation Monitoring Centre, 2017).

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

2.2. ШИВЭР ХИЛЭМ


Acipenser baerii (Brandt, 1869)

Баг: Хилэм (Acipenseriformes)

Овог: Хилэм (Acipenseridae)

Англи нэр: Siberian sturgeon

Ижил нэр: *Acipenser baeri*, *Acipenser stenorrhynchus*, *Acipenser stenorrhynchus* var. *baikalensis*, *Acipenser baerii chatys*.



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийн 4 салбар зүйл *Acipenser baeri baeri* (Обь болон Иртыш мөрний сав), *Acipenser stenorrhynchus* (Енисей мөрнөөс Анабар мөрний сав), *Acipenser baerii baikalensis* (Байгаль нуурын саваас Енисей мөрөн), *Acipenser baerii chatys* (Лена мөрнөөс Колум мөрний сав) байдаг (Решетников и др., 1997).


Таних шинж. Бие урт, ээрүүл хэлбэртэй. Биеийн урт 2 м, жин 65 кг-аас хэтэрдэггүй ч заримдаа 201 кг хүрнэ (Атлас пресноводных рыб России, 2003). Дэлгэрмөрөнд 1.4-1.5 м урт, 36 кг жинтэй бодгалийг тэмдэглэсэн (Дашдорж нар, 1970; 1976). Нурууг дагасан нэг эгнээ, биеийн хоёр тал, хэвлийг дагасан хоёр эгнээ бүгд 5 эгнээ ясажсан товхтой. Нурууны товхны тоо 32-47. Заламгайн өргөс нь дэвүүр хэлбэртэй ба үзүүр нь булцуулаг байдгаараа ялгагддаг. Хошууны доор байрлах саран хэлбэрийн амтай. Доод уруул нь сэтэрхий. Толгойн доод талд 4 сахалтай, сахал нь маш жижиг цацагтай (Дашдорж нар, 1970). Сүүлний сэлүүрийн дээд далбан нь доод далбангаасаа урт.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж байгаа (CR), A2bd (IUCN, 2023). Ази тивд хамгийн өргөн тархалттай хилэм бөгөөд сүүлийн 100-164 жилийн хугацаанд тоо толгой нь огцом буурсан. Дэлхийн хойд хагаст бодгалиуд хожуу бие гүйцдэг, түрс шахалт хоорондын зай хол болон үр төлөрхөг байдал багатай ээргээс шалтгаалан популяцийн нөхөн төлжилт удаан. Сүүлийн жилүүдэд хулгайн ан, далан, барилга болон усны бохирдлоос хамааран үржлийн амжилт улам буурсаар байгаа бөгөөд цаашид ч буурах хандлагатай (IUCN, 2024).

Бус нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж байгаа (CR) B2ab (iii,v) (Осcock *et al.*, 2006).

2025 онд Устаж байгаа (CR), B2ab (iii,v). Монгол орны популяцийн хэмжээ тодорхойгүй. Тохиолдох нутаг дэвсгэрийн хэмжээ 10 км²-аас бага гэж үзсэн. Монголд түрсээ шахах багахан газарт нь хууль бус агнуур их байгаа нь цөөрөх үндсэн шалтгаан болно. Их хэмжээний хууль бус загасчлал, ялангуяа үржлийн насны бодгалийг хулгайгаар агнаж байгаа нь тоо толгойг



цөөрөхөд хүргэнэ. Дэлхийн дулаарал болон хүний үйл ажиллагаанаас хамааран амьдрах орчин хумигдан, үржлийн нутаг нь доройтож буй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Орост Обь мөрнөөс Колым хүртэлх голууд, Енисей мөрөн, Зайсан, Байгаль нуурт тархсан (Берг, 1948; Sokolov *et al.*, 1989; Kottelat, 2006). Тархалтын өмнөд хил нь Казакстан, Монголын Сэлэнгэ мөрөн болно (Решетникова, 2003).

Монгол орны тархац, амьдрах орчин. Дэлгэрмөрөн, Орхон, Туул, Сэлэнгэ мөрөнд тархсан (Хойд мөсөн далайн ай сав) (Дашдорж нар, 1970; 1977; Дгебуадзе, 1986; Аюушсүрэн нар, 2024), Идэр голын адагт тэмдэглэгдсэн (Мэндсайхан нар, 2017). Тогтмол урсгалтай голын (5.1) элс, лаг шавартай гүн хэсэг, цутгал голуудын бэлчир (5.13), мөн цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Атуух (эрэгчин) 10-12, атуу (эмэгчин) нь 12-14 насанд үржилд орно. 5-р сарын дундаас 6-р сарын 15 хүртэл

усны хэм +10+15 хүрэхэд хайрга чулуу дээр, чулууны завсар түрсээ шахна.

Тоо толгой, нягтшил. Дэлхий дахинд агнуурын үнэтэй загас. Байгаль нуур, түүний цутгал голуудад XIX зууны хоёрдугаар хагаст жил бүр барих хэмжээ 200-300 тн байжээ. Үржлийн үед загасчлах нь энэ зүйлийн нөөцийг ноцтой сүйтгэж, 1924 онд хэмжээ 3.8 тн болж буурсан. Байгаль нуураас барихыг 1945 оноос өнөөг хүртэл хориглосон (Pronin *et al.*, 1988). Монгол орны популяцийн хэмжээ тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийг үржлийн үед нь хууль бусаар (1.3.2) болон хууль бус арга, хэрэгслээр (4.1.1.2) агнан зах зээлд худалдаалж (3.4.3), барьсан загасаа хил дамнуулдаг (3.1.2) зэрэг хүний шууд нөлөөнд өртөж (10), тоо толгой нь буурч байна (Ганболд, 1999). Дэлхийн дулаарлаас (6.1.1.) шалтгаалсан усны түвшин багасах (7.1), ихсэх (7.2), уул уурхай (1.3.1), хөдөө аж ахуй (6.3.1), усны бохирдлоос (6.3) хамаарсан амьдрах орчны доройтол, алдагдал (I), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), хожуу бэлгэ боловсордог, нөхөн төлжилт муу (9.2) зэрэг хүчин зүйлс, өсвөр насны бодгалиуд нь махчин загасны идэш тэжээл болох (8.2),

өвчин эмгэг үүсгэгчид ба шимэгчдийн нөлөө (8.5), тоо толгойн хэлбэлзэл ихтэй (9.8), залуу бодгалиудын үхэл хорогдол их (9.3) зэргээс шалтгаалан тоо нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 1945 оноос хойш агнахыг хориглосоор иржээ. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон (1.1-ээс харна уу).

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр хилэм 1,590,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг

хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна. Монгол Улсын Улаан ном (2007, 2013)-д нэн ховор зүйлээр бүртгэгдсэн.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай *конвенц (CITES)-ын II хавсралт*, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын II хавсралтад тус тус бүртгэжээ (Чимэддорж нар, 2018; UN Environmental Programme - World Conservation Monitoring Centre, 2017).

Хамгаалах арга хэмжээ. Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн ховор зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.1.2), хэрэгжүүлэх (1.2.2), шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх (1.1.2.), хамгааллын мониторинг хөтөлбөр (3.8, 3.9), арга хэмжээг жигд гүйцэтгэн хангах (4.1), түүний популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), тархац нутаг (3.4), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлд чиглэсэн нөхөн сэргээх менежментийн арга хэмжээг (5.4) зохион байгуулж, зориудын аргаар өсгөвөрлөх (3.7, 5.7.1), бие даан амьдрах чадвартай жараахайгаар байгалийн нөөцийг нөхөн сэргээх (4.2), сэргээн нутагшуулах (5.1), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

2.3. АЛТАЙН ДАВЖАА СУГАС

Oreoleuciscus humilis (Warpachowski, 1889)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Altai's small osman (Dwarf form)

Ижил нэр: *Oreoleuciscus humilis phoxinoides* (Warpachowski, 1889).



Ангилал зүйн тойм. Алтайн давжаа сугас “Нуурын” болон “Голын” гэсэн морфо-экологийн хоёр хэлбэртэй (Соколова, 1985). Хуурай жилүүдэд говийн нууруудын хөндийд “Нуурын” хэлбэр цөөрч, “Голын” хэлбэр нь голдоо үлддэг бол хуртай жилүүдэд нуур усаар дүүрэхэд голын популяци нуурт идээшдэг (Dgebuadze, 1995). Сангийн далай нуур, Тэс гол, Увс нуурт тархдаг (Соколова, 1983) гэх боловч молекул биологийн судалгаагаар, тэдгээрийг *Oreoleuciscus manchin* хэмээх зүйл гэж үзсэн (Слынько и др., 2009). Гэвч энэ зүйлийг олон улсын амьтан судлалын ангилал зүйд хүлээн зөвшөөрдөггүй (Ride, 1999). Мироновский, Слынько нар *Oreoleuciscus manchin* нь морфологи шинжээрээ *Oreoleuciscus humilis* гэх зүйлээс эрс ялгаатай хэмээжээ (Мироновский и др., 2019). Эдгээр загас морфогенезийн хэв шинжийг судлах загвар зүйл юм (Дгебуадзе и др., 1978; Dgebuadze, 1995; Мироновский и др., 2019). Хатаж ширгэсэн нуурууд усаар дүүрэхэд Алтайн давжаа сугасын “Голын” хэлбэр нь нуурт

шилжиж морфологи, амьдралын хэв шинжээ хурдан өөрчлөх чадвартай (Dgebuadze, 1995; Dgebuadze et al., 2020).

Таних шинж. Биеийн урт 20 см орчим ба 17 хүртэл насална. Нуурын хэлбэрийг голынхтой харьцуулахад толгой урт, ам том, доод эрүү дээд эрүүг бодвол бага зэрэг урт. Нуурын хэлбэр нь зөвхөн нуурт амьдрах ба биеийн урт 50 см хүрнэ.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023). Дэлхийд популяцийн чиг хандлага тодорхойгүй, түгээмэл тархалттай тул энэ зэрэглэлээр үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд: Эмзэг (VU), B2ab (ii,iii,iv,v) (Осcock et al., 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), B2ab (ii,iii,iv,v). Тархац нутгийн хэмжээ 2,000 км²-аас бага. Хуурай жилүүдэд зарим нуурууд хатаж ширгэх үед нуурын популяци бүхэлдээ хорогдох, түрс шахдаг голууд нь хатаж үржлийн талбай хомсдох, амьдрах орчин

доройтох зэрэг уур амьсгалын өөрчлөлт болон бусад хүчин зүйлсийн улмаас популяцийн 50 орчим хувь нь устах аюул нүүрлэсэн жижиг популяци юм. Түүнчлэн Хойд мөсөн далайн ай савын Чулуутын голоос шивэр хадран, шөвгөр хоншоорт зэвгийг Заг, Байдрагийн голд нутагшуулснаас амьдрах орчин, идэш тэжээлийн өрсөлдөөнд орох болсон учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Монгол орны унаган зүйл бөгөөд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Нууруудын хөндийн нуур, голуудад тархсан (Соколова, 1985; Dgebuadze, 1995; Баасанжав нар, 2001).

Монгол орны тархац, амьдрах орчин. Нууруудын хөндийн Бөөн Цагаан, Орог, Таацын Цагаан, Улаан нуур болон Байдраг, Заг, Онги, Таац, Түйн голд тархсан (Мэндсайхан нар, 2017). Тогтмол урсгалтай голын (5.1) тогтуун урсгалтай хэсэг, эрэг доогуур, улирлын чанартай байнгын бус гол (5.2), байнгын цэнгэг уст нуур (5.5), байнгын бус цэнгэг уст нуур (5.6), шорвог нуур (5.14), улирлын чанартай байнгын бус давсархаг

нуурын (5.15) эрэг орчмын гүехэн хэсгээр амьдарна. Хуурайшилт ихтэй жилүүдэд нуур хатаж ширгэвэл голыг шүтэж амьдарна (Мэндсайхан нар, 2019).

Амьдралын онцлог. Энэ зүйл 6-7 насандаа бие гүйцэж, үржилд орно. 6-р сарын сүүлчээс 8-р сарын эх хүртэл нуур, голын гүехэн хэсэгт үржинэ. Хэсэгчлэн 2,400-12,200 орчим түрс шахна. Түрс нь наалдамхай учир ургамал, ёроолын хурдсанд бэхлэгдэнэ. Голын хэлбэр нь усны ёроолын шавжийн авгалдай, хөвөгч амьтад болон замгаар хооллоно (Мэндсайхан, 2010). Нуурын хэлбэр нь 33,720-105,300 орчим түрс шахна. Нуурын хэлбэрийн биеийн урт нь голчлон 18 см хүрэхэд загасаар хооллож эхэлнэ (Мэндсайхан нар, 2017).

Тоо толгой, нягтшил. Дэлхий болон манай орны популяцийн тоо толгой, түүний хандлага тодорхойгүй. Баянхонгор аймгийн Бөөнцагаан нуур нь зөвхөн “Нуурын” популяцийг хадгалан үлдсэн байна. Нуурын 2-12 м гүнд тархан амьдрах загасны байршил, нягтшилыг орчин үеийн зайнаас тандан судлах багажийг ашиглан тооцоолоход, 2-8 м гүнд 0.2-0.8 ш/м², 10-12 м гүнд 0.8-1.1 ш/м² байв (Терещенко и др., 2009).



Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1.) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол (1), түрс шахах талбайн хэмжээ бага, тархалт хязгаарлагдмал (9.1), нөхөн сэргэлт, үржил муу (9.2), залуу бодгалиудын үхэл хорогдол их (9.3), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), нягтшил бага (9.5), өсөлтийн эрчим бага (9.7), тоо толгойн хэлбэлзэл ихтэй (9.8), өвчин эмгэг үүсгэгчид ба шимэгчдэд өртөмтгий (8.5), унаган зүйл загасны тархац нутагт харь зүйл загасыг нутагшуулсан (2) нь идэш тэжээлийн өрсөлдөөнд орох, түрэмгийлэл зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.7-д зааснаар Алтайн давжаа сугасыг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн,

хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Алтайн давжаа сугас 4,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад харь зүйлийн түрэмгийлэл (2), идэш тэжээлийн өрсөлдөөн (2.1), махчин загасны золиос болох (2.2), эмгэг үүсгэгч шимэгчид (2.4), ангилал зүй (3.1), түүний популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

2.4. АМАРЫН ХАДРАН

Thymallus grubii (Dybowski, 1869)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хадран (Thymallidae)

Англи нэр: Amur grayling

Ижил нэр: *Thymallus arcticus grubei*, *Thymallus burejensis*.



Ангилал зүйн тойм. Амар мөрний савд “Дээд-Амарын”, “Шар толбот” *Thymallus burejensis* (том хайрстай хэлбэр) болон *Th. sp.* (Доод-Амарын хэлбэр) гэсэн 3 хэлбэрийг тэмдэглэсэн (Книжин и др., 2004). Онон болон Ингода голоос барьсан “Дээд-Амарын” хэлбэрийг Амарын хадранд багтааж ангилсан. “Дээд-Амарын” болон “Шар толбот” нь аллопатрик үүсэлтэй ба хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай. Эдгээрийг гарал үүсэл өөр, зүйлийн эволюцийн болон филогенетик үзэл баримтлалаар бие даасан зүйлийн шалгуурыг хангасан (Kottelat, 2006) хэмээн тэмдэглэжээ.

Таних шинж. Биеийн урт 31.3 см. Нурууны сэлүүр урт. Нурууны сэлүүрийн захаар хүрэн улаан жижиг толботой. Бие нягт, дунд зэргийн хайрсаар хучигдсан (Дашдорж нар, 1970). Дээд эрүүний урт нүдний дунд хүртэл үргэлжилнэ (Книжин и др., 2004). Өөхөн сэлүүр цайвар ягаан. Сүүлний сэлүүр улбар хүрэн.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NE) (IUCN, 2023).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), B2ab (iii,v) (Осcock *et al.*, 2006).


2025 онд Устаж болзошгүй (EN), B2ab (iii,v). Монгол орны популяцийн хэмжээ тодорхойгүй. Түрс шахах газрын хэмжээ 100 км²-аас бага. Дэлхийн дулаарлын нөлөөгөөр усны түвшний хэлбэлзлээс шалтгаалан амьдрах орчин нь доройтож, түрс шахах талбай нь хомсдож, хууль бус загасчлалын улмаас тоо толгой нь тасралтгүй буурч байгаа тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Монгол орны зүүн хэсэг, Оросын Алс дорнод, Хятадын хойд хэсгийн Амар мөрний сав газраар тархсан (Kottelat, 2006; Bogutskaya *et al.*, 2008).

Монгол орны тархац, амьдрах орчин. Онон, Хэрлэн, Халх голын сав газраар тархсан (Дашдорж нар, 1970, 1977; Дгебуадзе, 1986; Аюушсүрэн нар, 2024; Баасанжав нар, 2001). Тогтмол урсгалтай голын (5.1) хүчилтөрөгчийн хангамж хамгийн ихтэй харгиа бүхий чулуутай хэсгээр, мөн цэнгэг уст нуурт (5.5) амьдарна. Голын хамгийн гүн хэсэгт өвөлжинө.



Амьдралын онцлог. Биеийн урт 31.3 см хүрнэ. Үржил 4-р сарын сүүлчээс усны хэм $+2.3+8.5^{\circ}\text{C}$ хүрэхэд сүрэглэж, гол өгсөн хайрга, чулууны завсар түрсээ шахна. Холимог идэштэй. Багшраа ялааны авгалдай, шаймий хавч, зөөлөн биетэн, өдөрч, хаварч зэрэг усны ёроолын шавжийн авгалдайгаар хооллохоос гадна (Никольский, 1956), хуурай газрын шавж, ялангуяа далавчилсан шоргоолжийг иднэ (Баасанжав, 1979).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн тоо толгой, түүний хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Үржлийн үед хууль бусаар (1.3.2), ахуйн зориулалтаар (3.1.1), хууль бус арга, хэрэгслээр (4.1.1.2) агнаснаас хүний шууд нөлөөнд өртөн (10) тоо толгой нь буурч байна. Дэлхийн дулаарлаас (6.1.1.) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), өсвөр насны бодгалиуд нь махчин загасны идэш болох (8.2), өвчин эмгэг үүсгэгчид ба шимэгчид (8.5) зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрсөн.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах

(10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын хадран загас 11,900 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад түүний ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

2.5. ГОВИЙН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula dgebuadzei (Prokofiev, 2003)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Dgebuadzei's stone loach

Ижил нэр: *Orthrias dgebuadzei*, *Barbatula dgebuadzei*.



Ангилал зүйн тойм. Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Нууруудын хөндийн Заг голоос анх тэмдэглэгдсэн (Prokofiev, 2003). Нууруудын хөндийн нуур, голуудаас *Barbatula dgebuadzei* хэмээн тэмдэглэсэн зүйлийг *Barbatula toni* гэж нэрлэсэн нь бий (Dgebuadze, 1995).

Таних шинж. Биеийн урт нь 10-14 см, жин нь 15-20 г. Бие нь урт, муна хэлбэртэй. Монхор хошуутай ба өргөн толгойтой. Ам нь доош эргэсэн, гурван хос сахалтай. Сүүлний сэлүүрийн орчим цөөн тооны хайрстай. Нуруу, сүүл, цээжний сэлүүрүүд нь хар толботой. Сүүлний сэлүүрийн ухлаадас үл мэдэг. Бие нь шаргал саарал. Нуруу бор хүрэн, хэвлий хэсэг цайвар. Биеийн хоёр хажуугаар том, жижиг янз бүрийн хэлбэртэй хар толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA) (IUCN, 2023).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), B2ab (iii) (Осcock et al., 2006). 2025 онд Устаж болзошгүй (EN) B2ab (iii). Тархац нутгийн хэмжээ 100 км² орчим. Хуурай


жилүүдэд Нууруудын хөндийн нуурууд ширгэх үед нуурын популяци бүхэлдээ хорогдон, усны түвшний хэлбэлзлээс түрс шахдаг голууд нь хатаж үржлийн орчин хумигддаг, харьцангуй жижиг популяциас бүрдэх зүйл юм. Хойд мөсөн далайн ай сав Чулуутын голоос шивэр хадран, шөвгөр хоншоорт зэвэг загасыг Заг, Байдрагийн голд нутагшуулснаас энэ зүйлийн залуу загаснуудад амьдрах орчин, идэш тэжээлийн өрсөлдөөн нэмэгдэж буй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Монгол орны Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Нууруудын хөндийн нуур, голуудад тархсан (Prokofiev, 2003).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хөх нуураас эх авах Нуурын гол, Заг, Байдраг, Онгийн голд тархана. Тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. 5-р сард голд үржих ба хатуу хайрга чулуун хурдсанд түрсээ шахна. Усны ёроолын сээр нуруугүйтэн голчлон шавжийн авгалдайгаар хооллоно. Ёроолын амьдралтай, махчин загасны идэш тэжээлд зонхилох үүрэг гүйцэтгэдэг агнуурын бус загас.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон манай орны популяцийн тоо толгой, түүний хандлагын талаарх мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүний үйл ажиллагаанаас улбаатай амьдрах орчны алдагдал, доройтол (1), дэд бүтцийн хөгжил (1.4), далан, суваг шуудуу, зам барилгын ажлууд (4.1.6) болон усны бохирдол (6.3) алт олборлолтоос (6.3.7) гаралтай усны бохирдол болон уугуул зүйлийн динамик өөрчлөлт (8), золиос, идэш тэжээл (8.3) зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Говийн сахалт эрээлж загас 2,600 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Их Богд уулын байгалийн цогцолборт газар, Заг-Байдраг голын сав газрын эх Биндэръяа Хөх нуурын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад түүний ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул занал (3.5), ялангуяа тухайн популяцид үзүүлэх харь зүйлийн судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй. Амьдрах орчин ба тухайлсан газарт чиглэсэн үйл ажиллагааг (4) хэрэгжүүлэх үүднээс бүс нутгийн хэмжээнд орон нутгийн хамгаалалтад авах газруудыг тогтоож (4.4.1), хамгааллын менежментийг хэрэгжүүлэх (4.4.3) хэрэгтэй.

2.6. ДАРХАДЫН ЦАГААН ЗАГАС

Coregonus pidschian (Gmelin, 1788)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Цагаасар (Coregonidae)

Англи нэр: Humpback whitefish, Bottom whitefish, Pidschian, Arctic whitefish

Ижил нэр: *Salmo pidschian*, *Salmo polcur*, *Coregonus sikus*, *Coregonus baicalensis*, *Coregonus smitti*, *Coregonus fluviatilis*, *Coregonus fera forma inarensis*, *Coregonus lavaretus pidschian natio bargusini* (Kottelat, 2006), *Coregonus lavaretus pidschian natio delger-muren*, *Coregonus pidschian* (Gmelin, 1788).



Ангилал зүйн тойм. *Coregonus pidschian* нь Байгаль нуураас тэмдэглэгдээгүй, харин Байгаль нуурын цутгал болох Баргузины голд “*natio bargusini*” гэж тэмдэглэгдсэн байдаг (Берг, 1948). Түүнчлэн Лена мөрнөөс *Coregonus pidschian* (*Coregonus lavaretus pidschian*), Байгаль нуураас “*C. l. pidschian natio baicalensis*” тэмдэглэгдсэн (Карасев, 1987)-ийг *C. baicalensis* гэж үзсэн (Bogutskaya et al., 2004). *Coregonus pidschian*-ийг *C. baicalensis* гэж батлахын тулд цаашид судлах шаардлагатай (Kottelat, 2006). Енисей мөрний дээд, дунд хэсгээр тархах “*natio fluviatilis*” нь Дархадын хотгорт тархах цагаан загастай адил хэмээн үздэг (Берг, 1948). Академич А. Дулмаа 1985 онд Оросын Улаан-Үдээс цагаан зарам *Coregonus peled* болон Байгалийн омуль *Coregonus migratoris*-ыг Дархадын хотгорт тавьсан ч *Coregonus migratoris* нь нутагшаагүй (Эрдэнэбат, 2006). Доод Цагаан нуурт нуур, нуур-голын гэсэн гурван бүл

байгаа гэжээ (Дулмаа, 1973). Дархадын хотгорын нууруудын цагаан загасны молекул биологийн судалгаагаар, эволюцийн хоёр шугам зэрэгцэн оршдог ба Енисей мөрнөөс Шишгэд голоор дамжин Доод Цагаан нуурт нүүдэллэн ирсэн. Иссатченкогийн цагаан загас (*C. fluviatilis* Isaczenko, 1925; Енисейн сав газар) нь Сэлэнгэ мөрний савд, түүний тархац нь Ангара-Енисейн сав газраас доод Тунгуск хүртэл үргэлжилдэг (Tuvshinzhargal et al., 2024).

Таних шинж. Бие мөнгөлөг цайвар, хайрс том, элдэв толбогүй. Нуруу бөгтөр. Бие хажуугаасаа хавчгар, жижиг амтай. Хошуу монхор, дээд эрүү нь доод эрүүг үл ялиг давсан. Өөхөн сэлүүр харьцангуй том. Заламгайн өргөс цөөн (15-30).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2023). Тархац нутгийнхаа болон

манай орны түвшинд буурч байж болзошгүй. Гэвч дэлхийд түүний популяцийн болон тархац нутгийн хэмжээ асар том хэвээр байна. Тиймээс Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлжээ.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), B2ab (iii,v) (Осcock *et al.*, 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), B2ab (iii,v). Тархац нутаг 500 км² талбайгаас бага. Дархадын хотгорын нууруудад өрнөж буй эрчимтэй агнуурын нөлөөгөөр нөөц нь багассан тул агнуурыг зогсоох хэмжээнд хүрсэн. Нутагшуулсан цагаан зарам *Coregonus peled* загастай үржлийн талбай, идэш тэжээлийн өрсөлдөөнд орохоос гадна, энэ хоёр зүйл хоорондоо эрлийзждэг (Эрдэнэбат, 1998) учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Хойд мөсөн далайн ай сав Финляндаас зүүн Сибирь, Аляск, Канадаас зүүн Маскензийн сав газар хүртэл тархсан (Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Дархадын хотгорын нуурууд, Доод Цагаан нуур, Идэр, Сэлэнгэ мөрөн, Тэнгис, Үүр, Хөг, Чулуут, Шарга, Шишхэд, Эгийн гол

зэрэг тогтмол урсгалтай голын (5.1) зөөлөн урсгалт хэсгээр, томоохон цэнгэг уст нуурт (5.5) тархан амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 66 см, 3.5 кг. 5-7 насандаа биеийн урт 38 см хүрэхэд бэлэг боловсорч, үржилд орно. Доод Цагаан нуурт нуурын болон гол-нуурын гэсэн хоёр бүл үүсгэнэ (Дулмаа, 1973). Нуурын цагаан загасны бүл 8-р сарын дундаас ус 12-18 хэм байхад 1.5-3.0 м гүнд, нуур-голын цагаан загасны бүл намар 10-р сарын эхээр ус 3 хэмийн дулаанаас -0.8 хэм болоход 2-4 м гүнд элс, хайрга чулуун дээр сүрэглэн түрсээ шахна. Хөврөлийн хөгжил мөсөн доор усны температур 0.8-3°C-д 256-284 хоног үргэлжилнэ. Атуу дунджаар 8,000-33,300 түрс гаргана (Dulmaa *et al.*, 1983).

Тоо толгой, нягтшил. Хөвсгөл аймгийн Цагаан нуур суманд 1942 оноос энэ зүйл загасыг үйлдвэрлэлийн зориулалтаар барьж эхэлсэн бөгөөд 1956 онд “Загасны үйлдвэр” байгуулагдаж, улмаар 1956-1960 онд 118.6 тн, 1961-1964 онд 125.4 тн (Дулмаа, 1967), 1966-1970 онд 165.2 тн, 1971-1975 онд 86.8 тн, 1976-1980 онд 119.3 тн, 1981-1985 онд 106.6 тн, 1986-1990 онд 75.5 тн, 1991-1995 онд 15.1 тн загасыг Дархадын хотгорын томоохон нуур, голуудаас агнаж байжээ (Дашдорж, 2005). Мөн 1992 онд 8.2 тн, 1993 онд 16 тн, 1994 онд 32.5 тн, 1995 онд 20.5 тн загас агнажээ (Эрдэнэбат, 2006). Ийнхүү



загасыг үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан 60 жилд агнуурын загасны хэмжээ нь “Загасны үйлдвэр” байсан үеийнхээс 4.3-7.4 дахин бага болсон (Мэндсайхан нар, 2017; Мэндсайхан нар, 2013).

Ховордлын шалтгаан. Цагаан загасыг олон улсын зах зээлд худалдаалдаг (3.4.3). Үржлийн үед эрчимтэй агнаснаас (1.3.2) нөөц нь эрс багассан (Мэндсайхан нар, 2017). Зах зээлийн эдийн засагт шилжиж, загасны аж ахуйн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, өмчийн хэлбэр өөрчлөгдөн хувийн хэвшилд шилжсэнээр загас агнуур зохицуулалтгүй болж хүний шууд нөлөөгөөр (10) тоо толгой нь буурсан. Мах нь таваарлаг чанар сайтай учир ахуйн хэрэглээнд (1.3.2.1) хэрэглэхээс гадна, түүний өөх, цөс нь морины ханиалгад сайн хэмээж уламжлалт анагаах ухаанд (3.2) хэрэглэдэг. Сүүлийн 10-аад жилд тураг гогой (8.3) зуны улиралд маш олноороо сүрэлгэн ирж байгаагаас өсвөр насны загас ихээр өртөж (9.3), түүний нөөцөд сөргөөр нөлөөлөх болсон. Дэлхийн дулаарлаас (6.1.1.) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, бохирдол (1), хөврөлийн хөгжил нь өвөл мөсөн дор урт хугацаагаар явагддаг тул нөхөн сэргэлт, үржил муу (9.2), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), өвчин эмгэг үүсгэгчид ба шимэгчдийн нөлөө (8.5), нутагшуулсан цагаан зарам загастай үржлийн талбай, идэш тэжээлийн өрсөлдөөнд орохоос гадна, энэ хоёр зүйлийн хооронд эрлийзжил явагдаж байгаа (Эрдэнэбат, 1998) зэргээс шалтгаалан энэ зүйлийн тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3-д дархадын цагаан загасыг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр дархадын цагаан загас 30,300 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Доод Цагаан нуурын нөөц хомсдож байгааг харгалзан Хөвсгөл аймгийн ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны тогтоолоор 1990 онд 5 жилээр үйлдвэрлэлийн зориулалтаар загас агнахыг хориглож (Эрдэнэбат, 2006) байжээ. Одоо зөвхөн ахуйн зориулалтаар зөвшөөрөл олгодог байна. Европын зэрлэг амьтан болон Байгалийн унаган идээшил нутгийг хамгаалах конвенц (Bern Convention)-ын III хавсралтад бүртгэгдсэн.

Хамгаалах арга хэмжээ. Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.1.2), хэрэгжүүлэх (1.2.2), шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад ангилал зүй (3.1), түүний популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлд чиглэж зориудын аргаар үржүүлэх (5.7), бие даан амьдрах чадвартай жараахайгаар байгалийн нөөцийг нөхөн сэргээх (4.2), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

2.7. ЕРДИЙН ТУЛ

Hucho Taimen (Pallas, 1773)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хулд (Salmonidae)

Англи нэр: Siberian taimen

Ижил нэр: *Hucho hucho taimen*, *Salmo taimen*, *Salmo fluviatilis*, *Salmo lossos*, *Salvelinus taimen*, *Hucho taimen*.



Ангилал зүйн тойм. Хойд Азид өргөн тархсан ба ялгаатай савд тохиолдох энэ зүйлд генетик ялгаа бага хөгжсөн (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 2.05 м (Баасанжав нар, 2001) хүрэх ч ерөнхийдөө 1.8 м, жин 45 кг. Дээд эрүү урт ба нүднээс хойш давсан харагдана. Толгой дээрээ жижиг дугуй бараан толботой, биеийн гадаргуудаа “х” хэлбэртэй хагас сар мэт хар бараан толботой. Хайрс жижиг. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Самалдаг, тагнайд хүчирхэг шүдтэй. Үржлийн үед атуух (эр) загасны сүв болон сүүлний сэлүүрүүд тод улаан болно.

Үнэлгээ ба үндэслэл


Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU), A2bcd (IUCN, 2023). Түүхэн тархац нутаг нь Орост 83.8%, Хятадад 6.4%, Казакстанд 6.1%, Монголд 3.7%-аар тус тус буурсан учир Эмзэг гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), A2de A3de B2ab (iii, v) (Oscock et al., 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), A2de, A3de, B2ab (iii,v). Тархалт нь 1985 оноос хойш 60%-аар (21 жил эсвэл 3 үе удам) буурсан (Oscock et al., 2006). Монгол орны хэмжээнд алт олборлолтоор голын голдирлыг өөрчлөх, механик бохирдол, хүн амын төвлөрлөөс үүдэлтэй органик бохирдлын улмаас амьдрах орчин нь 19.1%-аар алдагдсан (В шалгуур), үржлийн үе дэх хууль бус агналт, загас агнуурын дарамтаас үүдэн (А шалгуур) сүүлийн 3 үе удамд популяцийн тоо хэмжээ 50%-аар буурна хэмээн таамагласан (IUCN, 2024). Тархац нутгийн хэмжээ 500 км² хүрэхгүй, 2-3 жил өнжиж үржилд ордог учир популяцийн нөхөн төлжилт удаан, урт насалдаг учир хууль бус агнуурт өртөх нь их, бариад-буцааж тавих аргыг хэрэгжүүлэхгүй байгаагийн улмаас бодгалийн тоо тасралтгүй буурсан, мөн дэлхийн дулаарал Монгол оронд сүүлийн жилүүдэд эрчимжиж байгаа зэргийг харгалзан үзэж цэнгэг усны энэ зүйлийг дээрх зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, С.Пүрэвдорж (2025).

Үнэлгээг хянасан: П.Цогтсайхан, С.Гомбобаатар (2025).



Дэлхийн тархац. Сибирийн бүх голууд Обь мөрнөөс Лена мөрний сав газар, Байгаль нуурын сав (Орос), Агнуурын тэнгисийн сав газраас Амар мөрний савд (Орос, Монгол, Хятад), Печора голын баруун цутгал голууд (Орос), Кама мөрөн (Казакстан, Орос) хүртэл тархсан (Kottelat, 2006; Решетникова, 2003).

Монгол орны тархац, амьдрах орчин. Доод Цагаан нуур, Дэлгэрмөрөн, Ерөө, Идэр, Орхон, Сэлэнгэ, Суман, Тамир болон Туул голын эх, Тэрхийн цагаан нуур, Тэнгис, Үүр, Хөг, Чулуут, Шишхэд, Эг, Агац болон Балж гол, Буйр нуур, Нөмрөг, Онон, Халх, Хэрлэн, Хяраа голд тархсан. Тогтмол урсгалтай голын (5.1) хүчилтөрөгчөөр баялаг гүнзгий хэсэг, голын тохойрсон болон хадан хясаа, эгц эрэг бүхий цүнхээл, гүнзгий булан тохой, цутгал голуудын бэлчир (5.13), цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Усны температур 5-р сарын дундаас 10°C болоход голоо өгсөн ширүүн урсгалтай хайрга чулуун ёроол бүхий хэсэгт хос үүсгэн үрждэг (Manu et al., 2009). Үржлийн хосууд 0.5-1.0 м гүнд 1.0-1.5 м диаметртэй, 20-30 см гүнтэй үүр ухан түрсээ шахна (Matveyev et al., 1998). 2-3 жил өнжиж үржилд орно (Цогтсайхан, 2020). Атуу дунджаар 8,500-30,000 түрс гаргана.

Хөврөлийн хөгжил нь усны температураас хамааран 28-38 хоног үргэлжилнэ (Кифа, 1974). Алс хол нүүдэллэдэггүй суурин загас (Gilroy et al., 2010; Andrew et al., 2016). Жараахай усны элдэв сээр нуруугүйтэн амьтдаар хооллож байгаад биеийн урт 2.5 см хүрэхэд загасны жарамгайгаар хооллоно (Эрдэнэбат нар, 1996). Махчин загас бөгөөд хуурай газрын жижиг хөхтөн, шувуу, загасаар хооллоно.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой тогтмол буурах хандлагатай байна (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, түүний хандлагын талаар мэдээлэл хомс. Хөвсгөл аймгийн Дархадын хотгорын Доод нуурын загасны үйлдвэрийн 1956-1964 оны загас барилтын баримтаас харахад, нийт барьсан загасны 8.3%-ийг ердийн тул эзэлж байжээ (Дулмаа нар, 1977). Дархадын хотгорт дээд хэмжээ нь 1962 онд 14.7 тн, хамгийн бага нь 1964 онд 6.3 тн-ыг үйлдвэрлэлийн зориулалтаар барьж байв (Дулмаа нар, 1977). Төлөвлөгөөт эдийн засгийн үед Буйр нуурын загасны аж ахуй нь жилд 207 тн загас агнаж байсан ба 1954-1964 онд нийт олборлосон загасны 2%-ийг тул, 1970-аад оны үед ердийн тул болон шөвгөр хоншоорт зэвэг загас нийлээд 2.5%-ийг эзэлж байсан бол 1980-аад оноос тул баригдахаа больсон

(Дулмаа нар, 1977). 2009 оны судалгаагаар, Шишхэдийн сав газрын усан орчны экосистемийн өөрчлөлт, хууль бус агнуурын нөлөөгөөр тулын сүргийн бүтэц өөрчлөгдөж, тоо толгой нь буурчээ (Эрдэнэбат, 2010). Монголд энэ зүйлийн тоо толгойг анх удаа популяци харьцангуй хэвийн, хүний нөлөөнд бага өртсөн Хөвсгөл аймгийн Эг-Үүр голын сав газарт 120 км талбайд дахин барилтын аргаар тогтооход, 1 км-т 19 бодгаль оногдож байна (Olaf *et al.*, 2009).

Ховордлын шалтгаан. Үржлийн үед хууль бусаар (1.3.2), хууль бус арга, хэрэгслээр (4.1.1.2) агнаж, худалдаалах (3.4.3) зэрэг хүний шууд нөлөөгөөр (10) тоо толгой нь буурч байна. Бариад 100% буцаан тавьсан тохиолдолд популяцийн нөхөн дүүргэлт 94%, харин бариад тавихгүй бол 56% болно (Olaf *et al.*, 2009). Дэлхийн дулаарлаас (6.1.1.) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), ихсэлт (7.2), уул уурхай (1.3.1), хөдөө аж ахуйгаас үүдэлтэй (6.3.1) усны бохирдлоос (6.3) хамаарсан амьдрах орчны доройтол, алдагдал (I), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), хожуу бэлгэ боловсордог, нөхөн төлжилт бага (9.2) зэрэг хүчин зүйлс, өвчин эмгэг үүсгэгчид ба шимэгчдийн нөлөө (8.5), урт насалдаг, өсөлт удаан, хууль бус агнуурт (1.3.2) өртөмтгий зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрсөөр байна.

Хамгаалсан байдал. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон. Төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6-д зааснаар зөвхөн нэг салаа сэтгүүртэй, үзүүртээ сэртэнгүй дэгээг ашиглаж, хиймэл өгөөшөөр гэмтээлгүй барьж, усанд нь буцааж тавина. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.6-д зааснаар тул загасыг жил бүрийн 10 дугаар сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд судалгаа, шинжилгээнээс

бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ердийн тул 408,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан. Монгол Улсын Улаан ном (1997, 2007, 2013)-д ховор зүйлээр бүртгэгдсэн.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах (1.1.2.), хамгааллын менежментийг хэрэгжүүлэх (1.2.2.2), мониторинг хөтөлбөрийг (3.8, 3.9) жигд гүйцэтгэх (4.1), түүний популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), тархац нутаг (3.4), амьдрах орчин (3.4), аюул заналыг (3.5) тодорхойлох, биологи, экологи, шилжилт хөдөлгөөний судалгааг (3.3) олон улсын эрдэмтэдтэй хамтран гүйцэтгэх (1.2.1.1), хамтын ажиллагааг өргөжүүлэх (1.2.2.1) нь чухал байна. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

Мөн амьдрах орчин ба тухайлсан газарт чиглэсэн үйл ажиллагааг (4) хэрэгжүүлэх үүднээс агнуурын бүс нутгийг тогтоон менежмент хариуцагчтай болгож чадавхжуулах (2.3), орон нутгийн хамгаалалтад авах газруудыг тогтоож (4.4.1) хамгааллын менежментийг сайжруулах (4.4.3), үржлийн үед нь хянах тогтолцоог бий болгох, олон нийтийн дунд бариад-буцаан тавих аргыг сурталчлах, сургалт явуулах (2), мэдлэг олгох (2.2) арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх нэн шаардлагатай.

2.8. ЗҮҮНГАРЫН СУГАС

Leuciscus dzungaricus (Koch & Paepke, 1998)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Dzungarian dace

Ижил нэр: *Leuciscus dzungaricus* (Koch et Paepke, 1998), *Leuciscus leuciscus dzungaricus* (Koch et Paepke, 1998).



Ангилал зүйн тойм. Монгол-Хятадын хилийн дагуу Булган голд тархсан. Анхдагч заламгайн нуман дахь заламгайн өргөсний тоо нь Сэлэнгэ мөрний шивэр сугаснаас (*Leuciscus baicalensis*) олон (Koch et al., 1998). Энэ зүйл нь 7-11 заламгайн өргөстэй (Митрофнов, 2000). Өлөнгөр гол, Эрчис мөрнөөс барьсан *L. baicalensis* нь 9-12 заламгайн өргөстэй тул *L. dzungaricus* зүйлээс ялгаатай (Chen, 1998). *Leuciscus dzungaricus* нь тэгш амтай, нурууны яс цөөн гол төлөв 42, цээжний сэлүүрийн гуурс нь шигүү жижигхэн товруутай бол *L. baicalensis* нь дээд эрүү нь бага зэрэг давсан нурууны яс нь 44, цээжний сэлүүрийн гуурс нь шигүү жижигхэн товруугүй, биеийн зарим хэсэг хэмжээгээрээ ялгаатай (Koch et al., 1998). Мөн Өлөнгөр голоос *Leuciscus bergi* тэмдэглэгдсэн (Kimura et al., 1992) бөгөөд *L. dzungaricus* болон *L. baicalensis* хоёроос ялгаатай нь олон заламгайн өргөстэй (22-24). *L. bergi*-ийг урьд нь зөвхөн Казакстаны Иссы-Кул нуурт тэмдэглэж байжээ (Kottelat, 2006).

Таних шинж. Бие мөнгөлөг цайвар, нуруугаараа хөхвөрдүү цайвар. Хошуу богино, нурууны сэлүүр босоо, өндөр. Хос

болон хос бус сэлүүрүүд жигд цайвар. Ам тэгш. Бие нь шивэр сугасныхаас өндөр. Шивэр сугастай харьцуулахад заламгайн өргөс олон (14-17), нурууны нугалам цөөн (ихэвчлэн 42).


Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Мэдээлэл дутмаг (DD). Тархалт, амьдрах орчин, ашиглалт, ховордлын шалтгаан болон хамгааллын талаар үнэлгээнд шаардлагатай мэдээлэл хомс тул энэ зэрэглэлээр үнэлсэн (IUCN, 2024).

Бус нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), B1ab(v); 2ab(v) (Осcock et al., 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), (B1ab(v); B2ab(v)). Монгол орны хэмжээнд зөвхөн нэг л газар тэмдэглэгдсэн. Тархац нутгийн хэмжээ 500 км² хүрэхгүй. Дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшин хэлбэлзсэнээс түрс шахах талбай хомсдож, хууль бус загасчлалын нөлөөгөөр тоо толгой, бие гүйцсэн үржлийн бодгалиуд үргэлжлэн буурах төлөвтэй байна.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).



Үнэлгээ хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хятадын Эрчисийн сав газар, мөн Хятадын Өлөнгөр (Булган) голд тархсан (Kottelat, 2006; Мэндсайхан нар, 2017). Казакстанд тохиолддог эсэх нь тодорхойгүй (Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Булган голын тогтмол урсгалтай хэсэг (5.1), цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 16.2 см (Аюушсүрэн, 2024). Энэ зүйлийн биологи, экологийн талаарх мэдээ баримт хомс (IUCN, 2024).

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгойн талаар мэдээлэл хомс. Дэлхийд популяцийн тоо толгойн чиг хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Манай орны популяцийн тоо толгой, түүний хандлага тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1.) үүдэлтэй усны түвшин багасах (7.1), амьдрах орчин доройтох (1), түрс шахах талбайн хэмжээ (9.1), нягтшил багасах (9.5), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), тоо толгойн хэлбэлзэл их (9.8), харь зүйлийн түрэмгийлэл (8.5) зэргээс шалтгаалан цөөрөх хандлагатай.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Зүүнгарын сугас 3,100 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад ангилал зүй (3.1), түүний популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналыг (3.5) нарийвчлан судлах шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

2.9. ХӨВСГӨЛ ХАДРАН

Thymallus nigrescens (Dorogostaisky 1923)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хадран (Thymallidae)

Англи нэр: Khuvs gul grayling

Ижил нэр: *Thymallus arcticus nigrescens*



Ангилал зүйн тойм. *Thymallus arcticus* зүйлийн хэд хэдэн дэд зүйл бий (Берг, 1948; Решетникова, 2003). Хожим эдгээр дэд зүйлүүдийг (*T. baicalensis*, *T. brevipinnis*, *T. grubii*, *T. mertensii*, *T. pallasii*) бие даасан зүйл хэмээн хүлээн зөвшөөрсөн (Bogutskaya *et al.*, 2004). Байгаль нуурын гүний хадран нь *Thymallus brevipinnis* гэх зүйл гэж үзэх тохиолдол бий (Берг, 1948). Мөн Байгаль нуур болон Сэлэнгэ мөрний хадран дэд зүйл биш бие даасан зүйл (*Thymallus baicalensis*), Байгаль нуурын гүнд амьдрах зүйл нь *Thymallus brevipinnis* гэж үзсэн (Bogutskaya *et al.*, 2004). Байгаль нуурын савын (Сэлэнгэ мөрөн) хадрангийн популяци нь Ангар мөрний сав газар болон Енисей мөрний дунд хэсгийн популяцитай илүү ойр (Bogutskaya *et al.*, 2004). Монгол оронд тархах *T. arcticus*-ийн популяци нь жинхэнэ *T. arcticus* мөн эсэх нь эргэлзээтэй хэвээр (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 48.4 см, жин 420 г (Tsogtsaikhan *et al.*, 2016). Бие сунасан урт, хар, эсвэл хар бараан, толбогүй. Нурууны сэлүүр урт, үзүүр нь хүрэн улаан. Нүд том. Өөхөн сэлүүртэй. Бие маш нягт жижгэвтэр хайрсаар хучигдсан. Толгой уртавтار, дээд

эрүү нүдний голчийн төвд бараг хүрнэ. Эрүүнд шүд сайн хөгжсөн. Заламгайн өргөсний тоо 25-33 (Kirk *et al.*, 2019).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA) (IUCN, 2023).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), B2ab (I,ii,iii,iv,v) (Осочко *et al.*, 2006).

2025: Устаж болзошгүй (EN), B2ab(i,ii,iii,iv,v). Түрс шахах газрын хэмжээ 500 км²-аас бага. Дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл нь түрсээ шахдаг голууд хуурай жилүүдэд хатаж ширгэх, үржлийн талбай багасан амьдрах орчин нь доройтохоос гадна, хууль бус загасчлалын улмаас тоо толгой нь тасралтгүй буурсан тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Монголд Хөвсгөл нуурт тархсан (Дашдорж нар, 1970; Книжин нар, 2004).



Монгол орны тархац, амьдрах орчин. Хөвсгөл нуурт тархсан, унаган зүйл. Энэ нутгийн томоохон цэнгэг уст нуурын (5.5) эрэг, гүнээр, мөн түүнд цутгах тогтмол урсгалтай голын (5.1) харгиа хэсгээр амьдарна.

Амьдралын онцлог. 5-6 насандаа үржилд орно (Дашдорж нар, 1977). Энэ зүйлийн хоёр ялгаатай “бүл” бий гэж үздэг. Эхний бүл нь 4-р сарын сүүлчээс ус $+6.8+10^{\circ}\text{C}$ болоход нуурт цутгаж буй голоо өгсөн хайрга чулуун завсар түрсээ шахна. Хоёр дахь бүл нь 7-р сарын эхээс 8-р сарын эх хүртэл нуурын эргийн хайрга чулуунд болон голоо 3-5 км өгсөн түрсээ шахна (Мэндсайхан нар, 2017). Атуу 1,100-4,200 түрс гаргана (Соколова, 1985). Үржлийн дараа идэвхтэй идээшилнэ (Дашдорж нар, 1976; Тугарина, 2002). Нуурын гүнээр тархах хадран нь голчлон хөвмөл амьтдаар, эргийн дагуу тархан амьдрах нь ёроолын макро сээр нуруугүйтэн, хуурай газрын шавжаар хооллоно (Tyler *et al.*, 2011; Мэндсайхан нар, 2022). Байгальд 17 насалдаг (Tsogtsaikhan *et al.*, 2016).

Тоо толгой, нягтшил. Хөвсгөл нуурын 26-222 м гүнд амьдрах энэ зүйлийн тархалт, байршил, нягтшилыг орчин үеийн зайнаас тандан судлах багажийг ашиглан тооцоолоход, нягтшил 34.2 ± 6.8 бодгаль/га⁻¹, биомасс 4.4 ± 0.9 кг/га⁻¹ байна. Энэ нь Хөвсгөл

нуур шиг томоохон олиготроф нууруудын загасны нягтшилтай харьцуулахад 3.5-40 дахин бага байна (Tyler *et al.*, 2011).

Ховордлын шалтгаан. Амьдрах орчин, түрс шахах хугацаанд нь ихээр барьдаг (1.3.2.1) нь нөөцөд эрс сөргөөр нөлөөлдөг. Тороор (4.1.2) агнаж (1.3.2) хувийн хэрэгцээнд (1.3.2.1) болон дотоод, гадаадын жуулчдад (10.1) худалдана (3.4.3). Үржлийн үед эрчимтэй агнаснаас (1.3.2) нөөц нь багасаж байна (Free *et al.*, 2015; Мэндсайхан нар, 2017б). Зах зээлийн эдийн засагт шилжин орсноос хүмүүс утаж, дотоод, гадаадын жуулчдад (10.1) худалдах болсон. Дэлхийн дулаарлаас (6.1.1.) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, бохирдол (1), түрс шахах талбайн хэмжээ багасах, тархалт хязгаарлагдмал болох (9.1), эзэмшил нутаг хумигдах (9.9), нягтшил багасах (9.5), өсөлтийн эрчим буурах (9.7), тоо толгойн хэлбэлзэл ихсэх (9.8), өвчин эмгэг үүсгэгчид, шимэгчид (8.5) зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хөвсгөл хадран 11,100 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Одоо хэрэгжиж байгаа Амьтны тухай хуульд заасан Хөвсгөл хадран загасыг агнах, барихыг хориглосон хугацааг өөрчлөн шинэчлэх шаардлагатай.

Мөн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан “Дархан цаазат газрын

болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно” гэсэн заалтын хүрээнд бодлогын түвшинд Хөвсгөл нуурт нарийвчилсан загас агнуурын зохион байгуулалтыг хийлгэж, загас барих бүсийг тогтоож, агнуурын менежмент төлөвлөгөөг шинээр боловсруулж (1.2.1.2), хэрэгжүүлэх (1.2.2) шаардлагатай.

Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад ангилал зүй (3.1), түүний популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэх нь чухал байна. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ ЭМЗЭГ (VU) БОЛОН ХОВОРДОЖ
БОЛЗОШГҮЙ (NT) ЗАГАСНЫ ЗҮЙЛҮҮДИЙН
БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ



3.1. ЕНИСЕЙН ХАДРАН

Thymallus svetovidovi (Knizhin & Weiss, 2009)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хадран (Thymallidae)

Англи нэр: Upper Yenisei grayling

Ижил нэр: *Thymallus arcticus dentatus*, *Thymallus svetovidovi*.



Ангилал зүйн тойм. Шишгэд голоос барьсан популяци нь *Th. arcticus*-аас ялгаатай, харин *Th. brevirostris* гэх зүйлтэй илүү ойр (Koskinen *et al.*, 2002). Энэ популяци биеийн зүсээрээ Монгол орны бусад хадрангаас ялгаатай.

Таних шинж. Бие бахим. Сүүлний сэлүүрийн бариул болон сүүлний сэлүүрийн суурь тод шар. Хайрс том, нягт. Хошуу монхор, ам тэгш. Дээд эрүү нүдний голын хэсэг хүрэхгүй. Хэвлийн сэлүүрээс дээш, хажуугийн шугамаас доош хайрс бүдэг улаавар туяатай. Түүний дээд зах өргөн, зууван. Нурууны сэлүүр хэд хэдэн эгнээ янз бүрийн хэлбэртэй хүрэн улаан толботой. Сэлүүрийн дунд хэсгээс толбо бөөрөнхий хэлбэртэй болж тод ялгарна. Дээд эгнээний толбо том, хэлбэр дүрсгүй. Өөхөн сэлүүр том, хөхвөр ягаан. Цээжний сэлүүр жигд шаравтар саарал (Мэндсайхан нар, 2017а).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).

Бус нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.


2025 онд Эмзэг (VU), B2ab (i, ii). Тархац нутгийн хэмжээ 100 км²-аас ихгүй. Монголд цөөн тооны голд тэмдэглэгдсэн ба дэлхийн дулаарлаас үүдэн амьдрах орчин нь хумигдаж, үржлийн нутаг нь доройтож, хууль бус загасчлалд ихээр өртөж байгаа тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Оросын Енисей мөрний эх (Knizhin *et al.*, 2009) болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Дархадын хотгорын Тэнгис, Хөг, Шарга, Шишхэд гол, Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Боршоо, Тэс голд тархана (Мэндсайхан нар, 2017а). Тогтмол урсгалтай голын (5.1) хүйтэн, хүчилтөрөгчөөр баялаг харгиа хэсгээр амьдарна.



Амьдралын онцлог. Биеийн урт 40 см. 4-р сарын сүүлч 5-р сарын эхээр голоо өгсөн хайрга, чулуурхаг ёроолын хурдсанд тогоо үүсгэн түрсээ шахна. Усны шавж, жижиг загасаар хооллоно (Аюушсүрэн нар, 2024). Генетикийн хувьд Монгол хадран загастай ойролцоо (Ponomareva *et al.*, 2022).

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгой, нөөцийн хэмжээ тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Тороор (4.1.2) агнаж (1.3.2) ахуйн хэрэгцээнд (1.3.2.1) ашигладаг. Үржлийнх нь үед агнаснаас (1.3.2) нөөц нь багасаж байна. Түрс шахах талбайн хэмжээ бага (9.1), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), нягтшил бага (9.5), тоо толгойн хэлбэлзэл их (9.8) зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрсөн.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн

гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Енисейн хадран загас 10,800 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Тэнгис-Шишгэдийн байгалийн цогцолборт газар, Тэсийн голын байгалийн нөөц газар зэрэг тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад түүний ангилал зүй (3.1), популяцийн хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.2. МОНГОЛ ХАДРАН

Thymallus brevirostris (Kessler, 1879)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хадран (Thymallidae)

Англи нэр: Mongolian grayling

Ижил нэр: *Thymallus brevirostris*, *Phylogephyra altaica*, *Thymallus brevirostris kozovi*, *Thymallus brevirostris altaicus*.



Ангилал зүйн тойм. Хотон, Хоргон нуураас барьсан зүйлийг *Thymallus brevirostris kozovi* хэмээн тэмдэглэсэн (Дашдорж нар, 1968). Мөн Решетников и др. (1997), Bogutskaya (2004), Баасанжав нар (2001) *Thymallus brevirostris* гэж үзжээ. Хотон, Хоргон нуурын популяци нь бусад популяцийг бодвол биеэр том буюу урт нь 70 см хүрдэг ажээ. Оросын судлаачид энэ зүйлийг *Thymallus brevirostris altaicus* гэж үзсэн (Koskinen нар, 2002). Хотон, Хоргон нуурын Монгол хадран амьдрах орчин, идэш тэжээлийн онцлогоос шалтгаалан ёроолын амьтдаар хооллогч болон махан идэшт гэсэн морфо-экологийн хоёр хэлбэрийг үүсгэдэг (Слынько и др., 2010).

Таних шинж. Нурууны сэлүүр богино, намхан, хүчирхэг шүд бүхий том амтай (Мэндсайхан нар, 2017а). Бие бахим, бараавтар саарал, нуруун тал бүдэг хар ногоон туяатай, хэвлий цайвардуу, нурууны сэлүүр солонгорсон хүрэн ягаан ба толбогүй. Үржлийн үед нь ч толбо хөгждөггүй. Бие нягт, том хайрсаар бүрхэгдсэн. Өөхөн сэлүүртэй (Баасанжав, 1975; 1980).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Эмзэг (VU), B2ab (iii,v) (Осcock et al., 2006).

2025 онд Эмзэг (VU), B2ab (iii, v). Түрс шахах газрын хэмжээ 2,000 км²-аас бага. Ховд аймгийн Чоно харайх голд 2008 онд, Дөргөн болон Говь-Алтайн Завхан голд 2009 онд Тайширын усан цахилгаан станцыг байгуулсан нь энэ зүйлийн шилжилт хөдөлгөөнийг хааж, үржлийн нутаг нь Хар-Ус нуур-Ховд гол, Хар нуур-Тээлийн гол, Завхан голын хэсэг болон хуваагдсан. Дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшний хэлбэлзлээс амьдрах орчин нь доройтож, түрс шахах талбайн хэмжээ багассан, мөн хууль бус агнуурын нөлөөгөөр тоо толгой нь буурсаар байгаа тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, С.Пүрэвдорж, Б.Мөнхзориг (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Оросын нутаг дэвсгэрт Тувагийн Ховд голын эх (Груш нуур, Ак-Холь, Кырдыкт гол), Хар голын сав газарт тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын унаган загас. Богд, Бөх мөрөн, Буянт, Завхан, Хариг, Ховд, Чигэстэй, Яруу гол болон Ачит, Даян, Толбо, Хар, Хар-Ус, Хоргон, Хотон, Хонгор-Өлөн нуурт тархжээ (Мэндсайхан нар, 2017а). Тогтмол урсгалтай голын (5.1) хүчилтөрөгчийн хангамж сайтай, харгиа боргио, голын цутгал орчмын хэсэг, цэнгэг уст нуурт (5.5), зундаа нуурын 3.0-4.5 м гүнд, өвөлдөө нуурын гүн хэсэг, голын цүнхээлд өвөлжинө.

Амьдралын онцлог. Биеийн урт 70 см, жин 3 кг. 16 хүртэл насална. 5-6 насандаа үржилд орох ба 4-р сарын сүүлчээс ус +4+6.0С болоход нуурт цутгаж буй гол өгсөн сүрэглэж, хайрга чулууны ёроолд түрсээ шахна. Үр тогтсоны дараа атуух нь 7-10 хоног үүрээ манана. Атуу 5,000-18,000 орчим түрс гаргана (Тугарина и др., 1972; Лапин и др., 1982). Амьдрах орчин, идэш тэжээлийн онцлогоос шалтгаалан ёроолын амьтдаар хооллогч болон махан идэшт гэсэн морфо-экологийн хоёр хэлбэрийг үүсгэдэг (Слынько и др., 2010). Хавар нуураас гол руу өгсөх, намар уруудах шилжилт хийх (Мэндсайхан нар, 2019) бөгөөд хамгийн холдоо 170 орчим км-т шилжилт хийнэ.

Тоо толгой, нягтшил. Хар-Ус, Хар нуурт Ховд аймгийн Ой, агнуурын аж ахуй 1981 оны намраас эхлэн загас бэлтгэж эхэлсэн бөгөөд Цахиртайн хоолой, Шаазантын хоолой, Чоно харайхын голоос жилдээ дунджаар 10-25 тн загасыг өвөл мөс цоолон зөвхөн дэгээгээр барьж байв. 1990 оны өвлөөс эхэлж үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих ажил идэвхжиж Ой, агнуурын аж ахуйн томоохон бригадын анчид Хятадын мэргэжлийн загасчидтай хамтран Хар нуураас 40-80 орчим тн загас олборлож байсны 20 орчим хувийг монгол хадран эзэлж байжээ (Ховд аймгийн Ой, агнуурын аж ахуйн анчин Оросоогийн аман мэдээ). Загасыг үйлдвэрлэлийн зориулалтаар олборлох ажил 10 орчим жил үргэлжилж уг нуурууд улсын тусгай хамгаалалтад орсноор зогсжээ.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарал (6.1.1) эрчимтэй явагдсанаас мөнх цас хайлах (7.6), гантай жилийн үргэлжлэх хугацаа уртассанаас (7.1) усны түвшин багасах, хүчтэй аадар бороо (7.2) орсноос амьдрах орчин өөрчлөгдөх, доройтох, бохирдох (1), хүн амын нягтшил суурьшлын нөлөөгөөр (1.4.2) үүсэх хог хаягдал (6.3.9), бэлчээрийн талхидал (6.2.1), малын тоо толгойн өсөлт (1.1.4.1), усан цахилгаан



станцын нөлөө (1.4.6) зэрэг нь энэ зүйлийн үржил, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд сөргөөр нөлөөлнө (Мэндсайхан нар, 2021). Спорт загасчлалын гол төлөөлөгч учир үржлийн үед олноор барьж (1.3.2), өвлийн улиралд нуурт хууль бусаар заламгайн тор (4.1.1.2) тавин агнаснаас тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023

оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол хадран 30,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Алтай Таван Богд, Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газар зэрэг тусгай хамгаалалттай газар нутгуудад хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулж (1.2.1.2), хэрэгжүүлэх (1.2.2) шаардлагатай. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчин (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэж, зүйлд чиглэж зориудын аргаар үржүүлэх (5.7), бие даан амьдрах чадвартай жараахайгаар байгалийн нөөцийг нөхөн сэргээх (4.2), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.3. МОНХОР ХОНШООРТ ЗЭВЭГ

Brachymystax tumensis (Mori, 1930)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хулд (Salmonidae)

Англи нэр: Blunt-snouted lenok, Tumen lenok

Ижил нэр: *Brachymystax tumensis*, *Brachymystax savinovi*.



Ангилал зүйн тойм. Энэ зүйл Түмэн голоос тэмдэглэгдсэн ба түүнийг шөвгөр хоншоорт зэвэгтэй нэг зүйл хэмээн үзсэн. Богутская (2001, 2004) болон Shedko (2001) нар үүнийг бие даасан зүйл хэмээн тэмдэглэв. Mori (1930)-ийн тодорхойлсноор, уг зүйл нь бүх биеэрээ олон тооны том толботой, заламгайн өргөс 22, монхор хоншоортой. Амар болон Түмэн голын зэвгийн нэг ижил зүйл болох нь хараахан нотлогдоогүй. *B. tumensis* нэрийг Солонгосын судлаачид бараг ашигладаггүй бөгөөд түүнийг *B. l. tsinlingensis* (Jeon, 1987; Kim, 1997) хэмээн тэмдэглэжээ. *Brachymystax tsinlingensis* нь Хятадын Чанхи мужийн Чин Линг голд тархсан. Хэрэв Амарын сав газарт монхор хоншоорт зэвгийн нэг л зүйл байдаг, мөн энэ нь Түмэн голын зэвэгтэй ижил зүйл болох нь нотлогдвол, Монголд тархдаг монхор хоншоорт зэвгийг *Brachymystax tumensis* гэж нэрлэх нь зүйтэй (Kottelat, 2006).

Таних шинж. Бие алтлаг бор шаргал, биеийн хажуу, толгой, заламгайн хавхлаг, өөхөн сэлүүр болон нурууны сэлүүр дээр том том хар толботой (Мэндсайхан нар, 2017а). Ам жижиг, тэгш (Алексеев и др., 1983; 1985). Дээд, доод эрүү, тагнайд тах хэлбэртэйгээр шүд нь байрласан. Дээд, доод эрүү бараг тэнцүү эсвэл доод эрүү дээд эрүүнээс үл ялиг бага. Дээд эрүүний төгсгөл нүдний дунд хүрнэ. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Хайрс жижиг (Алексеев и др., 1983; 1985).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийд маш өргөн тархалттай ба түүнд нөлөөлж буй ховордлын шалтгаан тодорхойгүй. Тархац нутгийн аль нэг хэсэгт загас агнуур, харь зүйлийн түрэмгийллээс хамааран тоо толгой нь буурч байж болзошгүй. Амар мөрний сав газарт элбэг тархалттай.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.


2025 онд Эмзэг (VU), B2ab (iii, v). Түрс шахах нутаг 100 км²-аас бага. Дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшний хэлбэлзлээс хамааран түрс шахах талбайн хэмжээ багасах магадлалтай, тархац нутаг хязгаарлагдмал, хууль бус агнуурын нөлөөгөөр бие гүйцсэн бодгалийн тоо толгой эрс буурч байгаа учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, С.Пүрэвдорж, Б.Мөнхзориг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Оросын Амар мөрний сав газар, Лена мөрөн болон Сахалины арал, Хятад болон Солонгосын Түмэн голд тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Онон гол, түүний цутгал Агац, Балж, Хурх, Хярхан, Хярааны голд тархсан. Тогтмол урсгалтай голын (5.1) хүйтэн, ширүүн урсгалтай, хүчилтөрөгчөөр баялаг харгиа хэсгээр тархан амьдарна.



Амьдралын онцлог. Биеийн урт 65 см. 5-р сарын дундуур голоо өгсөн хайрга чулуу бүхий ёроолд сүрэглэн 1,300 хүртэл түрсээ шахна (Мэндсайхан нар, 2017). Үржлийн үед заримдаа биеийн хажуугаар хэлбэр дүрсгүй улаан толбо үүснэ. Монхор хоншоорт зэвэг нь усны ёроолын шавж, түүний авгалдай, хүүхэлдэй, усны мандлын шавж, бие гүйцсэн загас нь жижиг загасаар хооллоно (Мэндсайхан нар, 2017; Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийд популяцийн тоо толгойн чиг хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Мөн Монгол орны популяцийн тоо хэмжээ, хандлага тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Спорт загасчлалын гол төлөөлөл болдог тул хууль бус агнуурт ихээхэн өртөж (1.3.2), мөн ахуйн хэрэгцээнд (1.3.2.1) ашигладаг. Үржлийнх нь үед агнаснаас (1.3.2) нөөц нь багассаар байна. Түрс шахах талбайн хэмжээ бага (9.1), эзэмшил нутаг хязгаарлагдмал (9.9), нягтшил бага (9.5), тоо толгойн хэлбэлзэл ихтэй (9.8) зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн

гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр монхор хоншоорт зэвэг 26,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад түүний ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлд чиглэсэн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.4. ШАРГАЛ ҮХЭРДЭЭ

Tinca tinca (Linnaeus, 1758)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Үхэрдээ (Tincidae)

Англи нэр: Tench

Ижил нэр: *Cyprinus tinca* (Linnaeus, 1758), *Cyprinus tinca auratus* (Bloch, 1782), *Cyprinus tinca aureus* (Bloch, 1782), *Cyprinus tincaureus* (Shaw, 1804), *Cyprinus zeelt* (Lacepède, 1803), *Leuciscus communis* (Swainson, 1839), *Tinca aurea* (Gmelin, 1788), *Tinca chrysitis* (Fitzinger, 1832), *Tinca communis* (Swainson, 1839).



Таних шинж. Биеийн урт 47-60 см, жин 2-5 кг. Бие нь бахим бүдүүн, өндөр. Ам нь жижиг, уруул нь махлаг, хоёр завжиндаа богино сахалтай. Залгиурын шүдтэй. Нүд жижиг улаан хүрээтэй. Арьсанд гүн суусан жижиг хайрстай. Сүүлний сэлүүр нь ухлаадасгүй, тэгш. Сүүлний бариул богино, өргөн. Эр загасны хэвлийн сэлүүр том хэмжээтэй, эмийн өсөлт илүү хурдан. Зузаан арьстай. Өнгө нь хувьсамтгай, ерөнхийдөө ногоовтор хүрэн. Нуруугаараа хар ногоон, хажуугаараа алтлаг туяатай цайвар хүрэн. Бүх сэлүүрүүд нь бараан. Тухайн нуур, голын хурдасны шинж чанар, гэрлийн нэвтрэлт буюу тунгалагшилтаас хамааран өнгө нь өөр өөр. Тухайлбал, цэнгэг уст нуур голд алтлаг шаргал, ургамалтай гэрэл бага нэвтрэх тогтоол усанд бараг бараан (Аюушсүрэн нар, 2024).


Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Түгээмэл тархалттай ч генетикийн хувьд бүрэн бие даасан популяци байгаа эсэх нь эргэлзээтэй. Дэлхийн популяцийн

чиг хандлага буурч байгаа боловч ямар нэгэн ховордлын зэрэглэлд хамааруулахад шалгуур хангаагүй бөгөөд нийт популяцийн хэмжээ их тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock *et al.*, 2006).

2025 онд Эмзэг (VU), B2b (i). Тархац нутаг нь зөвхөн Булган голоор хязгаарлагдаж байгаа ба Булган голын ус зүйн сүлжээний онцлогтой холбоотой. Экологийн ижил ништэй харь зүйлүүд болох мөнгөлөг ба алтлаг хэлтэг, булуу цагаантай идэш тэжээл, амьдрах орчны өрсөлдөөн, эрлийзжилт, үр төлөрхөг чанарын алдагдал зэрэгт өртсөнөөр ховордож болзошгүй болсон. Түүнчлэн Амарын хөөлөнхэй мэт харь зүйлийн нөлөөгөөр үр төлийн мэнд үлдэлтийн хувь буурч байгааг Булган голд хийсэн судалгааны явцад уг зүйл баригдахаа больсон баримтаар нотлогдоно. Цаашид уг зүйлийн популяцийн нарийвчилсан судалгааг гүйцэтгэх шаардлагатай ч одоо байгаа судалгааны дүнд үндэслэн Эмзэг зэрэглэлээр үнэлэв.



Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Европ болон Хойд, Баруун, Төв Азийн зарим хэсэгт тархсан ба Хойд Америк, Чили, Энэтхэг, Индонез, Япон, Австри, Шинэ Зеланд, Өмнөд Африк болон Зимбабвед нутагшуулсан зүйл бий.

Монгол орны тархац, амьдрах орчин. Зөвхөн Булган голд ховор тохиолдоно. Цэнгэг уст ус, намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Голын шигүү ургамал дунд, тогтуун урсгалтай булан тохой, зуны халуунд ялангуяа хүйтэн устай цүнхээлд тархана. Шаварт шигдэн ичиж өвөлждөг бөгөөд голын тогтуун салаа, татуургыг шүтэн амьдарна. Жилийн турш нэг газраа суурьших ба ганцаарчилсан амьдралын хэв маягтай, сүрэлгэдэггүй, хол нүүдэл хийдэггүй. Харин хүчтэй үерийн урсгалын нөлөөгөөр алсад шилжиж болно.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтмол бууралт ажиглагдсан (IUCN, 2024) ба манай орны популяцийн хэмжээ, түүний чиг хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Хүний үйл ажиллагаанаас улбаалсан амьдрах орчны алдагдал, доройтол (1), түүний амьдрах

орчинд шууд нөлөөлөх харь зүйлийн түрэмгийлэл (1.5), өрсөлдөгчид (2.1), уугуул зүйлийн динамик өөрчлөлт (8) болон популяцийн хөдлөл зүй (9), тархац нутаг хумигдах (9.9) зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар орсон тул түүнийг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр шаргал үхэрдээ 18,500 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна.

Монгол Улсын Улаан ном (2013, 2016)-д нэн ховор зүйлээр бүртгэгдсэн (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газарт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Судалгааг тусгайлан хийх (3) нэн шаардлагатай. Тухайлбал, популяцийн хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4) болон ховордлын шалтгааныг (3.5) нарийвчилсан судалсны үндсэн дээр хамгааллын менежментийн арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

3.5. ШИВЭР ХАДРАН

Thymallus baicalensis (Dybowski, 1874)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хадран (Thymallidae)

Англи нэр: Baikal grayling

Ижил нэр: *Thymallus grubii* var. *baicalensis*, *Thymallus arcticus baicalensis* morpha *Angarensis*.



Ангилал зүйн тойм. Энэ зүйл хэд хэдэн дэд зүйлээс бүрдэнэ (Берг, 1948; Решетников и др., 1997). Хойд Америк болон Лена мөрний *T. arcticus* гэх зүйлийн популяци нь харьцангуй тусгаарагдмал (Koshinen *et al.*, 2002). Оросын эрдэмтэд Хойд Америкийн зүйлийг *T. signifer* (Решетников и др., 1997), Лена мөрний хадранг *T. pallasii* хэмээн нэрлэжээ (Берг, 1948). *T. arcticus* нь Кара, Обь, Енисей мөрөн, Монголын Их нууруудын хотгорт тархан амьдардаг (Берг, 1948). Енисей мөрний хоёр зүйлийн аль нь Обь мөрний зүйлтэй удмын хувьд холбоотойг одоогоор батлаагүй. Енисей мөрний адаг орчмынх нь *T. arcticus* байх магадлалтай (Kottelat, 2006). *T. baicalensis* нь Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав газарт тархдаг. *T. baicalensis* нь нурууны сэлүүрийн өнгөөрөө ялгагддаг (Weiss *et al.*, 2021). Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Заг, Байдраг голд, Хойд мөсөн далайн ай савын Чулуут голд нутагшуулсан хадран нь *T. baicalensis* болохыг молекул генетикийн судалгаагаар тогтоосон.

Таних шинж. Нурууны сэлүүр нь урт, түүний суурь толгойн уртаас урт, улаан болон улбар шар хүрээ бүхий ягаан толбот эгнээтэй. Нуруу хөх саарлаас нил ягаан, хажуу нь мөнгөлөг хөх саарал, заримдаа ягаавтар, цээжний хэсэгт хар толботой. Биеийн хажуу улаавтар хөндлөн судалтай. Нурууны сэлүүрийн суурийн урт нь биеийн уртын 20-27%-ийг эзэлнэ. Ам тэгш. Дээд эрүүний урт нүдний голын харалдаа төгсөнө. Жижиг өөхөн сэлүүртэй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Осcock *et al.*, 2006).

2025 онд Эмзэг (VU), АЗд. Дэлхийн дулаарлаас үүдэн усны түвшин хэлбэлзэх, уул уурхайн үйл ажиллагаанаас амьдрах орчин нь доройтох, спорт загасчлал, хууль бус агнуурт ихээхэн өртсөний улмаас популяцийн хэмжээ ойрын ирээдүйд буурч байгаа гэсэн үндэслэлээр Эмзэг зэрэглэлд оруулав.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хойд мөсөн далайн ай савын нуур, голууд Оросын Кара голоос Чукотск, Камчатск, Печорын цутгал, Коротайка гол, Байгал нуур, Амар мөрний сав, Монголын Сэлэнгэ мөрөн, түүний цутгал, Аляск, Канад, Хойд Америкт тархсан (Kottelat, 2006).


Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ мөрний бүх цутгал голууд, Дархадын хотгорын нуур, голууд, Ёлт, Орхон, Сонгинот, Туул голын эх болон Тэрхийн Цагаан нуур, Хар Эрчисийн эхэн Хуримт, Хөвсгөл нуурт тархана (Баасанжав нар, 2001; Аюушсүрэн нар, 2024). Баянхонгор аймгийн Байдраг голын сав газар Заг голд нутагшуулсан (Мэндсайхан нар, 2012). Тогтмол урсгалтай голын (5.1) хүчилтөрөгчийн хангамж сайтай, харгиа боргио, голын цутгал хавийн харзтай хэсэгт, цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 50 см. 3-4 насандаа үржилд орно. Үржил 4-р сарын сүүлчээс усны $+6^{\circ}\text{C}$ болж ирэхэд түрсээ шахаж эхлэх бөгөөд 5-р сарын дунд хүртэл үргэлжилнэ. Голын ширүүн урсгалтай

хэсгийн хайрга чулууны ёроолд 2.5-3.0х3.5-4.5 м диаметр бүхий тэгш өнцөгт эсвэл 1.8-2.4х2.4-3.1 м диаметр бүхий зууван хэлбэртэйгээр үүр засан сүргээрээ түрсээ шахна. Түрс шахсаны дараа үржлийн талбайг атуух нь хамгаалж үлдэнэ. Атуу дунджаар 5,000-10,000 орчим түрс гаргана. Хоовгон, шаамий хавч, зөөлөн биетэн, соно, жингэнүүр ялааны авгалдай зэрэг ёроолын амьтад, усны ургамал, замаг, заримдаа усны гадаргуу дээр унасан хуурай газрын шавжаар хооллодог элдэв идэштэн.

Тоо толгой, нягтшил. Дархадын хотгорын нууруудаас 1956-1964 онд 2.4 тн олборлож байсан (Дулмаа, 1967). Үржлийн үед эрчимтэй агнаснаас популяцийн хэмжээ 20%-аар буурсан гэсэн дүгнэлтэд хүрсэн (Ососк нар, 2006). Өнөөгийн байдлаар энэ зүйлийн популяцийн талаарх баримт ховор.

Ховордлын шалтгаан. Дэлхий дулаарал (6.1.1.), гангийн үргэлжлэх хугацаа уртсах (7.1) усны түвшин багасах, хүчтэй аадар бороо (7.2) орсноос амьдрах орчин өөрчлөгдөх, бохирдох (1), хүн амын нягтшил суурьшлын нөлөөгөөр (1.4.2) хог хаягдал үүсэх (6.3.9), бэлчээрийн талхагдал (6.2.1), малын тоо толгойн өсөлт (1.1.4.1), уул уурхайн ашиглалт (1.3.1), орчны бохирдлын



(1) улмаас амьдрах орчин доройтох нь түүний үржилд сөргөөр нөлөөлнө. Эрчимтэй агнуур (1.3.2), зохицуулгагүй загас агнуур, хүний шууд нөлөөгөөр (10) тоо толгой нь буурсан. Спорт загасчлалын гол төлөөлөгч болохын хувьд зугаагаа гарган уургаар (1.4.3, 1.3.2.1) их барьдаг, мах нь таваарлаг чанар сайтай учир ахуйн хэрэглээндээ тороор (4.1.1.2) барихаас гадна, хууль бус агнуурт (1.3.2.1; 1.3.2.2) өртөнө. Сүүлийн жилүүдэд тураг гогой (8.3) зуны улиралд олноор сүрэглэн өсвөр насны загасыг ихээр идэж (9.3) түүний тоо толгойд сөргөөр нөлөөлөх болсон.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн

зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр хадран 11,900 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгаалалд түүний ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг гүйцэтгэх шаардлагатай. Зориудын аргаар үржүүлэх (5.7), бие даан амьдрах чадвартай жараахайгаар байгалийн нөөцийг нөхөн сэргээх (4.2), зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) нь зүйтэй.

3.6. ШӨВГӨР ХОНШООРТ ЗЭВЭГ

Brachymystax lenok (Pallas, 1773)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Хулд (Salmonidae)

Англи нэр: Sharp-snouted lenok

Ижил нэр: *Salmo lenok*, *Salmo coregonoides*, *Brachymystax lenok swetowidowi*.



Ангилал зүйн тойм. Зарим судлаачид энэ зүйлийг дэд зүйл (Кифа, 1976; Богутская и др., 2004), зарим нь бие даасан зүйл хэмээдэг (Решетников и др., 1997). Зүүн Сибирьд Оленекээс Колумын сав газарт зэвэг загасны судалгааг хийсэн ч (Алексеев и др., 2003) Зүүн Сибирь болон Амарын хэлбэрүүдийн морфологийн ялгааг бүрэн гаргаагүй. Молекул биологийн судалгаагаар, Зүүн Сибирь болон Амарын монхор хоншоорт зэвэг нь нэг зүйлд хамаардаг (Froufe *et al.*, 2003). Амарын сав газарт шөвгөр хоншоорт зэвэг ба монхор хоншоорт зэвэг (*B. savinovi*) гэх хоёр зүйл байна (Kifa, 1976). Shedko (2001) болон Богутская (2004) нар *Brachymystax lenok savinovi* гэх дэд зүйлийг *B. lenok* зүйлийн синоним гэж үзсэн.

Таних шинж. Биеийн хажуу, толгой, нурууны болон сүүлний сэлүүрүүд бөөрөнхий, зууван хар толботой. Биеийн хажууд 6-8 зэсэн улаан хүрэн босоо судалтай. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Сүүлний сэлүүрийн ухлаадас бага. Бие хажуугаасаа

бөөрөнхийдүү. Ам жижиг, эрүү, тагнайд шүдтэй. Дээд эрүү богино, нүдний дунд хэсэг хүрнэ. Хайрс жижиг.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Сибирийн гол, мөрөнд тоо толгой олон, өргөн тархалттай тул энэ зэрэглэлээр үнэлсэн.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Эмзэг (VU), A3d (Осcock *et al.*, 2006).

2025 онд Эмзэг (VU), B3d. Өргөн тархалттай ч спорт загасчлалын гол төлөөлөгч тул хууль бус агнуурт ихээр өртдөг. Бодгалийн тоо буурч байгаа нь уул уурхай, хүн амын суурьшлын нөлөөгөөр амьдрах орчин нь механик болон органик бохирдолд өртөн доройтож, дэлхийн дулаарлаас үүдэн усны түвшин багасаж, үржих талбай хумигдаж байна. Энэ зүйлийн популяци дараагийн 15 жилд (3 үе удам) 30 хүртэлх хувиар (A3 шалгуур) буурна хэмээн таамагласан (Осcock нар, 2006). Хүн амын хүнсний хэрэгцээнд загасан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байгаагаас их хэмжээгээр

агнаж, популяцид учирч болох аюул занал улам нэмэгдэх хандлагатай болж байгаа учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, А.Түвшинлхагва, Б.Мөнхзориг (2025).

Үнэлгээг хянасан: П.Цогтсайхан, С.Гомбобаатар (2025).


Дэлхийн тархац. Хойд мөсөн далайд цутгах голууд Оросын Обь мөрнөөс Колым хүртэл, Енисей, Лена мөрөн, Алс Дорнодын хойд хэсэг Тугур, Үд гол, Казакстаны зүүн хойд хэсэг Иртыш мөрний сав газар, өмнөд хэсэгт Солонгосын хойгийн өмнөд хэсгийн голууд, Яла мөрөн, Номхон далайн ай сав Хятадын хойд хэсэг, Амар мөрний сав, Япон болон Агнуурын тэнгист цутгах гол, Монгол орны хойд болон зүүн хэсгийн нуур голуудаар тархсан (Атлас пресноводных рыб России, 2003; Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Дэлгэрмөрөн, Ерөө, Идэр, Чулуут, Суман, Орхон, Туул, Тэнгис, Үүр, Хөг, Шарга, Шишгэд, Эг голууд, Хөвсгөл, Тэрхийн Цагаан, Өгий, Дархадын хотгорын нуурууд, Номхон далайн ай савын Онон, түүний цутгал голууд, Хэрлэн, Халх гол, Буйр нуурт тархсан. Баянхонгор аймгийн Байдраг голын сав Биндэръяа Хөх нуур, Загийн голд нутагшуулсан (Мэндсайхан

нар, 2012). Тогтмол урсгалтай голын (5.1) хүчилтөрөгчийн хангамж сайтай, харгиа боргио, голын цутгал хавийн харзтай хэсэгт, цэнгэг уст нуурт (5.5) тархан амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 70 см, жин 6 кг. 6-7 насандаа биеийн урт 40-45 см, жин 700-900 г хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. 4-р сарын сүүлчээс 5-р сарын дунд хүртэл усны хэм +6+12°C болоход голоо өгсөн хайрга чулуун ёроол бүхий хэсэгт 0.5-0.8 м диаметртэй, 15-20 см гүнтэй хонхор үүсгэж, бөөнөөрөө түрсээ шахна. Атуу дунджаар 2,500-10,800 түрс гаргана. Усны болон хуурай газрын шавж, жижиг загас, бие гүйцсэн том загас нь жижиг хөхтнөөр хооллоно.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтмол бууралт ажиглагдаж байгаа (IUCN, 2024) бөгөөд манай орны популяцийн хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс. Дархадын хотгорын нууруудаас 1957-1964 онд 7.3 тн шөвгөр хоншоорт зэвгийг олборлож байсан (Дулмаа, 1974). Хамгийн их нь 1963 онд 13 тн, 1964 онд 14 тн-ийг барьж байжээ. Буйр нуураас 1954-1964 онд олборлосон загасны 9%-ийг, 1970-аад онд ердийн тул, шөвгөр хоншоорт нийлээд 2.5%-



ийг эзэлж байжээ (Мэндсайхан нар, 2017b). Буйр нуурт агнуур эрчимжсэнээр 1980-аад оноос агнуурын холбогдолтой зэвэг үзэгдэхээ больсон. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн органик бохирдлоос шалтгаалж, түүний амьдрах орчин алдагдаж, Туул голын шөвгөр хоншоорт зэвэг устаж, дайжсан ба мөн хууль бус загасчлалын нөлөөгөөр тоо толгой нь эрс буурсан. Иймээс 2012 оноос шөвгөр хоншоорт зэвэг загасыг зориудын аргаар лабораторийн нөхцөлд үржүүлэн 675,000 ширхэг бие даан амьдрах чадвартай жараахайг Туул голд тавьж, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг эхлээд байна (Мэндсайхан нар, 2012; 2014; Mendsaikhan et al., 2020).

Ховордлын шалтгаан. Спорт загасчлалын гол төлөөлөгч болох энэ зүйл зэвгийг уурга, дэгээ (4.1.1.1), тороор (4.1.2) агнаж (1.3.2) ахуйн хэрэгцээнд (1.3.2.1) ашигладаг. Үржлийн үед нь хууль бусаар ихээр агнаснаас (1.3.2) нөөц нь багассан (Мэндсайхан нар, 2017b). Зах зээлд жижиглэн худалдааны зориулалтаар иргэд утаж, дотоод, гадаадын жуулчдад (10.1) худалдаалж (3.4.3) байна. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, бохирдол (1), түрс шахах талбайн хэмжээ багассан (9.1) зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрсөн.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн

гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр шөвгөр хоншоорт зэвэг 29,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.1.2), загас агнуурын бүсийг тогтоож, менежментийн төлөвлөгөө (1.1.2), хамтын менежментийг (1.3) хэрэгжүүлэх (1.2.2) шаардлагатай. Ангилал зүйн судалгаа (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан гүйцэтгэх хэрэгтэй. Зориудын аргаар үржүүлэх (5.7), бие даан амьдрах чадвартай жараахайгаар байгалийн нөөцийг сэргээх (4.2), сэргээн нутагшуулах (5.1), нөхөн сэргээх үйл ажиллагааны менежмент (5.4) хэрэгжүүлэх, зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.7. БУХ СУГАС

Leuciscus idus (Linnaeus, 1758)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Ide

Ижил нэр: *Cyprinus idus* (Linnaeus, 1758), *Idus idus* (Linnaeus, 1758), *Cyprinus jesus* (Linnaeus, 1758), *Cyprinus idbarus* (Linnaeus, 1758), *Cyprinus orfus* (Linnaeus, 1758), *Cyprinus microlepidotus* (Ekström, 1835), *Leuciscus neglectus* (Selys-Longchamps, 1842), *Idus melanotus* (Heckel, 1843), *Idus miniatus* (Bonaparte, 1845), *Idus miniatus* (Heckel & Kner, 1858), *Squalius oxianus* (Kessler, 1877), *Idus oxianus* (Kessler, 1877).



Таних шинж. Мөрөг загастай төсөөтэй биеийн галбиртай ч ерөнхийдөө мөнгөлөг өнгөтэй, сэлүүрүүд улаан ягаан. Бие гүйцсэн загасны өнгө шаргал хүрэн болж хувирна. Ам тэгш. Бух сугасны дух өргөн, бие өндөр, толгой харьцангуй жижгэвтэр. Залгиур араа хоёр эгнээ буюу 3.5-5.3 цилиндр хэлбэрийн шүдтэй. Заламгайн өргөс богинохон, 10-14 өргөстэй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Популяцийн бууралт нь эмзэг зэрэглэлээр үнэлэх босгод нийцэхээргүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Ососк *et al.*, 2006). 2025 онд Ховордож болзошгүй (NT). Амьдрах орчны доройтол, эрчимтэй агнуурын нөлөөгөөр популяцийн тоо толгой нь буурч байж болзошгүй.


Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хойд Европын Рейн мөрний сав, зүүнээ Лена мөрний сав хүрэх ба Оросын зүүн хэсэг, Ази тивийн нуур, голуудад тархсан. Англи, Хойд Америк, Шинэ Зеландад нутагшуулсан (Ососк нар, 2006; Атлас пресноводных рыб России, 2003; Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ мөрний сав газрын голууд, Орхон, Туул гол, Өгий, Тэрхийн Цагаан нуурт тархсан (Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986; Баасанжав нар, 2001). Тогтмол урсгалтай голын (5.1) урсгал тогтуун, нарны илчинд амархан халдаг ургамалтай хэсэг, булан тохойд, цэнгэг уст нуурт (5.5), цөөрөм (5.7)-ийн ургамал бүхий хэсэгт сүрэлгэн амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 70 см, жин 6-8 кг. Гол төлөв 30-50 см, 1 кг жинтэй. Биеийн урт 4 насандаа 25 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 4-р сарын



сүүлчээс эхэлж, 5-р сард усны температур $+5+7^{\circ}\text{C}$ болоход түрсээ голын ширүүн урсгалтай хайрга, чулуу болон ургамал дээр 37,600-114,000 орчим түрс гаргана. Бие гүйцсэн усны ёроолын шавж, тэдгээрийн авгалдай, зөөлөн биетэн, хорхой, замаг, усны дээд ургамлаар хооллоно.

Тоо толгой, нягтшил. 1932-1947 онд Архангай аймгийн Өгий нуураас хүнсний комбинат, гар артель, 1955-1980 онд Улаанбаатар хотын мах комбинат загас олборлож байсан бөгөөд 1955-1960 онд 31.9 тн, 1961-1965 онд 90.4 тн (Цэнд-Аюуш, 1968), 1966-1970 онд 32.6 тн олборлож байв (Дулмаа нар, 1972). 1980 он хүртэл жилд 30 тн агнаж ирсэн бөгөөд нийт олборлосон загасны 1.7-19.2%-ийг бух сугас эзэлж байжээ. Орон нутгийн иргэдийн хүсэлтээр 1989 оноос загас агнахыг хориглосон тогтоол гаргасан. Биологийн хүрээлэнгийн судлаачид Өгий нуурт судалгаа хийж, агнуурын загасны зүйлийн бүрэлдэхүүнд гарч байгаа өөрчлөлтийг гаргажээ.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, бохирдол (1), тороор (4.1.2) агнаж (1.3.2) ахуйн хэрэгцээнд (1.3.2.1) ашигладаг, эрчимтэй агнуурын нөлөөгөөр (1.3.2) нөөц нь багасаж байгаа зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар

сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бух сугас 10,600 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Шинжлэх ухаанд суурилсан хамгааллын арга хэмжээ авахад түүний ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны статус (3.4), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.8. ХАТГУУРТ ХАРВАА

Acheilognathus asmussi (Dybowski, 1872)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Харваа (Acheilognathidae)

Англи нэр: Amur spiny bitterling

Ижил нэр: *Devario asmussi* (Dybowski, 1872), *Acanthorhodeus asmussi* (Dybowski, 1872).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг *Acanthorhodeus* (Атлас пресноводных рыб России, 2003; Решетников и др., 1997; Bogutskaya *et al.*, 2004), мөн *Acheilognathus* төрөлд багтаан ангилсан (Arai, Akai, 1988).

Таних шинж. Бие хоёр хажуугаас хавчиг. Нуруу болон сүвний сэлүүр хатгууртай, сүвний сэлүүр урт, хажуугийн шугам бүрэн. Бие гүйцсэн бодгалийн дээд эрүүнд мэдэгдэх төдий сахалтай (Баасанжав нар, 2001). Нуруу ногоовтор бор, хажуу мөнгөлөг, заримдаа хөхөлбөр туяатай. Тод алтлаг хайрстай. Хэвлийн сэлүүрийн дээгүүр алтлаг толботой. Толгой жижигхэн. Ам тэгш. Сүүлний хэсгээр тууш бараан зураастай (Мэндсайхан нар, 2017).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Түгээмэл тархалттай ба популяци нь тогтвортой. Аюул занал болон ашиглалтад өртөөгүй хэд хэдэн хамгаалалттай газар нутагт тархсан (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Осочко *et al.*, 2006).


2025 онд Ховордож болзошгүй (NT). Түрсээ шахдаг хос хавтаст зөөлөн биетнийг тороор их хэмжээгээр барьж, хүнсний зорилгоор ашиглаж, түүний нөөцөд сөргөөр нөлөөлж буй учир энэхүү зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Монгол, Орос, Солонгос, Хятадын Амар мөрний сав газарт тархсан (Атлас пресноводных рыб России, 2003; Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур, Онон, Халх болон Хэрлэн голын цутгалуудад тохиолдоно (Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986). Тогтмол урсгалтай голын (5.1) зөөлөн урсгалтай тогтуун, хүчилтөрөгчийн хангамж сайтай шаварлаг, элсэрхэг ёроолтой хэсэгт, цэнгэг уст нуурын



(5.5) торгон элсэрхэг ёроолтой хэсэгт амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 16 см. 3 насандаа биеийн урт 7 см хүрэхэд үржилд орно. 5-р сарын сүүлчээс 7-р сарын эхэн хүртэл түрсээ хэсэгчлэн шахна. Үржлийн үед атуугийн түрсний хаг уртсан өндөг дамжуулах хоолой болон гадагш сунаж, дунгийн хавтас завсар түрсээ шахаж, үр тогтооно (Аюушсүрэн нар, 2004). Атуу 300-1,100 орчим түрс гаргана. Замаг, усны ургамлаар хооллоно. Агнуурын бус загас.

Тоо толгой, нягтшил. Манай орны популяцийн хэмжээ, түүний чиг хандлагын талаар мэдээ, баримт хомс, тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, (1), усны бохирдол нэмэгдэж байгаа болон тороор загас барих (4.1.1.2) үед түрсээ шахдаг хос хавтаст зөөлөн биетэн их хэмжээгээр баригдах, хүнсэнд хэрэглэх (3.1.1) зэрэг хүчин зүйлс түүний тоо толгойг бууруулах шалтгаалан болж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын

15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хатгуурт харваа загас 3,400 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.1.2), хэрэгжүүлэх (1.2.2) шаардлагатай. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан хийх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.9. ХОРХОЙ ЗАГАС

Lethenteron reissneri (Dybowski, 1869)

Баг: Дугариг амтан (Petromyzontiformes)

Овог: Хорхой загас (Petromyzontidae)

Англи нэр: Far Eastern brook lamprey

Ижил нэр: *Petromyzon reissneri*, *Lampetra mitsukurii*, *Petromyzon kessleri*, *Lampetra mitsukurii minor*.



Ангилал зүйн тойм. *Lampetra reissneri* (Holcik, 1969; Дашдорж нар, 1977) зүйлийг Монгол-Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедици *Lampetra japonica* хэмээн үзсэн (Рыбы МНР, 1983; Баасанжав нар, 2001; Дулмаа, 1999). *L. reissneri* гэх зүйлийг Камчатскаас Солонгос, Японы Номхон далайд цутгах бүх голуудад тэмдэглэсэн. Онон голын *L. reissneri* гэх зүйл нь Оросын Алс Дорнод, Японы хойд хэсгээр амьдрах *L. kessleri* гэх зүйлд хамаарна гэжээ (Yamazaki et al., 2006).

Таних шинж. Хорхой хэлбэрийн биетэй, хайрсгүй. Биеийн хоёр хажууд заламгайн 7 сүв хөгжсөн. Хамрын ганц сүв нүдний өмнө байрлана. Хос сэлүүрүүдгүй. Нурууны сэлүүр хоёр, хоорондоо бага зэрэг тусгаарлагдсан. Эрүүгүй. Дугариг ам нь бумбадан сорох онцлогтой. Хажуугийн шугам нөсөөжөөгүй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Өргөн тархалттай ч тархац нутгийнхаа

аль нэг хэсэгт ховордсон байж болзошгүй. Гэвч эмзэг зэрэглэлд хамруулах шалгуур, үзүүлэлтийг хангаагүй тул энэ зэрэглэлээр үнэлсэн (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол орны хувьд тархац хязгаарлагдмал, тоо толгой цөөн, дэлхийн популяцийн 1 хүрэхгүй хувь тохиолддог тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Номхон далайн ай савын голуудаар тархана. Оросын Анадырь ба Камчаткаас Сахалин хүртэл тархсан (Берг, 1949; Никольский, 1956; Атлас пресноводных рыб России, 2003; Kottelat, 2006). Японы Хаккойда арал, Солонгосын хойгт тохиолдоно (Choi et al., 1990; Kottelat, 2006).



Монгол орны тархац, амьдрах орчин. Онон, Балж, түүний цутгал голд тархсан (Дгебуадзе, 1986; Дулмаа, 1999; Баасанжав нар, 2001). Хорхой загас нь тогтмол урсгалтай (5.1) голын салаа, тогтуун урсгалтай хэсэг, байнгын цэнгэг уст нуурын (5.5) эргийн элсэрхэг, шаварлаг хурдас бүхий хэсэгт амьдарна (Аюушсүрэн нар, 2024).

Амьдралын онцлог. Биеийн урт 23 см. Атуух нь атуугаасаа арай жижиг ба 3 насандаа бэлгэ боловсорч үржинэ. Голын ширүүн урсгалтай хэсгийн хайрга-элсэрхэг, чулуутай хэсэгт 5-р сарын сүүлч 6-р сарын эхээр 50,000-90,000 орчим түрс гаргана. Органик ялзмаг, замгаар хооллоно.

Тоо толгой, нягтшил. Манай орны популяцийн хэмжээ, түүний чиг хандлагын талаар мэдээ, баримт хомс, тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл, усны бохирдол (6.3), хөдөө аж ахуйгаас (6.3.1) үүсэх бохирдол зэрэг нь түүний тоо толгойд сөрөг нөлөөтэй. Эдгээр шалтгаан нь энэ зүйлийн амьдрах орчныг доройтуулж, хомсдуулах үр дагавартай.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хорхой загас 2,600 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна. Монгол Улсын Улаан ном (2013)-д ховор зүйлээр бүртгэгдсэн (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) тусгайлан явуулсны үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

3.10. ЦАГААН ХАДИР

Coregonus chadary (Dybowski, 1862)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Цагаасар (Coregonidae)

Англи нэр: Khadary-whitefish

Ижил нэр: *Coregonus chadary*



Таних шинж. Бие болон хажуу хэсэг мөнгөлөг цагаан, том хайрсаар хучигдсан. Толгой болон нуруу жижиг хар толботой. Дээд эрүүний яс урт. Дээд эрүү нь доод эрүүгээ ялимгүй давсан. Дээд эрүүний яс нүдний өмнөд хэсэгт хүрэхгүй. Сэлүүрийн үзүүр бараан. Өөхөн сэлүүртэй. Заламгайн өргөс цөөн буюу 23-28 ширхэг.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Амар мөрний сав газрын дээд хэсгээр өргөн тархацтай, популяцийн тоо толгой нь тогтвортой байгааг харгалзан Анхааралд өртөхөөргүй гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осочко *et al.*, 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол орны хувьд популяцийн тархалт, хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаар мэдээлэл хомс ч манай орны хувьд тархац нутгийн хэмжээ бага тул Ховордож болзошгүй зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П. Цогтсайхан (2025).


Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Оросын Амар мөрний сав газрын дээд, дунд хэсгийн голууд (Онон, Шилка, Аргунь, Уссури), Агнуурын тэнгисийн эрэг орчмоор Уда, Тугур голд тархсан (Никольский, 1956; Решетников, 1980).

Монгол орны тархац, амьдрах орчин.

Монголд Онон голын сав газарт тархсан (Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986; Баасанжав нар, 2001). Тогтмол урсгалтай (5.1) харьцангуй хүйтэн устай уулын голоор, зундаа эдгээр голын тогтуун урсгалтай хэсгийг бараадан амьдарна (Подушко, 1967). Намар усны хэм буурахад голын доод хэсэг рүү сүрэлгэн шилжинэ.

Амьдралын онцлог. Биеийн урт 59 см. 7-8 насандаа биеийн урт 40 см, 900 г жинтэй болоход үржилд орно. Намар орой 10-11-р сард голын хайрга чулуу, элсэрхэг ёроолд дунджаар 12,000 орчим түрс гаргана. Гол төлөв хоовгон, багшраа ялааны авгалдай



зэрэг ёроолын амьтдаар хооллох ба заримдаа загас ч иднэ.

Тоо толгой, нягтшил. Манай орны популяцийн хэмжээ, түүний чиг хандлагын талаар мэдээ, баримт хомс, тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Аялал жуулчлал, зугаа гаргаж (1.4.3) өвлийн улиралд мөс цоолон дэгээгээр, зундаа уургаар (4.1.1.1), мөн хууль бусаар тор тавьж (4.1.1.2), ахуйн хүнсний хэрэгцээнд (1.3.2.1) бага хэмжээгээр (1.3.2.2) агнадаг. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл, уул уурхайн (1.3.1) нөлөөтэй усны бохирдол, бэлчээрийн талхагдал (1.1.4.1), хүн амын суурьшил (1.4.2), ахуйн гаралтай органик бохирдол (6.3.2), хог хаягдал (6.3.9) зэрэг хүчин зүйлсийн улмаас амьдрах орчин нь доройтож байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн

гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цагаан хадир загас 16,300 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна. Монгол Улсын Улаан ном (2013)-д ховор зүйлээр бүртгэгдсэн (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) тусгайлан явуулсны үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй. Мөн энэ зүйл загасны үржил, хөгжлийн хугацааг харгалзан үзэж Амьтны тухай хуульд заасан агнах, барихыг хориглосон хугацааг шинэчлэн өөрчлөх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ
(LC), МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD) БОЛОН ҮНЭЛЭХ
БОЛОМЖГҮЙ (NA) ЗАГАСНЫ ЗҮЙЛҮҮДИЙН
БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ



4.1. АМАРЫН МОГОЛЗОЙ

Misgurnus mohoity (Dybowski, 1869)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Яралж (Cobitidae)

Англи нэр: Amur weatherfish

Ижил нэр: *Cobitis fossilis mohoity* (Dybowski, 1869), *Misgurnus bipartitus* (Sauvage & Dabry de Thiersant, 1874), *Misgurnus cestoideus* (Kessler, 1876), *Misgurnus erikssoni* (Rendahl, 1922), *Nemacheilus bipartitus* (Sauvage & Dabry de Thiersant, 1874).



Таних шинж. Биеийн урт 15-18 см, жин нь 80-100 г. Урт, могойрхуу хэлбэртэй. Хайрс нь маш жижиг боловч сайн ялгаран харагдах ба бүх биеийг бүрхсэн. Амаа тойрсон 12 сахалтай. Сүүлний сэлүүр дугуй. Эр нь эмээсээ ялгаатай нь цээжний сэлүүрийн хоёрдугаар цацраг нь урт болж, өргөссөн. Биеийн хажуугаар зузаан өөхөн эдийн үүсэлтэй. Хийт цуух нь ясархаг капсулд байрлана. Нүдний доор хатгуургүй. Хажуугийн шугамаас дээш буюу нуруугаараа хар ногоон, түүнээс доош цайвар шаргал. Гэхдээ биеийн зүс тухайн орчноос хамааран өөрчлөгдөх ба цэвэр усанд илүү тод, бохир усанд илүү бараан. Биеийн хажуугаар олон жижиг хар толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийд түгээмэл тархалттай. Загас агнуурт өгөөш болгон ашигласнаас тархац нутгийнхаа аль нэг хэсэгт буурч байж болзошгүй. Гэхдээ популяцийн бууралт нь ховордлын зэрэглэлд оруулахааргүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко *et al.*, 2006).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд өргөн тархалттай том популяци тогтоогдсон ба популяцийн бууралт ажиглагдаагүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хятадад Амар мөрний сав газрын зүүн хойд хэсгээр, Монгол орны зүүн хойд болон Оросын Алс Дорнодын Амар мөрний савд багтах нутгаар тархана (Antonov, 2012). Энэ зүйл Төвдийн тэгш өндөрлөг болон Шар мөрний савд одоогоор тэмдэглэгдээгүй.

Монгол орны тархац, амьдрах орчин. Онон, Хэрлэн, Улз ба Халх гол болон Гүн галуут, Буйр нуурт тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Сэрүүн бүсийн тогтуун урсгал бүхий цэнгэг уст голын ёроолын зүйл бөгөөд жижиг хайрга, элсэн ёроолд амьдардаг онцлогтой (Аюушсүрэн, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн тоо толгой болон популяцийн чиг хандлага тогтвортой (IUCN, 2024). Монгол орны популяцийн тоо хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүний үйл ажиллагаагаар бий болсон мал аж ахуйгаас (1.1.4) улбаалсан амьдрах орчны алдагдал, доройтол болно. Гүн галуут нуурын хувьд цутгал жижиг гол, горхи нь бэлчээрийн талхагдалд өртсөний улмаас энэ зүйлийн амьдрах орчин бохирдож байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын

15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын моголзой загас 2,300 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Түүний тархац нутгийн тодорхой хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) талаар нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй.

4.2. АМАРЫН ЦУЛБУУРТ

Silurus asotus (Linnaeus, 1758)

Баг: Цулбуурт (Siluriformes)

Овог: Цулбуурт (Siluridae)

Англи нэр: Amur catfish

Ижил нэр: *Silurus asotus*, *Silurus dauricus*, *Silurus punctatus*, *Silurus xanthosteus*, *Silurus japonicus*, *Silurus cinereus*, *Silurus bedfordi*, *Parasilurus asotus* (Kottelat, 2006).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг *Parasilurus* төрөлд хамааруулдаг байсан бөгөөд одоо *Silurus* төрөлд багтаан ангилах болсон (Kobayakawa, 1989).

Таних шинж. Толгой том, хавчгар, хошуу дугуйвтар хэлбэртэй. Арьс хайрсгүй, нүцгэн. Ам том, эрүү, самалдагтаа шүдтэй. Хоёр хос сахалтай ба 1 хос урт сахал дээд эрүүнд байдгаас улбаалан монгол нэрийг оноосон. Нэг хос сахал нь доод эрүүнд бий. Нуруу, хажуу тал бор ногоон, хэвлий цайвар. Нуруу, сүүл, сүв, хэвлийн сэлүүрүүд нуруутай ижил зүстэй. Нурууны сэлүүр маш бага, салаалаагүй гуурсгүй, хэвлийн сэлүүрийн суурийн урд харалдаа байрлана. Сүвний сэлүүр урт, сүүлний сэлүүр хүрнэ. Сүүлний сэлүүр дугуй. Өөхөн сэлүүргүй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийд түгээмэл тархалттай. Хэт загасчлалын нөлөөгөөр тархац нутгийнхаа аль нэг хэсэгт буурч байж болзошгүй. Гэхдээ популяцийн бууралт нь ховордлын зэрэглэлд оруулах шалгуур үзүүлэлтийг хангаагүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бус нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочк *et al.*, 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл, хууль бус агнуур түүний

тоо толгойд сөргөөр нөлөөлж байгаа ч одоогоор өргөн цар хүрээтэй биш тул дээрх зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Япон тэнгис, Шар тэнгис, Өмнөд Хятадын тэнгисийн эргээр түгээмэл тархсан. Хятадын Гуаньжоугаас өмнө зүг, Монголын Амар мөрний савын нуур, голууд, Тайвань, Япон (Хоккода болон Рюкю арлаас бусад), Солонгосын арал, Вьетнам (Берг, 1949; Choi *et al.*, 1990). Оросын Амар мөрний дээд эхээс (Ингода, Шилка, Аргунь, Кенон нуур) адаг Сунгур, Уссури, Ханка нуур, Сахалины баруун хойд хэсэгт тархсан (Никольский, 1956). Байгалийн савын Шакша нуурт 1932 онд нутагшуулснаар Сэлэнгэ мөрөнд тархжээ (Атлас пресноводных рыб России, 2003).

Монгол орны тархац, амьдрах орчин.

Буйр нуур болон Онон, Оршуун, Халх, Хэрлэн голд тархана (Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986). Оросын Байгаль нуур орчим нутагшуулсан нь Сэлэнгэ мөрнөөр байгалийн аясаараа тархан өнөөгийн байдлаар Ерөө, Орхон, Хараа, Туул гол болон Өгий нуурт суурьшсан (Баасанжав нар, 2004; Мэндсайхан нар, 2017; Аюушсүрэн нар, 2004). Тогтмол урсгалтай голын (5.1) зөөлөн



урсгалтай тогтуун, шаварлаг ёроолтой хэсэгт, цэнгэг уст нуур (5.5), намгархаг (5.4) цөөрмийн ургамал элбэгтэй, лаг шаварлаг хурдастай ёроолын хэсгээр амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 1 м, жин 8 кг (Вронский, 1960). 4-5 насанд бэлгэ боловсорно. Биеийн урт 35-37 см хүрэхэд 5-р сарын сүүлчээс 7-р сарын дундуур үржилд орно. Үржлийн үеийн усны температур $+16+18^{\circ}\text{C}$. Ургамал элбэгтэй дунджаар 0.5 м гүнтэй хэсэгт атуу 22,200-92,700, дунджаар 54,900 орчим түрс шахна. Ихэвчлэн агнуурын ач холбогдол багатай жижиг загас, усны шавжийн авгалдай, хавчаар хооллоно (Мэндсайхан нар, 2017а). Шөнийн цагаар идэвхтэй хооллоно.

Тоо толгой, нягтшил. Төлөвлөгөөт эдийн засгийн үед Буйр нуурын загасны аж ахуй нь жилд 207 тн загас олзворлож байжээ. Буйр нуураас 1954-1964 онд үйлдвэрлэлийн зориулалтаар олборлосон загасны 4%-ийг, 1970-аад оны үед 6.9%-ийг, 1980-аад оны үед 3.9%-ийг тус тус энэ зүйл эзэлж байжээ. Харин 2013-2015 оны судалгаагаар, баригдсан загасны 9.2%-ийг эзэлж байв (Мэндсайхан нар, 2017b).

Ховордлын шалтгаан. Төлөвлөгөөт эдийн засгийн үед Хятадад экспортолдог (3.1.3) байсан боловч 1990-ээд оноос хойш зах зээлд эрэлтгүй болсон. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэн усны түвшин буурах (7.1), эрчимтэй загас агнуур зэргээс шалтгаалан түүний тоо толгой буурах магадлалтай

ч одоогоор хорогдолд хүргэж буй өргөн хүрээний сөрөг нөлөөлөл тэмдэглэгдээгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын цулбуурт загас 19,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Түүний тархац нутгийн тодорхой хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай. Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

4.3. АМАРЫН ЦУРХАЙ

Esox reichertii (Dybowski, 1869)

Баг: Цурхай (Esociformes)

Овог: Цурхай (Esocidae)

Англи нэр: Amur pike

Ижил нэр: *Esox reichertii*



Таних шинж. Бие шувтан урт, суман хэлбэртэй, хүчирхэг шүдтэй. Нуруу бараан, хэвлий цайвар. Биеийн хажуугаар болон толгой дээр бөөрөнхий том хар бараан толботой. Хос бус сэлүүрүүд бараан толботой. Доод эрүү нь дээд эрүүг давсан. Нурууны сэлүүр сүвний сэлүүрийн харалдаа нуруунаас хойш байрласан. Заламгайн хавхалганы дээд хэсэг, шанаа нь хайрсаар хучигдсан. Хэвлийн сэлүүр биеийн дунд хэсэгт байрлана.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийд түгээмэл тархалттай. Хэт загасчлалын нөлөөгөөр тархац нутгийнхаа аль нэг хэсэгт буурч байж болзошгүй ч ховордлын зэрэглэлд оруулах нөхцөл бүрдээгүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлжээ (IUCN, 2024).

Бус нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко *et al.*, 2006). 2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшний хэлбэлзлээс шалтгаалсан амьдрах орчны доройтол, эрчимтэй загас агнуур, хууль бус агнуурт өртсөн ч эдгээр хүчин


зүйлс энэ зүйлийн популяцийг бүхэлд нь ховордуулахаар өргөн хүрээтэй биш тул дээрх зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний сав газрын эхээс (Оросын Аргунь, Шика, Ингода, Кенон нуур, Монголын Онон, Хэрлэн, Халх гол болон Буйр нуур) адаг (Уссури гол, Ханка нуур), Сунгари, Агнуурын тэнгисийн Уда, Түмэн, Амгунь гол болон Япон тэнгисийн Сайфун голын сав газар (Берг, 1949; Никольский, 1956) болон Сахалины Поронай, Тымь голд хүртэл тархсан (Сафронов нар, 2002; Атлас пресноводных рыб России, 2003).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур болон Онон, Оршуун, Халх ба Хэрлэн голд тархана (Дашдорж нар, 1976, 1977; Дгебуадзе, 1986). Тогтмол урсгалтай голын (5.1) урсгал намуун, ургамал ихтэй, гүехэн хэсэг, цэнгэг уст нуурын (5.5) ургамал бүхий эрэг болон гүн хэсгээр амьдарна.



Амьдралын онцлог. Биеийн урт 1.2 м, жин 16 кг. 4-5 насандаа бэлгэ боловсрох бөгөөд биеийн урт 35-42 см хүрэхэд 4-р сарын эцэс 5-р сард усны температурын хэмээс хамааран 73,000-236,500 орчим наалдамхай түрсээ ургамалд шахна. Жилийн бүх улиралд идэвхтэй хооллогч махчин загас.

Тоо толгой, нягтшил. Төлөвлөгөөт эдийн засгийн үед Буйр нуурын загасны аж ахуй нь жилд 207 тн загас агнаж байв. Буйр нуураас 1954-1964 онд үйлдвэрлэлийн зориулалтаар олборлосон загасны 77%-ийг, 1970-аад оны үед 17.5%-ийг, 1980-аад оны үед 19.7%-ийг Амарын цурхай эзэлж байжээ (Мэндсайхан нар, 2017b). Улс орон зах зээлийн эдийн засагт шилжин орсон 1990-ээд оны үеэс Дорнод аймгийн мах комбинатад харьяалагдаж байсан загасны цех хувьчлагдсанаар загас олборлох эрх бүхий хувийн компаниуд олборлолт хийдэг болсон. Харамсалтай нь олборлолтын талаарх статистик мэдээлэл байхгүй.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) хамаарсан усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, бохирдол (1), тороор (4.1.1.2) барьж (4.1) Хятадын зах зээлд борлуулах зэрэг эрчимтэй загас агнуурын нөлөөгөөр тоо толгой нь цөөрөх магадлалтай ч одоогоор нийт популяцийн хэмжээнд сөргөөр нөлөөлөхүйц аюул занал илрээгүй байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын цурхай загас 25,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Түүний тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан гүйцэтгэх, мөн зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

4.4. АРНОЛДЫН ЭРЭЭЛЖ

Triplophysa arnoldii (Prokofiev, 2002)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Arnoldi's spotted thicklip loach



Таних шинж. Биеийн урт 70 мм. Муна хэлбэртэй. Толгойн дээд болон хажуу тал маш шигүү бөөрөнхийдүү хар цоохор толботой. Нуруу, сүүл болон цээжний сэлүүрүүд тод эгнээ бүхий хар толботой. Бие хайрсгүй, гэхдээ толгой болон хэвлий харьцангуй том үү мэт арьсан товгороор бүрхэгдсэн. Ам доош эргэсэн. Дээд уруул үргэлжилсэн, доод уруул тасархай. Доод эрүү хүрз хэлбэртэй. Хамрын нүх бие биетэйгээ ойр байрласан. Нуруу болон ялгаруулах сүв орчмын сэлүүрийн үзүүр бараг шулуун. Хэвлийн сэлүүр нурууны сэлүүрийн суурийн харалдаа эсвэл бага зэрэг ард, эсвэл сүвний амсрын ар талаас эхэлнэ. Биеийн үндсэн зүс сааралдуу цагаан, толгой болон биеийн доод хэсэг цайвар, биеийн хажуугаар хоёр тууш эгнээ жигд бус хар толботой.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (NA).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийн популяцийн багахан хэсэг нь Монголд тохиолддог ч популяци нь тогтвортой бөгөөд өргөн тархацтай.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Тянь Шанийн нуруунаас баруун урагш Төв Азид Казакстан, Киргизстан болон Узбекистан хүртэл тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Ховд голын доод хэсгээр тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Монгол орны зөвхөн Ховд голын доод хэсгээр ховор тархсан цэнгэг усны зүйл. Нуур, гол, ус нь бохирдсон цөөрмийн эргийн хайрга чулуун ёроолтой хэсгээр амьдарна (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Манай орны хувьд болон дэлхийд тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтвортой ба буурах хандлага ажиглагдаагүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, суваг шуудуу, зам барилгын



ажлуудаас (4.1.6) улбаатай амьдрах орчны алдагдал, доройтол (1) болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн

засгийн үнэлгээ”-ээр Арнолдын эрээлж 2,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) судалгааг нарийвчилсан (3) хийх шаардлагатай.

4.5. ГОЛЫН АЛГАНА

Perca fluviatilis (Linnaeus, 1758)

Баг: Алгана (Perciformes)

Овог: Алгана (Percidae)

Англи нэр: European perch

Ижил нэр: *Perca fluviatilis*, *Perca fluviatilis zaissanica* (Dianov, 1955), *Perca fluviatilis Intermedius* (Svetovidov & Dorofeyeva, 1963), *Perca fluviatilis* (Linnaeus, 1758).



Ангилал зүйн тойм. Казакстаны Зайсан нуурт тархан амьдардаг голын алганы популяцийг *Perca fluviatilis zaissanica* (Dianov, 1955) гэдэг бөгөөд гэхдээ Эрчис болон Булган голын сав газрын популяцитай холбоотой эсэхийг судлах шаардлагатай (Kottelat, 2006).

Таних шинж. Бие хажуугаасаа бага зэрэг хавчгардуу. Нуруу хар ногоон, хоёр хажуу шаргал. Биеийн хоёр хажуугаар 5-9 хөндлөн хар ногоон судалтай. Өргөслөг, самлаг хатуу хайрстай. Толгой том. Эрүү, тагнайд олон эгнээ өргөслөг шүдтэй. Заламгайн хавхалганы хойд зах шөвгөр. Нурууны эхний сэлүүрийн төгсгөлд зууван хар толботой, хоёр дахь сэлүүр ногоон шаргал, хэвлий, сүв болон сүүлний сэлүүр улбар шар.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Популяцийн тоо толгой буурах ховордлын шалтгаангүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Ососк *et al.*, 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Өргөн тархалттай, одоогийн агнуурын

дарамт популяцийн хэмжээг эрс бууруулах хэмжээнд нөлөөлөхгүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П. Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Баруун Европоос Колым голын сав газар (Орос), Австрали, Шинэ Зеланд болон өмнөд Африкт нутагшуулсан (Атлас пресноводных рыб России, 2003; Ососк нар, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Булган гол, Сэлэнгэ мөрний сав газрын бүх нуур, голууд, Өгий, Тэрхийн Цагаан, Хөвсгөл нуурт тархсан (Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986). Тогтмол урсгалтай голын (5.1) урсгал намуун, ургамал ихтэй, гүехэн хэсэг, цэнгэг уст нуурын (5.5) ургамал бүхий эрэг болон гүнд, мөн задгай хэсгээр сүрэглэн амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 51 см (Атлас пресноводных рыб России, 2003), жин 2 кг. Бэлгэ боловсрох нас нь харилцан адилгүй. Өгий, Тэрхийн Цагаан нуурт 2-3



насандаа, Сэлэнгэ мөрөнд 4-6 насандаа, Хөвсгөл нуурт 6-7 насандаа бэлгэ боловсорч (Экология и хозяйственное значение рыб МНР, 1985), 4-р сарын сүүлчээс 6-р сарын эхээр усны ургамал элбэгтэй нуурын хоолой, голын эргийн ургамал дээр туузан хэлбэрийн (Аюушсүрэн нар, 2024) 9,500-67,700 орчим түрс гаргана. Тухайн нуурын тэжээллэг чанараас хамааран өсөлт нь харилцан адилгүй (Цэнд-Аюуш, 1969). Бие гүйцсэн голын алгана жижиг загас, агнуурын болон агнуурын бус загасны жарамгайгаар хооллоно.

Тоо толгой, нягтшил. Өгий нуураас жилд олборлосон загасны 22.3%-ийг эзэлж байсан (Баасанжав нар, 2001). 1997 онд Цагаан овооны хэсэгт 60.9%, Орхоны цутгал орчим 62%, Хоолойн голд 39.5%, Баян нуурт 9.2%-ийг тус тус эзэлж байв (Баасанжав нар, 2001). 1960-1966 онд олборлосон загасны 25% хүрч байсан бол 2001-2004 онд 35% болж өссөн (Мэндсайхан нар, 2017б).

Ховордлын шалтгаан. Загасны тор (4.1.1.2), уурга (4.1.1.1) ашиглан барьдаг. Энэ зүйлийн тоо толгой элбэг бөгөөд түүний популяцид өргөн хүрээнд эрс сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл одоогоор тэмдэглэгдээгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн

болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр голын алгана загас 9,600 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан гүйцэтгэж, зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

4.6. ЕРДИЙН ВАРЛАН

Phoxinus phoxinus (Linnaeus, 1758)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Common minnow

Ижил нэр: *Cyprinus phoxinus* (Linnaeus, 1758), *Leuciscus phoxinus* (Linnaeus, 1758).



Ангилал зүйн тойм. Монгол орны Сэлэнгэ мөрөн, Эгийн голоос барьсан хэлбэрүүд ч ангилал зүйн тодорхойгүй хэвээр байна. Цаашид энэ зүйлийн молекул генетикийн судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

Таних шинж. Биеийн урт нь 8-12.5 см, жин нь 9-10 г. Биеийн хажуугаар хөндлөн эгнээ 10-15 том бараан толботой. Бие нь уртассан, ээрүүл хэлбэртэй. Хажуугийн шугам тасалдан, үргэлжилнэ. Хамрын сүвний хоорондын зай түмбэгэр. Сүүлний сэлүүрээс бусад сэлүүрийн үзүүр нь дугуйрсан, бага зэрэг урт. Биеийн зүс хувьсал ихтэй. Түүний зүс нь нуруугаараа бараан ногоондуу алтлаг, хэвлийгээрээ шаргал ногоон, заримдаа ногоон саарал. Сэлүүрийн өнгө мөн л тодорхой бус, хөхөлбөр, улаан туяатай саарал, үржлийн үедээ шаргал болно. Биеийн зүс нь үржлийн үедээ илүү тодорч, хар ногоон болж, амны үзүүр болон цээж, хэвлий, сүвний сэлүүрийн уг тод улаан ягаан болно.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Тоо толгойн бууралтад хүргэх ховордлын ноцтой шалтгаан тодорхойлогдоогүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко *et al.*, 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд нэлээд өргөн тархалттай популяци тохиолдох бөгөөд тоо толгойн бууралт ажиглагдаагүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Баруун Европын голуудад уугуул тархалттай ба Оросын зүүн хэсэг, Монгол, Япон, Солонгост тархжээ.



Монгол орны тархац, амьдрах орчин. Булган, Шишхэд, Сэлэнгэ, Дэлгэр мөрөн, Идэр, Чулуут, Хануй, Хүнүй, Орхон, Ерөө, Хараа, Цөх, Хүдэр, Туул, Онон, Хэрлэн, Халх, Оршуун гол болон Хөвсгөл, Тэрхийн цагаан, Дархадын нуурууд, Өгий ба Буйр нуур зэрэг бараг бүхий л гол мөрөн, нуурт тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуур, голын түргэн урсгалтай хэсэг, эргийн дагуух амьдрах орчныг шүтэж амьдарна. Ихэвчлэн сүрэглэн идээшилдэг агнуурын бус загас.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд популяцийн тоо толгойн чиг хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Манай орны популяцийн тоо толгой, түүний чиг хандлагын талаар мэдээлэл хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаанд хүнсэнд хэрэглэх (3.1), газар тариалан (6.3.1), хөдөө аж ахуй (6.3.2), алт олборлолт (6.3.7)-ын гаралтай усны бохирдол болон өрсөлдөгчид (8.1), эрлийзжилт (8.4) зэрэг уугуул зүйлийн тоо толгойн өөрчлөлт хүчин зүйл багтана.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ердийн варлан загас 2,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн багахан хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчлан судалгаа хийх шаардлагатай.

4.7. ЕРДИЙН ЦУРХАЙ

Esox lucius (Linnaeus, 1758)

Баг: Цурхай (Esociformes)

Овог: Цурхай (Esocidae)

Англи нэр: Northern pike

Ижил нэр: *Esox reichertii* var. *baicalensis*, *Esox reichertii* var. *baicalensis*, *Esox lucius* var. *atrox*, *Esox lucius bergi*, *Esox lucius lucius* natio *wiliunensis*, *Esox lucius aralensis*, *Esox lucius*.



Таних шинж. Бие сунаж уртассан, толгой уртавтар бөгөөд биеийн уртын дөрөвний нэгийг эзэлнэ. Доод эрүүний хоёр талд 5 том мэдрэхүйн нүх бий. Дээд ба доод эрүү, тагнай, хэл дээр хүчирхэг шүдтэй. Доод эрүү нь дээд эрүүгээ давсан. Хайрс жижиг. Нурууны сэлүүр нь сүвний сэлүүрийн харалдаа байрлаж, нуруунаас хойш байрласан. Хэвлийн сэлүүр нь биеийн дунд хэсэгт байрлана.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийн зарим хэсэгт популяцийн тоо толгойн хандлага нь буурч байгаа ч нийт тархалтын хүрээнд популяцийн буурсан үзүүлэлт ажиглагдаагүй тул энэ зэрэглэлээр үнэлсэн.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко *et al.*, 2006). 2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Өргөн тархалттай, нийт популяцийн хандлага тогтвортой. Хууль бус загасчлал популяцийн тоо толгойд нөлөөлөх магадлалтай ба дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл, уул уурхайн нөлөөнд түүний амьдрах орчин болон үржлийн талбайн тодорхой хэсэг өртсөн ч тоо толгойд


бүхэлд нь сөрөг нөлөө үзүүлэхгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, А.Түвшинлхагва (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Европ, Ази, Хойд Америкт өргөн тархсан. Европт Хойд мөсөн далай, Балтийн тэнгис, Баренцев, Цагаан, Хар, Каспийн тэнгисийн савд түгээмэл тохиолдоно. Ази тивд Аралын тэнгисийн сав газар, Монголын Сэлэнгэ мөрний цутгал голууд, Дундад Азид Атрек, Амударь, Сырдарь голуудад тархжээ (Атлас пресноводных рыб России, 2003).

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ мөрөн, түүний цутгал голуудын адаг хэсэг, Өгий, Тэрхийн цагаан нуурт тархсан (Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986; Баасанжав нар, 2001). Ердийн цурхайг Баруун Монголын Дөрөө нуурт Оросоос нутагшуулсан (Мэндсайхан нар, 2017а). Тогтмол урсгалтай голын (5.1) урсгал намуун, ургамал ихтэй, гүехэн хэсэг, цэнгэг уст нуурын (5.5) ургамал бүхий эрэг болон гүн хэсгээр амьдарна.



Амьдралын онцлог. Биеийн урт 1.5 м, жин 35 кг. 3-4 насандаа бэлгэ боловсорч, 4-р сарын эцэс 5-р сард усны температур $+3+6^{\circ}\text{C}$ болох үеэс үржил эхэлж, нуурын эрэг, булан тохой, голын адаг орчмын тогтуун урсгалтай, 0.5-1.0 м орчим гүнтэй хэсэгт сүрэглэн атуу 14,800-121,000 орчим түрсийг эрэг орчмын ургамалд шахна. Жарамгайн үедээ голлон хөвмөл амьтад, шавжийн авгалдайгаар, харин бие гүйцсэн үедээ загасаар хооллоно (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Өгий нуураас үйлдвэрлэлийн зориулалтаар 1960-1965 онд олборлосон загасны 25%-ийг ердийн цурхай эзэлж байжээ (Цэнд-Аюуш, 1969). Харин 2001-2004 оны судалгаагаар, энэ нуураас барьсан загасны 9%-ийг эзэлж байв (Мэндсайхан нар, 20176).

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний багасалт (7.1), амьдрах орчны доройтол, бохирдол (1), үржлийн үед хууль бусаар уургаар (4.1.1.1) барьж хүнсэндээ (4.1) хэрэглэж байгаагаас үржлийн насны бодгалийн тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг

хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ердийн цурхай загас 36,500 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн хэмжээ (3.2), биологи, экологийн судалгааг (3.3) нарийвчлан гүйцэтгэх, мөн зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

4.8. МӨНГӨЛӨГ ХЭЛТЭГ

Carassius gibelio (Bloch, 1782)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Мөрөг (Cyprinidae)

Англи нэр: Prussian carp

Ижил нэр: *Carassius auratus gibelio* (Bloch, 1782), *Carassius bucephalus* (Heckel, 1837), *Carassius ellipticus* (Heckel, 1848), *Carassius vulgaris kolenty* (Dybowski, 1877), *Carassius vulgaris ventrosus* (Walecki, 1863), *Cyprinus gibelio* (Bloch, 1782).



Ангилал зүйн тойм. Монголд генетикийн хувьд ялгаатай хоёр хэлбэр бий (Rylková *et al.*, 2013).

Таних шинж. Биеийн урт 45 см, жин 1-2 кг. Биеийн хэмжээ өндөр, том хайрстай. Нурууны сэлүүр урт, өргөслөг цацрагтай. Сүүлний сэлүүр гүн ухлаадастай. Нуруу ногоовор хүрэн, биеийн хажуу мөнгөлөг. 6-7 насандаа 400-700 г, заримдаа 2 кг хүрнэ. Ихэвчлэн 15-20 см урттай, биеийн жин нь 200-350 г бодгалиуд таардаг (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочк *et al.*, 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд тархац өргөн, популяцийн хэмжээ их төдийгүй тоо толгойн бууралт ажиглагдаагүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Зүүн Европ болон Ази тэр дундаа Каспи, Хар болон Арал тэнгисийн савын нуур, голуудын уугуул зүйл бөгөөд Хятад, Орос, Зүүн Европын орнуудад ч түгээмэл тархалттай. Гэхдээ дэлхийн маш олон оронд нутагшуулсан учраас байгалийн тархац нутгийн хилийн зааг тодорхойгүй болж байна. Нутагшсан орчиндоо дасан



зохицох чадвар сайтай учраас түрэмгийлэгч зүйлд тооцогддог.

Монгол орны тархац, амьдрах орчин. Орхон, Хараа, Ерөө, Туул, Онон, Хэрлэн, Улз, Цөх, Халх гол болон Өгий, Хөх, Дөрөө Цагаан, Тээлийн Цагаан, Аварга тосон, Буйр, Дөрөө, Тээлийн цагаан нуурт тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Голын гүехэн тохой, цүнхээл, нуурын эргийн гүехэн хэсгийн усны температур харьцангуй өндөр хэсэгт байршижтай зүйл юм. Ургамал ихээр ургасан, урсгал тогтуун хэсгүүдэд олноор сүрэглэн идээшилдэг хэдий ч дасан зохицох чадвар өндөртэй. Хоёр таславч бүхий хийт цуухтай учраас хүчилтөрөгчийн хангамж багатай усанд ч амьдрах чадвартай (Maitland *et al.*, 2009).

Тоо толгой, нягтшил. Дэлхийд болон Монгол орны хувьд популяцийн хэмжээ, тоо толгойн өсөлт тогтвортой ба буурах чиг хандлага ажиглагдаагүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүнсэнд ашиглах (3.1), газар

тариалан (6.3.1), хөдөө аж ахуй (6.3.2), алт олборлолтын (6.3.7) гаралтай усны бохирдол болон гэнэтийн үхэл хорогдол (4) болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр мөнгөлөг хэлтэг загас 12,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) судалгааг тусгайлан зохион байгуулах шаардлагатай.

4.9. НАЙМАС ЭРЭЭЛЖ

Lefua costata (Kessler, 1876)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Eightbarbel loach

Ижил нэр: *Diplophysa costata* (Kessler, 1876), *Lefua costata costata*.



Ангилал зүйн тойм. Оросын судлаачдын *Lefua costata* гэж тодорхойлсон зүйл нь хоёр өөр зүйлийг хольсон байв (Kottelat, 2006). Япон, Солонгосын популяцид хийсэн молекул генетикийн судалгаагаар, ялгаатай зүйлүүд болох нь тодорхой болсон (Sakai et al., 2006).

Таних шинж. Биеийн урт ихэвчлэн 3-5.4 см, заримдаа 8-10 см хүрдэг, маш жижиг загас. Монголын Ташгай таван нуурын цутгал Шинэ усны голын наймас эрээлж нь 31-55 мм урттай, биеийн жин нь 0.21-0.74 г. Бие нарийн, урт. Нурууны сэлүүрийн өмнөд хэсэг нь цилиндр хэлбэртэй, түүнээс хойш бие нь хоёр хажуугаасаа хавчиг. Биеийн хажуугаар уртааш сунасан хар хүрэн судал нь сүүлний сэлүүр хүртэл үргэлжилнэ. Бие нь хайрсаар бүрхэгдсэн. Толгой нь хавтгай ба ам нь доош эргэсэн. Нэг хос нь хамрын нүхний ойролцоо, 4 хос нь хошууны урд, 2 хос нь завжинд нийт 8 хос сахалтай. Нүдний доор хатгуургүй. Нурууны сэлүүр нь хэвлийн сэлүүрийн харалдаа байрлана. Нурууны болон сүвний сэлүүр нь дугуйрсан, дээгүүрээ хүрэн толботой. Сүүлний сэлүүрийн дээд, доод хэсэгт арьс нь нугалардаг. Нуруугаараа

ногоон саарал болон хүрэн саарал, хоёр хажуу болон хэвлийгээрээ цайвар шаргал. Нуруу, цээж болон сүүлний сэлүүр хэд хэдэн эгнээ толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийд түгээмэл тархалттай ба загас агнуурт өгөөш болгон ашиглаж байгаагаас тархац нутгийн аль нэг хэсэгт буурч байж болзошгүй (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийн популяцийн багахан хэсэг нь Монголд тохиолддог боловч тогтвортой бөгөөд өргөн тархалттай, түүний тоо толгой, тархац нутаг буураагүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний ай савд Монгол, Хятад, Орос болон Солонгосын хойг, Японд тархана (Antonov et al., 2019).



Монгол орны тархац, амьдрах орчин. Азарга ба Шинэ усны гол, Тамсагийн булаг, Хайлаастайн гол болон Буйр нуурын савд багтах бусад жижиг голуудад тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Тогтуун урсгалт, элсэрхэг болон шаварлаг хурдас бүхий жижиг голын эргийн ургамал, шаварт сүргээрээ тархана (Antonov et al., 2019).

Тоо толгой, нягтшил. Популяцийн хэмжээ болон өсөлт тогтвортой ба буурах хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Манай орны популяцийн хэмжээ, түүний хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хуурайшилт, ган (7.1) зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр наймас эрээлж загас 2,580 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

4.10. ПОТАНИНЫ АЛТАЙН СУГАС

Oreoleuciscus potanini (Kessler, 1879)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Potanin's Altai osman

Ижил нэр: *Chondrostoma potanini* (Kessler, 1879), *Leuciscus pewzowi* (Herzenstein, 1883), *Oreoleuciscus choerocephalus* (Warpachowski, 1889), *Oreoleuciscus gracilis* (Warpachowski, 1889), *Oreoleuciscus herzensteini* (Warpachowski, 1889), *Oreoleuciscus ignatowi* (Nikolskii, 1902), *Oreoleuciscus similis* (Warpachowski, 1889), *Oreoleuciscus potanini recurviceps* (Nikolskii, 1902).



Ангилал зүйн тойм. Монголоос олдсон зүйлийг *Chondrostoma potanini* гэж тодорхойлж байсан бөгөөд Герценштейн (1883) *Leuciscus* төрөлд, Н.А. Варпаховский (1889) *Oreoleuciscus* төрөлд хамааруулж байсан. 1912 онд Л.С. Берг “Фауна России” бүтээлдээ *Oreoleuciscus* төрлийн ангилал зүйг шинэчилж, Обь мөрний эхэнд 3 зүйл Алтайн сугас *O. humilis*, *O. potanini*, *O. pewzowi* амьдардаг хэмээжээ. Түүнчлэн А. Дашдорж (Dashdorzh et al., 1969) болон бусад бүтээлүүдэд (Тугарина, Дулмаа, 1971; Дулмаа 1974; Васильева, 1982; 1985) Алтайн сугасыг *O. humilis*, *O. potanini*, *O. pewzowi* гэж тэмдэглэсэн байна. Зарим судлаач ганц зүйл (*O. potanini*)-д хамааруулан бичсэн (Иоганзен, 1940; Кафанова, 1961; Световидова, 1965; Дгебуадзе, Рябов, 1978; Дгебуадзе, 1982) байдаг бол зарим нь 5 хэлбэрт ялган тэмдэглэсэн (Рыбы МНР, 1983; Экология хозяйственного значение рыб МНР, 1985; Борисовец нар., 1984; 1985) байдаг. Генетикийн судалгаагаар, Потанины алтайн сугас *O. potanini* нь амьдрах орчин, идэш тэжээлийн онцлогоосоо хамааран махан

идэшт-нохой сугас, ургамал идэшт-шар сугас, шөвгөр хошуут хэмээх 3 хэлбэрийг үүсгэдэг (Слынько, Дгебуадзе, 2009).

Таних шинж. Бие нь уртассан ба толгой шовгордуу. Нуруу болон хоёр хажуу жижиг хайрстай ба хэвлийдээ хайрсгүй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл


Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийд түгээмэл тархалттай ба тархац нутгийнхаа хэмжээнд тоо толгой буурсан тухай баримтгүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко et al., 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд өргөн тархацтай, популяцийн хэмжээ тогтвортой тул Анхааралд өртөхөөргүй (LC) хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).



Дэлхийн тархац. Тувагийн Обь мөрний эхний Бий, Катунь, Оросын Чуя голын саваар болон Монголд тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгорын Хар, Хар-Ус, Дөргөн, Айраг, Хяргас нуур болон Ховд, Чоно харайх, Тээл, Завхан гол, Алтайн уулсын Хотон, Хоргон, Даян, Үүрэг, Ачит, Толбо нуур, түүний цутгал голууд, нуурт тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсцацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Монгол орны Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нууруудад тархсан. Өдөртөө нуурын гүн хэсэгт, шөнөдөө эргийн бүсийн ургамал шигүү ургасан хэсэгт идээшилнэ.

Тоо толгой, нягтшил. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нуур, голын агнуурын үндсэн загас бөгөөд агнуурын загасны 80%-аас дээш хувийг эзэлдэг (Мэндсайхан нар, 2017). Бүс нутагт популяцийн чиг хандлагын хувьд тогтвортой бөгөөд тархац нутаг нь багасаагүй (IUCN, 2024).

Ховордлын шалтгаан. Ховордлын гол шалтгаан нь биологийн нөөцийн ашиглалт (3) буюу хүнсэнд хэрэглэх юм.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.7-д зааснаар алтайн сугас загасыг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр

хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Потанины Алтайн сугас 15,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь Их нууруудын хотгорын нууруудыг хамгаалсан улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд болон Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газар зэрэгт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн хэмжээ (3.2) болон ашиглалт, хэрэглээний түвшин (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа явуулах нь чухал.

4.11. ШИВЭР САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula toni (Dybowski, 1869)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Siberian stone loach

Ижил нэр: *Cobitis toni* (Dybowski, 1869), *Nemacheilus toni* (Dybowski, 1869), *Noemacheilus barbatulus toni* (Dybowski, 1869), *Barbatula compressirostris* (Warpachowsky, 1897), *Nemacheilus sibiricus* (Gratzianov, 1907).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг анх Амар мөрний дээд цутгал болох Онон болон Ингода голуудаас тэмдэглэсэн (Dybowski, 1869). Иймд Монголын Онон голын популяци нь *B. toni* байх магадлал өндөр. Хэрлэн болон Сэлэнгийн сав газрын популяциудыг *B. toni* гэж нэрлэсэн ч баталгаажуулах шаардлагатай. Учир нь Сэлэнгийн сав газарт *Barbatula* төрлийн хэд хэдэн зүйл тархсан нь тогтоогдсон (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 10-18 см, жин нь 130 г. Бие нь өндөр биш, могойрхуу эсвэл муна хэлбэртэй. Дээд эрүүндээ 3 хос сахалтай. Сүүлний сэлүүр үл мэдэг ухлаадастай. Хайрс нь маш жижиг учраас бараг нүцгэн харагдах ба биеийн урд хэсгээрээ хайрсгүй. Зүс нь их хувирамтгай, ихэвчлэн нуруугаараа хүрэн саарал, хэвлийгээрээ цайвар. Биеийн хажуу болон нуруу дээгүүрээ хөндлөн хар толботой, заримдаа эдгээр толбо нь хөгждөггүй. Сэлүүрүүд улаан, улбар шаргалаас хүрэн саарал ба сүүл, нуруу, цээжний сэлүүрүүд хар толботой. Нүд хар (Гениатулин, 2009).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Популяци нь тогтвортой ба түгээмэл тархалттай тул энэ зэрэглэлээр үнэлсэн (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко *et al.*, 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд өргөн тархалттай том популяци бий, мөн тоо толгойн цөөрч, тархац нутаг нь хумигдах хандлага ажиглагдаагүй учир Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Орос, Хятад болон Монголын Амар мөрний сав газарт өргөн тархсан. Оросын нутаг дэвсгэрт орших Амар мөрний дээд хэсгээс урагш Хятадын газар нутгийн өмнөд хэсэг хүртэл (Antonov, 2012; Antonov *et al.*, 2019) болон Агнуурын тэнгисийн эрэг орчмын голууд, Хятадын



дорнод хэсгээс Солонгосыг хамруулан Зүүн Хятадын тэнгис хүртэл тархжээ (Chen *et al.*, 2019).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савын гол мөрөн, нуураар түгээмэл тархана. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Чулуурхаг хурдас бүхий жирэлзсэн урсгалд амьдардаг ёроолын загас юм. Ихэнхдээ 0.5-3 м гүнтэй хэсгүүдэд идээшилнэ. Ихэвчлэн цөөн тооны бодгалиудаар сүрэглэдэг амьдралын хэв маягтай ба өдрийн цагаар чулуу, ургамал дор нуугдана. Шөнө идэвхтэй идэш тэжээлээ хайна. Улирлын нүүдэл хийх ба хавар голын эх хэсэг рүү нүүдэллэж, өвөл голын цүнхээл хэсэгт идээшилнэ.

Тоо толгой, нягтшил. Популяцийн хэмжээ болон өсөлт тогтвортой ба буурах чиг хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Монгол орны популяцийн чиг хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүний үйл ажиллагаагаар бий болсон

далан, суваг шуудуу, зам барилгын ажлуудаас (4.1.6) үүдэлтэй амьдрах орчны алдагдал, доройтол болон газар тариалан (6.3.1), хөдөө аж ахуй (6.3.2), алт олборлолтын (6.3.7) гаралтай усны бохирдол болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр сахалт эрээлж загас 2,200 төгрөг байдаг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

4.12. ШИВЭР СУГАС

Leuciscus baicalensis (Dybowski, 1874)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Siberian dace

Ижил нэр: *Squalidus baicalensis* (Dybowski, 1874), *Leuciscus leuciscus baicalensis* (Dybowski, 1874), *Squalius suworzewi* (Warpachowski, 1889).



Ангилал зүйн тойм. Монгол орны *Leuciscus* төрлийн популяциудыг судлаачид *Leuciscus leuciscus baicalensis* хэмээсэн (Bogutskaya et al., 2004). Гэвч зарим судлаачид үүнийг бие даасан зүйл гэж тодорхойлдог (Баасанжав нар, 2001) ба газарзүй, морфологийн хувьд тодорхойгүй байдал илэрсээр байгаа тул цаашид ангилал зүйн асуудлыг тодруулах шаардлагатай (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 16-35 см, жин нь 32-350 г. Биеийн өндөр нь толгойн уртаас үл ялиг урт. Бие нь сунасан, мунархуу хэлбэртэй ба хажуугаасаа бага зэрэг хавчгар. Тэгш, жижиг амтай, хошуу нь монхор. Ам доош болон хагас доош эргэсэн. Сүвний сэлүүр бага зэрэг ховилтой эсвэл таслагдсан. Сүүлний сэлүүр нэлээд урт, 19 цацрагтай, гүн ухлаадастай. Бие нь мөнгөлөг цайвар, нуруугаараа хөхвөр саарал. Нуруу, сүүлний сэлүүр бараавтар хүрэн, хэвлий, сүв, цээжний сэлүүрүүд шаргал улаан.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко et al., 2006). 2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд өргөн тархацтай, том популяци байдаг бөгөөд популяцийн бууралт ажиглагдаагүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Обь мөрнөөс Колым хүртэл, Оросын Енисей мөрний саваар тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ мөрөн, түүний цутгал голууд, Орхон, Туул, Хараа, Ерөө, Булган гол, Өгий, Тэрхийн Цагаан нуурт тархсан. Дархадын



хотгорын доод Шишхэд, Доод Цагаан нуурт бүртгэгдсэн. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Голын элс, чулуурхаг хурдастай, түргэн урсгалт, гүехэн хэсэг, нуурын эргийн хүчилтөрөгчөөр баялаг урсгалтай хэсгээр зонхилон идээшилнэ. Өвлийн улиралд бага хөлдсөн эсвэл харзалсан хэсгийн ургамалтай усыг даган байршина. Үржлийн үед эр бодгалийн толгойн дээд хэсэг, нуруу, биеийн хажуугаар цагаан өнгийн эвэрлэг булцуу үүсдэг ба эм бодгалиуд бие гүйцэн үржихдээ эрээсээ илүү өнгөлөг харагддаг.

Тоо толгой, нягтшил. Популяцийн хэмжээ болон өсөлт тогтвортой бөгөөд буурах чиг хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Монгол орны популяцийн тоо хэмжээ болон хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Хууль бус агнуур, ашигт малтмалын олборлолт (алт г.м)-ын үйл ажиллагааны улмаас түүний амьдрах орчин доройтож, тоо толгойд нь сөргөөр нөлөөлж

байж болзошгүй боловч нийт тархац нутгийн хүрээнд тухайлсан ховордлын шалтгааныг илрүүлээгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр сугас 2,920 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Ангилал зүй (3.1), популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

4.13. ШИВЭР ЧИМХҮҮР ЗАГАС

Cobitis melanoleuca (Nichols, 1925)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Яралж (Cobitidae)

Англи нэр: Siberian stony loach

Ижил нэр: *Cobitis taenia melanoleuca* (Nichols, 1925)



Таних шинж. Биеийн урт нь 18 см, жин нь 10-15 г. Бие урт нарийн, тууз хэлбэрийн буюу хажуугаасаа хавчгар бөгөөд хайрсаар хучигдсан. Толгойг хоёр хажуугаасаа чимхсэн мэт хавчгар, гөлгөр гадаргуутай. Амны үзүүрт 4, угт 2 буюу нийт 6 сахалтай. Нүд нь нимгэн арьсаар бүрхэгдсэн. Нүдний доор сунадаг өргөслөг хатгууртай. Бие нь цоохор, нуруугаараа цайвар хүрэн, хоёр хажуугаараа элсэн шаргал, хэвлийгээрээ цайвар. Биеийн уртын дагууд хоёр хажуугаар нь нэг эгнээ хагас дугуйрсан өвөрмөц хар толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC). Тоотолгойн бууралтад хүргэх ховордлын ноцтой шалтгаан тодорхойлогдоогүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочк *et al.*, 2006). 2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд нэлээд өргөн тархалттай


популяци тохиолдох бөгөөд тоо толгойн бууралт ажиглагдаагүй тул Анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Европт Дон, Кубан, Волга, Урал болон Ияа голуудын сав (Perdices *et al.*, 2012) болон Азид Сибирийн ихэнх гол, мөрний сав газраас зүүн тийш Амар болон Хятадын Шар мөрний сав хүртэл тархсан. Казакстаны Нура гол, Приморийн болон Солонгосын хойгт тэмдэглэгдсэн (Froese *et al.*, 2025).

Монгол орны тархац, амьдрах орчин. Булган, Орхон, Онон, Хэрлэн, Туул гол болон Өгий ба Хөвсгөл нуур, Дархадын хотгорын нуур голуудаар тархана (Аюушсүрэн нар, 2024). Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Харьцангуй тогтуун болон түргэн урсгалтай голын хайрга, элсэн хурдас бүхий ёроол хэсгээр байршилтай (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн хэмжээ тогтвортой бөгөөд буурах чиг хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Манай орны популяцийн тоо толгойн талаар мэдээ, баримт хомс ч өргөн тархалттай.

Ховордлын шалтгаан. Загас агнуурт өгөөш болгон ашиглах, далан, суваг шуудуу, зам, барилгын ажлууд (1.4.6) болон газар тариалан (6.3.1), хөдөө аж ахуй (6.3.2), үйлдвэр (6.3.3), алт олборлолтоос (6.3.7) үүдэлтэй усны бохирдол зэрэг нь энэ зүйлд сөрөг нөлөөлтэй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар

сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр чимхүүр загас 2,100 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн багахан хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.14. ЭГЭЛ УЛААН НҮДЭН

Rutilus rutilus (Linnaeus, 1758)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Roach

Ижил нэр: *Cyprinus rutilus* (Linnaeus, 1758), *Leuciscus rutilus* (Linnaeus, 1758), *Gardonus rutilus* (Linnaeus, 1758).



Ангилал зүйн тойм. Сибирийн *R. rutilus* популяциудыг өмнө нь *R. r. lacustris* нэртэй дэд зүйл хэмээн үзэж байв (Берг, 1948). Хожим *R. Lacustris*-ийг бие даасан зүйл гэж үзэж байсан (Баасанжав нар, 2001) боловч *R. rutilus* хэмээх зүйлийн ижил нэр хэмээн дүгнэсэн (Bogutskaya et al., 2004).

Таних шинж. Биеийн урт 10-35 см, жин нь 0.7-1 кг. Нүд улаан. Толгой богино. Бие бага зэрэг бахим. Нурууны сэлүүр өндөр ба сүвний сэлүүрийн харалдаа байрлалтай. Хайрс харьцангуй том. Хажуугийн шугам биеийн дундаас нэлээд доогуур үргэлжилнэ. Нуруу хөх эсвэл ногоовор хүрэн, биеийн хоёр хажуу мөнгөлөг, заримдаа шаргал. Сүвний сэлүүрээс бусад нь саарал хүрэн, цээж болон хэвлийн сэлүүр нь улбар шар, цайвар улаан туяатай.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Осочко et al., 2006).


2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол оронд харьцангуй өргөн тархацтай, тоо толгойн хувьд бууралт ажиглагдаагүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Евразийн ихэнх хэсгээр уугуул зүйл ба тархалт нь Европоос Оросын зүүн нутаг хүртэл үргэлжилнэ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Орхон, Туул, Хараа, Ерөө, Цөх, Хүдэр, Идэр, Чулуут, Дэлгэрмөрөн, Эгийн гол болон Өгий, Тэрхийн цагаан, Хөвсгөл нуур, мөн Ховд аймгийн Булган голд түгээмэл тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Голчлон голын зөөлөн урсгалтай, тогтуун хэсэгт тархан амьдарна. Тэд цэнгэг усны зүйл ч суваг, цөөрөм болон дунд зэргийн бохирдол бүхий усанд оршин амьдрах чадвартай. Мөн тэнгисийн давстай усанд ч тохиолддог. Өсвөр насны загас нь бие гүйцсэнтэйгээ хамт идээшилнэ.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд популяцийн тоо толгойн чиг хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Манай орны хувьд популяцийн тоо толгой, түүний хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүнсэнд хэрэглэх (3.1), газар тариалан (6.3.1), хөдөө аж ахуй (6.3.2), алт олборлолтоос (6.3.7) үүдэлтэй усны бохирдол (7.1), ган, байгалийн гамшиг болон уугуул зүйлийн тоо толгойн өөрчлөлттэй холбоотой эрлийзжих (8.4) явц ихсэх зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр эгэл улаан нүдэн загас 7,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), ашиглалт, хэрэглээний түвшний (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

4.15. АМАРЫН ЗАНТГАР

Mesocottus haitej (Dybowski, 1869)

Баг: Алгана (Perciformes)

Овог: Живэрт (Cottidae)

Англи нэр: Amur sculpin

Ижил нэр: *Cottus haitej*



Таних шинж. Биеийн 40%-ийг эзлэх зантгар толгойтой. Бараан саарал, хүрвэтэр зүстэй ба цайвар хэвлийтэй. Арьс зузаан, бие жижиг өргөслөг товгороор хучигдсан ч зөвхөн хэвлийн хэсэгт хөгжөөгүй. Нурууны хоёр дахь сэлүүрээс хойш сүүлний уг хүртэл өргөн хар 3 хөндлөн судалтай. Нуруу, сүүл, цээжний сэлүүрүүд нь хөндлөн хар зураастай, сүвний болон хэвлийн сэлүүр цайвар. Сүүлний бариул богино. Хэвлийн сэлүүр богино ба сүвний сэлүүр хүрэхгүй. Нурууны сэлүүрүүд холбогдоогүй. Ам том, дээд доод эрүү тэгш, нүдний дунд хэсэг хүрнэ. Эрүү, тагнайдаа шүдтэй. Сүүлний сэлүүр дугуй. Заламгайн өргөс 4-6.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осочко *et al.*, 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орны популяцийн хэмжээ, хандлага,


хорогдлын шалтгааны талаар мэдээ, баримт хангалтгүй.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Монголын Онон голын сав газар, Оросын Амар мөрний савын дээд эхээс (Шилка, Аргунь, Онон, Ингода гол) адаг хүртэл, Уссури болон Сунгурийн сав газар, Хятад, Солонгосын хойд хэсэгт тархсан (Берг, 1949; Никольский, 1956; Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986; Рыбы МНР, 1983; Карасев, 1987).

Монгол орны тархац, амьдрах орчин. Амар мөрний савын Онон голын савд тархжээ. Тогтмол урсгалтай (5.1) харьцангуй хүйтэн устай голын эргийн чулуун дор нуугдан амьдардаг. Том голуудад хавар, намартаа тааралдана.



Амьдралын онцлог. Биеийн урт 20 см, жин 18-50 г. Атуу дунджаар 2,832-4,100 түрсийг 5-р сард гаргана. Түрсний голч 0.2-0.3 мм. Хөдөлгөөн багатай, ёроолын амьдралтай. Зонхилон өдөрч, хаварч, хоовгон, шумуулын авгалдай зэрэг ёроолын шавж, мөн загасаар хооллоно.

Ховордлын шалтгаан. Хорогдлын шалтгаан нь дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл, спорт загасчлалд өгөөш болгон ашиглах (3), зам барилгын ажлууд (1.4.6), дэд бүтцийн хөгжил, бэлчээрийн талхагдал (1.1.4.1), хүн амын суурьшил (1.4.2), ахуйн гаралтай органик бохирдол (6.3.2), бохир ус (6.3.2), хог хаягдал (6.9) зэргээс амьдрах орчин нь доройтож, тоо толгойд нь сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар

сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын зантгар загас 2,800 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.16. АМАРЫН СУГАС

Leuciscus waleckii (Dybowski, 1869)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Amur ide

Ижил нэр: *Idus waleckii* (Dybowski, 1869), *Leuciscus tumensis* (Mori, 1930).



Ангилал зүйн тойм. Түмэн голоос (Хятад, Солонгосын хил) гаралтай *Leuciscus* төрлийн загасны популяцийг *L. waleckii tumensis* гэж дэд зүйл болгосон (Chen, 1998). Хожим *L. waleckii* хэмээх бие даасан зүйл болгон ангилсан (Bogutskaya et al., 2004).

Таних шинж. Биеийн урт 20-35 см, жин 100-500 г. Бие өндөр, том мөнгөлөг хайрстай. Нүдний солонгон бүрхүүл шаргал, залгиурын шүд нь хоёр эгнээ, эгнээ бүртээ 3 шүдтэй. Сүвний сэлүүр нь богино. Нуруугаараа цайвар болон бараан саарал. Сүвний болон хэвлийн сэлүүрүүд нь улбар шар, цээжний сэлүүр илүү тод улаан шаргал туяатай.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Osock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Популяцийн төлөв байдлын талаар үнэлгээнд шаардлагатай мэдээлэл, судалгааны дүн хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Оросын Амар мөрний сав газраас Сахалинаар дамжин Япон тэнгисийн эх газрын эргийн дагууд Хятадын Шар мөрөн, Хойд Солонгос хүртэл тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин.

Хэрлэн, Онон, Балж, Адарга, Халх, Оршуун, Нөмрөг гол болон Буйр нуурт тархана. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуур, голын тогтуун урсгалтай, хайрга чулуу, элсэрхэг ёроолтой, эргийн ургамал дунд, булан тохойд сүрэглэнэ.

Тоо толгой, нягтшил. Популяцийн хэмжээ болон өсөлт тогтвортой бөгөөд буурах чиг хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Манай



орны популяцийн тоо толгой, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүнсэнд ашиглах (3.1) болон ган (7.1) зэрэг байгалийн гамшиг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн

засгийн үнэлгээ”-ээр Амарын сугас 5,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь Онон-Балжийн байгалийн цогцолборт газар, Нөмрөгийн дархан цаазат газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), ашиглалт, хэрэглээний түвшний (3.3) нарийвчилсан судалгаа болон мониторинг (3.9) хийх шаардлагатай.

4.17. АМАРЫН ХАВЧИГАС

Hemiculter varpachovskii (Nikolskii, 1903)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Зүүн Азийн мөрөг (Xenocyprididae)

Англи нэр: Amur bitterling

Ижил нэр: *Hemiculter leucisculus varpachowski* (Nikolskii, 1903).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг анх Буйр нуураас тодорхойлсон ба *Hemiculter leucisculus* гэх зүйлийн ижил нэр болон дэд зүйл эсвэл *H. bleekeri* зүйлийн дэд зүйл, мөн *H. lucidus* хэмээх зүйлийн ижил нэр болон дэд зүйл гэж авч үзсээр ирсэн. Хожим морфологи шинжээрээ ялгаатай, бие даасан зүйл хэмээн батлагдсан (Chen, 1998; Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 15-18 см, жин 50-90 г. Урт толгойтой, бие урт, нурууны сэлүүрийн сүүлчийн цацраг нь урт, салаалаагүй. Залгиурын шүд нь 3 эгнээ. Хажуугийн шугам нь өвөрмөц муруй буюу толгойн араас хэвлийн сэлүүрийн харалдаа хүртэл нэлээд огцом доошлон хойшоо тууш үргэлжилнэ. Нурууны сэлүүр богино. Нуруу бор ногоон, биеийн хажуу ба хэвлий мөнгөлөг цайвар. Сэлүүрүүд хар эмжээртэй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 он Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн популяцийн төлөв байдлыг үнэлэхэд шаардлагатай мэдээ, баримт, судалгааны дүн хангалтгүй тул Мэдээлэл дутмаг (DD) гэж үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Зүүн Азийн уугуул зүйл ба Амарын сав газар (Хятад, Орос, Монгол, Солонгос, Япон)-аас урагшаа Вьетнамын хойд хэсгийн Хуонг мөрний сав хүртэл тархана. Иран, Афганистан болон Узбекистанд нутагшуулсан (IUCN, 2024).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур болон Халх голд тархсан. Ус намгархаг газар (5), цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Цэнгэг уст нуур, голд түрс шахах үедээ Буйр нуурын 1-2 м гүнд сүрэглэн амьдардаг.



Тоо толгой, нягтшил. Дэлхийд болон манай орны популяцийн тоо толгой, хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Тархац нутгийн хүрээнд тухайлсан ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн

засгийн үнэлгээ”-ээр Амарын хавчигас загас 4,100 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй.

4.18. АМАРЫН ХӨӨЛӨНХЭЙ

Pseudorasbora parva (Temminck & Schlegel, 1846)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Stone moroko

Ижил нэр: *Leuciscus parvus* (Temminck & Schlegel, 1846), *Fundulus virescens* (Temminck and Schlegel, 1846), *Micraspius mianowskii* (Dybowski, 1896), *Pseudorasbora altipinna* (Nichols, 1925), *Pseudorasbora depressirostris* (Nichols, 1925), *Pseudorasbora fowleri* (Nichols, 1925), *Pseudorasbora monstrosa* (Nichols, 1925), *Pseudorasbora parva parvula* (Nichols, 1929), *Pseudorasbora parva tenuis* (Nichols, 1929), *Pseudorasbora parvus* (Nichols, 1929).



Таних шинж. Биеийн урт ихэвчлэн 2-8 см, заримдаа 11 см хүрнэ. Жин нь 5 нас хүрэх үед 13 г хүрнэ. Бие хажуугаасаа хавчиг. Ам жижиг, дээш эргэсэн. Сахалгүй. Том хайрсан дээр нь хагас саран хэлбэрийн бараан толботой. Нурууны өнгө бараан хөхвөр саарал, биеийн хажуугаар нарийн хар судал бүхий мөнгөлөг. Бүх сэлүүрүүд нь цайвар (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock *et al.*, 2006). 2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Популяцийн төлөв байдлыг үнэлэхэд шаардлагатай судалгааны баримт, мэдээ, үр дүн хангалтгүй тул Мэдээлэл дутмаг (DD) гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний сав (Хятад, Монгол), Солонгос, Тайван, Вьетнамын хойд хэсэг хүртэл тархсан ба Австри, Франц, Герман, Итали, Польш, Орос болон Англид нутагшуулсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэрлэн, Онон, Улз, Оршуун, Халх гол болон Буйр нуурын унаган зүйл бөгөөд Булган голын харь зүйл болохыг тогтоосон (Аюушсүрэн нар, 2024). Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Голын тогтуун урсгалтай, элс-шаварлаг хурдастай, ургамал бүхий хэсгийг даган байршина. Өсвөр насны загас бие гүйцсэн загастайгаа хамт идээшилнэ.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд популяцийн тоо толгой, хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Манай орны хувьд популяцийн тоо толгой, хандлагын талаар судалгааны баримт хомс.

Ховордлын шалтгаан. Тус зүйлийн тархац нутгийн хүрээнд тухайлсан ховордлын шалтгаан тодорхойгүй. Монгол орны хувьд Булган голд усан сүлжээгээр дамжин орж ирсэн бөгөөд цаашид тэдгээрийн тоо толгойн хяналтыг хийх шаардлагатай.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны

өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын хөөлөнхэй загас 6,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгааг хийж, популяцийн тоо толгойн хяналт, хязгаарлалтын (5.6) үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.19. АМАРЫН ЭРЭЭН ЖИВЭРТ

Cottus szanaga (Dybowski, 1869)

Баг: Алгана (Perciformes)

Овог: Живэрт (Cottidae)

Англи нэр: Siberian bullhead

Ижил нэр: *Cottus poecilopus* (Heckel, 1836); *Cottus szanaga* (Dybowski, 1869)



Ангилал зүйн тойм. Монгол-Оросын биологийн хамтарсан иж бүрэн экспедицийн судалгаагаар, Монгол орны Номхон далайн ай савын Амар мөрний савын голуудад *C. poecilopus* тархдаг хэмээн тэмдэглэсэн (Рыбы МНР, 1983; Баасанжав нар, 2001). *C. szanaga* нь *C. poecilopus* гэх зүйлийн ижил нэр хэмээн тэмдэглэжээ (Берг, 1948). Харин Holcik нар (1969) Онон голоос барьсан зүйлийг *C. szanaga* хэмээн тодорхойлсон бол Bogutskaya нар (2004) *C. szanaga*-ийг бие даасан зүйл гэж үзсэн.

Таних шинж. Бие уртавтар, биеийн зүс шар ногоон, хар хөндлөн судлуудтай. Биеийн хажуугаар 4-5 толботой, нэг нь сүүлний сэлүүрийн угт байна. Хэвлий цайвардуу, сүүлний сэлүүр ба цээжний сэлүүр дээгүүр бараан өнгийн толбо ихтэй ба нурууны сэлүүр дээгүүр тууш бараан судалтай. Бие нүцгэн, зөвхөн цээжний сэлүүрийн доод

талд маш жижигхэн цөөн ясархаг өргөстэй. Нурууны сэлүүр холбогдсон. Цээжний сэлүүр урт. Ам том. Хажуугийн шугам бүрэн бус, биеийн хажуугийн тэнхлэгийн дээгүүр байрласан.

Үнэлгээ ба үндэслэл


Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Ocock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийг үнэлэхэд популяцийн хэмжээ, тархалт, хандлага, хорогдлын шалтгааны талаарх судалгааны баримт хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П. Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).



Дэлхийн тархац. Номхон далайн ай савын Амар мөрний савд тархсан (Монгол, Орос, Хятад). Сибирьд тэмдэглэгдсэн (Атлас пресноводных рыб России, 2003; Kottelat, 2006; Ососк нар, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Онон голын сав газарт тархсан (Дашдорж нар, 1977; Дгебуадзе, 1986; Баасанжав нар, 2001). Тогтмол урсгалтай голын (5.1) элс, хайрган ёроолтой хэсэг, цэнгэг уст нуурт (5.5) тархан амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 17 см. 6-7 насална. Усны ёроолын шавжийн авгалдай болох өдөрч, хаварч, хоовгон, багшраа ялааны авгалдай, салаа сахалт хавчаас гадна, загасны түрс, жараахайгаар хооллоно. Ёроолын амьдралын хэвшилтэй, хад чулуун дор нуугдан амьдардаг, хөдөлгөөн багатай загас.

Ховордлын шалтгаан. Хорогдлын шалгаан нь дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл, биологийн нөөцийн ашиглалтын (3) чиглэлээр спорт загасчлалд өгөөш болгон ашиглах, зам барилгын ажлууд (1.4.6), бэлчээрийн талхагдал (1.1.4.1),

хүн амын суурьшил (1.4.2), ахуйн гаралтай органик бохирдол (6.3.2), бохир ус (6.3.2), хог хаягдлын (6.3.9) улмаас амьдрах орчин нь доройтож, хомсдох зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын эрээн живэрт 2,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.20. БАЙГАЛИЙН ОМУЛЬ

Coregonus migratorius (Georgi, 1775)

Баг: Яргай (Salmoniformes)

Овог: Цагаасар (Coregonidae)

Англи нэр: Baikal omul, Arctic cisco

Ижил нэр: *Salmo migratorius* (Georgi, 1775), *Coregonus migratorius migratorius* (Georgi, 1775), *Coregonus migratorius autumnalis* (Pallas, 1776).



Ангилал зүйн тойм. *Coregonus migratorius* нь зөвхөн Байгаль нуурт тархан үржлийнхээ үед цутгал голуудаа өгсөж, түрсээ шахна (Kottelat, 2006). Зарим судлаачид (Дулмаа нар, 1977; Баасанжав нар, 2001) энэ зүйлийг *C. m. autumnalis* гэх дэд зүйл болгон ангилж байв. Хойд мөсөн далайн ай савын томоохон цутгал голуудын (Обь мөрнөөс бусад) хооронд шилжилт хийж буй зүйлийг *C. autumnalis* гэж үзсэн (Kottelat, 2006).

Таних шинж. Бие мөнгөлөг цагаан зүстэй ба толбогүй, хайрс том. Ам тэгш, жижиг. Нүд том, духны $\frac{3}{4}$ эзэлнэ. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Заламгайн өргөс маш олон буюу 36-43.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Oscock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Үржлийн үед Байгаль нуураас Сэлэнгэ мөрөн өгсөж, Монголын Сэлэнгэ, Орхон голд


түрсээ шахдаг (Воронов, аман мэдээ) гэх боловч усны түвшнээс хамаарч жил болгон өгсдөггүй (Базов и др, 2016) гэжээ. Ийнхүү энэ зүйлийн тархалт, нүүдэл шилжилт, тоо толгой, хандлага, хорогдлын шалтгааны талаарх судалгааны баримт хомс учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, П.Цогтсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Г.Баасанжав, С.Гомбобаатар, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хойд мөсөн далайн ай савын Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав газар (Монгол, Орос) тархсан (Атлас пресноводных рыб России, 2003; Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ мөрөн, Орхон голд тархсан (Баасанжав нар, 2001). 1954-1956 онд Хөвсгөл нуурт (Дашдорж, 1957), академич А. Дулмаа 1984-1986 онд Хөвсгөл аймгийн Доод Цагаан, Завхан аймгийн Улаагчины Хар нуурт нутагшуулсан боловч амжилтгүй болсон.



Цэнгэг уст нуурын (5.5) гүн, задгай хэсэг, эргээр тархан амьдрах бөгөөд үржлийнхээ үед тогтмол урсгалтай голыг (5.1) өгсөн нүүдэллэж түрсээ шахна (Базов и др, 2016).

Амьдралын онцлог. Биеийн урт 56 см, жин 2.5 кг. Уг зүйл 6-7 насандаа бэлгэ боловсорч, 9-р сарын сүүлч 10-р сарыг дуустал цутгал голууд руу сүрэглэн өгсөж, усны температур $+2.0+1.4^{\circ}\text{C}$ хүрч буурахад түрсээ голын түргэн урсгалтай хэсгийн хайрга чулуунд атуу дунджаар 49,800 түрс гаргана. Гол өгсөн түрсээ шахаад нуур руу уруудна. Залуу бодгалиуд нь ихэвчлэн хөвмөл амьтдаар, бие гүйцсэн бодгалиуд хөвмөл амьтад болон ёроолын амьтдаар хооллоно.

Ховордлын шалтгаан. Агнуурын өндөр ач холбогдолтой загас (4.1.1). Орост тороор (4.1.1.2) эрчимтэй агнуур хийсний улмаас нөөц нь эрс багассан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй усны түвшний хэлбэлзэл, хүн амын суурьшил (1.4.2), хөдөө аж ахуй (6.3.1), ахуйн (6.3.2) болон үйлдвэрлэлийн гаралтай (6.3.3), бохир ус (6.3.8), хог хаягдлаас (6.3.9) улбаалсан амьдрах орчны доройтол, түрс шахах талбайн хэмжээ багасах нь түүний нөхөн үржилд сөргөөр нөлөөлөн ховордож байна. Монголын нутаг дэвсгэрт усны түвшин бага жил Сэлэнгэ мөрөн өгсөн хил гарч түрсээ шахдаг (Базов и др, 2016).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх (10.1.6), ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх (10.1.7), түүнчлэн гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах (10.1.9) зэрэг арга, хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Байгалийн омуль 32,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй. Мөн энэ зүйл загасны үржил, хөгжлийн хугацааг харгалзан үзэж Амьтны тухай хуульд заасан агнах, барихыг хориглосон хугацааг шинэчлэн өөрчлөх шаардлагатай.

4.21. БУЙРЫН МОНХОР ГҮРЦ

Microphysogobio tungtingensis (Nichols, 1926)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Long-nosed gudgeon

Ижил нэр: *Pseudogobio tungtingensis* (Nichols, 1926), *Abbottina tungtingensis* (Nichols, 1926).



Ангилал зүйн тойм. *Microphysogobio* төрөлд хамаарах зүйлийг Буйр нуураас анх *M. tungtingensis anudarini* нэрээр тодорхойлсон (Holcik et al., 1969). Хожим энэ дэд зүйлийг *M. tungtingensis* гэсэн бие даасан зүйл болгон авч үзэх болсон (Bogutskaya et al., 2004).

Таних шинж. Биеийн урт 8-10 см, жин нь 10-20 г. Гадаад төрхөөрөө хадаасан гүрцтэй төсөөтэй ч хошууны хэлбэр болон арай богино сахлаараа ялгагдана. Ам доош эргэсэн хагас саран хэлбэртэй. Залгиурын шүд нэг эгнээ. Завжиндаа хоёр богино сахалтай. Бие уртавтار, нурууны сэлүүр нь биеийн дунд хэсэгт байрлана. Ялгаруулах сүв нь хэвлийн сэлүүрт илүү ойр, сүвний сэлүүрээс урагш байрлана. Дундаж хэмжээний хайрстай ба хэвлий хэсэгтээ нүцгэн. Бие нь цайвар, бага зэрэг шаргалдуу. Биеийн хоёр хажууг дагасан тасархайтан үргэлжлэх судалтай. Бүх сэлүүрүүд өнгөгүй тунгалаг, толбогүй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT). Өмнө нь өргөн тархацтай гэж үзэж

байсан бол одоо Шар мөрний сав газрын дунд хэсэг дэх нуур, голуудаар тархалт нь хязгаарлагдсан. Энэ зүйл хөдөө аж ахуй болон үйлдвэрлэлийн гаралтай бохирдлын нөлөөнд ихээр өртөж байгаа ч 2007 оны судалгаагаар, тоо толгойг буурсан үзүүлэлт илрээгүй (Zhang and Li, 2007). Бохирдол нь нуурын ургамал бүхий амьдрах орчинд нөлөөлж популяцийн тоо толгой сүүлийн 10 жилд 30 хувь хүртэл буурсан тул энэ зэрэглэлээр үнэлэгдсэн. Уг зүйлийн популяци болон амьдрах орчны талаар нэмэлт мониторинг хийх шаардлагатай.


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Osock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Популяцийн төлөв байдлын талаар үнэлгээнд шаардлагатай судалгааны мэдээ, үр дүн хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрнөөс Хятадын Хөх мөрөн хүртэл тархсан.



Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур болон Халх голын адаг орчмоор тархана. Ус намгархаг газар (5), цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Ёроолын амьдралын хэлбэртэй загас. Нуурт ховор тохиолдоно. Голын урсгал багатай хэсгийн элс, хайрга шаварлаг ёроолтой хэсгээр амьдардаг.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтмол бууралт ажиглагдаж байгаа (IUCN, 2024) ба Монгол орны популяцийн хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь газар тариалан (6.3.1) ахуйн гаралтай усны бохирдол (6.3.2) болон ган (7.1) зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны

өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Буйрын монхор гүрц загас 3,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй.

4.22. БУЛУУ ЦАГААН

Cyprinus rubrofasciatus (Lacepède, 1803)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Мөрөг (Cyprinidae)

Англи нэр: Amur carp

Ижил нэр: *Cyprinus carpio rubrofasciatus* (Lacepède, 1803), *Cyprinus carpio haematopterus* (Temminck and Schlegel, 1846), *Cyprinus carpio* var. *Koi*, *Cyprinus carpio* var. *Nishikigoi*, *Cyprinus carpio* var. *Broadtail*, *Cyprinus carpio* var. *Ogon*, *Cyprinus carpio* var. *Shusui*, *Cyprinus carpio* var. *Asagi*, *Cyprinus carpio* var. *Bekko*, *Cyprinus carpio* var. *Doitsu*, *Cyprinus carpio* var. *Matsuba*, *Cyprinus carpio* var. *Ogon*, *Cyprinus carpio* var. *Shiro muji*.



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг өмнө нь *Cyprinus carpio haematopterus* (Temminck et Schlegel, 1846) хэмээн нэрлэж байсан бол хожмоо *Cyprinus rubrofasciatus* (Lacepède, 1803) гэж нэрлэх болсон (Kottelat, 2006; Dylidin et al., 2023).

Таних шинж. Биеийн урт 50-100 см, жин 2-5 кг. Урт, том, бүдүүн биетэй, алтлаг хайрстай. Хоёр хос сахалтай, захын хос сахал нь урт, дээд уруул дээрх сахал нь богино. Нуруу, сүвний сэлүүрийн эхний цацраг нь ясархаг, шүдлэг. Ам доош эргэсэн, их хөдөлгөөнтэй. Нуруу ногоовтор бор, биеийн хажуу алтлаг шаргал. Сэлүүрүүд нь бараан ба улбар туяатай. Амьдрах орчноосоо хамааран зүс нь хувьсдаг бөгөөд олон оронд гоёл чимэглэлийн зүйлүүдийг гарган авахад энэ шинжийг нь ашигладаг (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монголд агнуурт их өртдөг. Нэг ай саваас нөгөөд нутагшуулахад түрэмгийлэгч зүйл болох талтай. Хэдийгээр тархац нутгийн хэмжээ, тоо толгойн хувьд бууралт ажиглагдаагүй ч популяцийн тоо толгой, хорогдлын судалгаа, үнэлгээ хийх баримт, мэдээлэл хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний ай савд Монгол, Хятад, Орос болон Лаосын өмнөд



хэсгээс Вьетнам хүртэл тархсан бөгөөд Орос, Зүүн Азид нутагшуулсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Онон, Хэрлэн, Халх гол болон Дөрөө, Тээл, Бүрд, Буйр нуурт байгалийн цэвэр популяци тархсан. Сэлэнгэ, Орхон, Туул гол болон Өгий нуур, мөн Булган голд нутагшуулсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуур, голын эргийн гүехэн, хурдан халдаг хэсэг, гүн цүнхээл усны ургамлаар баялаг, шаварлаг хурдас бүхий хэсгийн ёроолоор сүрэглэн идээшилнэ. Гүн цүнхээлд өвөлжинө.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд өсөж байгаа (IUCN, 2024) боловч манай орны популяцийн хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт хомс. Нутагшуулсан болон үржүүлэг хийсэн ай савд түрэмгийлэгч зүйл болох боломж өндөртэй байгааг анхаарах шаардлагатай.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүнсэнд хэрэглэх (3.1) болон ган (7.1) зэрэг байгалийн гамшиг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр булуу цагаан загас 25,600 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), ашиглалт, хэрэглээний түвшний (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа, мониторинг хийж (3.9), үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.23. ГОЛУБЦОВЫН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula golubtsovi (Prokofiev, 2003)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Golubtsovi's stone loach

Ижил нэр: *Orthrias golubtsovi* (Prokofiev, 2003)



Ангилал зүйн тойм. Монгол орны Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Ховд голоос 2003 онд олж, шинжлэх ухаанд тэмдэглэсэн (Prokofiev, 2003).

Таних шинж. Биеийн урт нь 13 см, жин нь 12-15 г. Бие нь урт, хажуугаасаа хавчиг. Бага зэрэг сунасан боловч мохоо хэлбэрт хошуутай. Толгой нь хавтгайдуу, дээрээсээ гурвалжин харагдана. Гурван хос сахалтай. Жижиг хайрсаар хучигдсан учраас нүцгэн мэт харагддаг. Жижиг нүдтэй. Биеийн хажуугаар тасархайтсан хөндлөн хар судалтай. Сүүлний сэлүүр нь үл мэдэг ухлаадастай. Эр нь цээжний том сэлүүртэй ба үржлийн үед тэдгээрийн бие дээр жижиг товруунууд үүснэ. Бие нь шаргал саарал, хэвлийгээрээ цайвар. Нуруу болон сүүлний сэлүүр богино, тууш хар толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Мэдээлэл дутмаг (DD). Дэлхийд тоо толгой, тархац нутаг болон популяцийн хандлагын талаарх мэдээ, баримт хомс учир Мэдээлэл дутмаг (DD) гэж үнэлсэн (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац нутаг хязгаарлагдмал, популяцийн төлөв байдал, хандлагын талаар үнэлгээнд шаардлагатай баримт, судалгаа хангалтгүй учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).


Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Зөвхөн Монгол орны Ховд голд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Ховд голд тархана. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Голын хайрга, чулуун хурдас бүхий хэсгийг даган байршина. Хүчилтөрөгчийн дутагдлыг тэсвэрлэх чадвар сайтай.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд популяцийн тоо толгойн чиг хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Монгол орны популяцийн тоо толгой, хандлагын талаар судалгаа үгүй байна.



Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь далан, суваг шуудуу, зам барилгын ажлуудын (4.1.6) нөлөөгөөр амьдрах орчны алдагдал, доройтол болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Голубцовын сахалт

эрээлж 2,600 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн багахан хэсэг нь Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгааг хийж (3.9), үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.24. ДУХ ДАВХАА

Hypophthalmichthys molitrix (Valenciennes, 1844)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Зүүн Азийн мөрөг (Xenocypridae)

Англи нэр: Silver carp

Ижил нэр: *Leuciscus molitrix* (Valenciennes, 1844), *Leuciscus hypophthalmus* (Richardson, 1845), *Cephalus mantschuricus* (Basilewsky, 1855), *Onychodon mantschuricus* (Basilewsky, 1855), *Abramocephalus microlepis* (Steindachner, 1869), *Hypophthalmichthys dabryi* (Guichenot, 1871), *Hypophthalmichthys dybowskii* (Herzenstein, 1888).



Таних шинж. Биеийн урт 100 см, жин 10-16 кг. Тэжээлээ олж идэх онцлогоосоо шалтгаалан хурдан өсдөг ба 3-5 насандаа 50 см урт, 2 насандаа 500 г хүрнэ. Бие муна хэлбэртэй, урт. Толгой өргөн, дух төвгөр. Нүд маш доор, нүдний доод зах завжтай нэг түвшинд байрлана. Сахалгүй. Хэвлийн дагуу толгойноос төгсгөлийн сүв хүрсэн хянгатай. Нуруу болон толгойн дээд хэсэг ногоовор саарал. Биеийн хажуу болон хэвлийгээрээ мөнгөлөг саарал. Нуруу болон сүүлний сэлүүр нуруутай ижил өнгөтэй. Цээж, хэвлий болон сүвний сэлүүр цайвар, бага зэргийн шаргал туяатай. Солонгорсон мөнгөлөг зүстэй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT). Байгалийн тархац нутгийн хүрээнд усны барилга байгууламж барих, нуур голын бохирдол болон загасчлалын нөлөөнд өртөж байна. Ялангуяа далан энэ зүйлийн нөхөн үржлийг ихээр саатуулж байна. Амар мөрний популяци уг нөлөөлөлд бага өртөж байгаа хэдий ч Хятадын популяци барилга байгууламжийн нөлөөнд ихээр

өртсөнөөр буурч байна. Хятадын зүйлийн хүрээний бууралтаас хамааруулж Ховордож болзошгүй (NT) (шалгуур A2) гэж үнэлсэн.


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монголд маш ховор тохиолддог, ёроолын амьдралтай зүйл бөгөөд популяцийн төлөв байдлын үнэлгээг бүрэн хийхэд шаардагдах тархац, тоо толгойн судалгааны баримт хангалтгүй байгаа тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хятадын Шар, Хөх, Сувдан мөрний сав газраар өргөн тархсан зүйл. Оросын зүүн хэсгийн Амар мөрний сав газар болон Монголд тэмдэглэгдсэн. Загас үржүүлгийн болон замгийн хэт хөгжлийг хянах зорилгоор дэлхийн олон оронд нутагшуулсан. Хэд хэдэн оронд нутагшуулалтын дараа сөрөг нөлөөлөл үзүүлсэн мэдээлэл бий (IUCN, 2024).



Монгол орны тархац, амьдрах орчин. Оршуун, Хэрлэн гол болон Буйр нуурт тэмдэглэгдсэн. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуур, голын ургамал бүхий цэнгэг уст хэсгээр байршилтай. Үржлийн үед голоо өгсөнө. Үржсэний дараа нуурт сүрэглэн байршина. Намар орой цутгал голуудаа өгсөж тэндээ өвөлжинө.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд тоо толгой болон популяцийн хандлагын хувьд тогтмол бууралт ажиглагдаж байна (IUCN, 2024). Монгол орны популяцийн тоо толгой, төлөв байдал, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаанд махыг нь хүнсэнд хэрэглэх (3.1), далан, суваг шуудуу, зам барилгын ажлууд (4.1.6) зэрэг хүний үйл ажиллагаагаар бий болсон амьдрах орчны алдагдал, доройтол, ахуйн гаралтай усны бохирдол (6.3.2) болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх

хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дух давхаа загас 24,700 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржлийн биологи, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.25. ЕРДИЙН ГУТААРЬ

Lota lota (Linnaeus, 1758)

Баг: Сагамхай (Gadiformes)

Овог: Гутаарь (Lotidae)

Англи нэр: Burbot

Ижил нэр: *Gadus lota*, *Lota vulgaris* var. *obensis*, *Lota lota asiatica*, *Lota lota*.



Таних шинж. Бие уртавтар, төгсгөл рүүгээ хавчгар. Эрүүн доороо ганц сахалтай. Хайрс жижигхэн, циклойд хэлбэртэй. Толгой хавтгар өргөн. Эрүү, тагнайд өргөслөг шүдтэй. Нурууны болон сүвний сэлүүрүүд урт, нурууны сэлүүр цувраа 2 байх ба эхнийх нь богино, удаах нь урт. Сүүлний сэлүүр дугуй. Дээд эрүү нь доод эрүүг бага зэрэг давсан.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Популяцийн тархалт, тоо толгой, биологи, экологийн чиглэлээр үнэлэхэд шаардагдах судалгааны дүн хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг, А.Түвшинлхагва (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Хойд Америкийн хойд хэсэг, Англи, Шотланд, Ирланд, Франц, Италийн По голын сав газар, Швейцарын баруун хэсэг, Дунай мөрний сав, Балтын тэнгисийн

сав, Оросын Хойд мөсөн далайн ай савын бүх гол, мөрөн, нуурууд, Балт, Цагаан, Хар, Каспийн тэнгисийн сав, Сибирийн Обь мөрнөөс Анадыр хүртэл тархсан. Енисей мөрний сав, Байгаль нуур, түүний бүх цутгал голууд, Монголын Сэлэнгэ мөрний савын нуур, голуудад тохиолдоно.

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ мөрний сав газрын нуур голууд, Тэрхийн цагаан, Өгий, Хөвсгөл нуур, Дархадын Доод Цагаан нуурт, Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Оршуун, Халх гол, Буйр нуурт тархан амьдарна. Тогтмол урсгалтай голын (5.1) эх хэсгээр, цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 1 м, жин 24 кг. 3 насандаа бэлгэ боловсорч, өвөл мөсөн дор 12-р сарын сүүлчийн хагасаас 2-р сар хүртэл хугацаанд шөнө гүехэн устай хэсгийн цэвэр элс, хайрга, чулуун дээр 20,570-97,840 орчим, дунджаар 63,785 түрс гаргана. Шөнийн идэвхтэй махчин загас.

Ховордлын шалтгаан. Өвлийн улиралд мөс цоолон дэгээгээр (4.1.1.1) аялал жуулчлал, зугаа цэнгээн (1.4.3), хууль бусаар тор



тавьж (4.1.1.2) хүнс, ахуйн хэрэгцээнд (1.3.2.1) бага хэмжээгээр (1.3.2.2), заримдаа үйлдвэрлэлийн (1.3.2.3) зорилгоор их хэмжээгээр агнана. Дэлхийн дулаарал, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй уул уурхай (1.3.1), бэлчээрийн талхагдал (1.1.4.1), хүн амын суурьшил (1.4.2), ахуйн гаралтай органик бохирдол (6.3.2), хог хаягдал (6.3.9) зэргээс шалтгаан түүний амьдрах орчин нь доройтож байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна (25.1). Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй

(28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ердийн гутаарь загас 18,200 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж (3.9), үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх шаардлагатай. Мөн энэ зүйл загасны үржил, хөгжлийн хугацааг харгалзан үзэж Амьтны тухай хуульд заасан агнах, барихыг хориглосон хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

4.26. ЕРДИЙН ГҮРЦ

Gobio acutipinnatus (Men'schikov, 1939)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Markakul gudgeon

Ижил нэр: *Gobio gobio acutipinnatus* (Men'shikov, 1939), *Gobio acutipinnatus* (Men'shikov, 1939).



Ангилал зүйн тойм. *Gobio acutipinnatus* гэх зүйлийг Хятадтай хиллэх Эрчис мөрний сав газарт Казахстаны Маркакул нуураас анх тодорхойлсон. Тиймээс уг зүйл Өрөнгө голтой нийлж, Өлөнгөр нуурт цутгах ба Монголын Булган голд тэмдэглэгдсэн (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт нь 14-15 см, заримдаа 20 см, биеийн жин 80 г. Эр нь эмээсээ жижиг биетэй. Бие нь сунасан, муна хэлбэртэй. Залгиурын шүд 2 эгнээ. Сахал нь богино. Нурууны сэлүүрт 7 зөөлөн цацраг, хэвлийн сэлүүрт 13-16 цацрагтай. Нуруу алтлаг, элсэн шаргал, биеийн хажуугаараа арай цайвар шаргал, хэвлий хэсгээрээ цайвар. Нуруу болон сүүлний сэлүүрүүд бараан тасархайтсан судал хэлбэрийн толботой. Бусад сэлүүрүүд нь толбогүй саарал (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Osock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Үнэлгээнд шаардлагатай энэ зүйлийн тархац, тоо толгой, популяцийн төлөв байдал, хандлагын талаар хангалттай мэдээ, баримт хомс тул уг зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хятадын Алтай, Монгол, Орос болон Казакстан, Эрчис мөрний сав газарт тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Булган голд тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Голын эргийн урсгал бүхий хайрга, чулуун дор нуугдана. Цөөн тоогоор сүрэглэнэ. Ёроолын амьдралтай, тайван загас хэдий ч аюул тохиох үед маш хурдан нуугдана.



Тоо толгой, нягтшил. Дэлхий болон Монгол орны хувьд тоо толгой болон популяцийн хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүний үйл ажиллагаанаас улбаатай амьдрах орчны алдагдал, доройтол (1), харь зүйлийн түрэмгийлэл (1.5) болон өрсөлдөгчид (8.1), золиос, идэш тэжээл болох (8.3) зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ердийн гүрц загас 1,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газарт хамаарна.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж (3.9), үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.27. ЗАВХАНЫ САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula dsapchynensis (Prokofiev, 2016)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Dsapchyensis stone loach



Ангилал зүйн тойм. Монгол орны Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Завхан голын цутгал Богд, Чигэстэй голоос 2016 онд олж, шинжлэх ухаанд тэмдэглэсэн (Prokofiev, 2016) учир 2006 оны Монгол орны загасны Улаан дансанд ороогүй.

Таних шинж. Биеийн урт нь 10-18 см, жин нь 15-20 г. Бие хажуугаараа 3-4 эгнээлсэн болон замбараагүй байрлах бараан хүрэн толботой. Хоншоор нь өргөн, гурван хос сахалтай. Ам нь хагас доош эргэсэн саран хэлбэртэй, дээд эрүүндээ шүд шиг ургацагтай. Дээд уруул нь дундаа бага зэрэг цуулбартай. Маш жижиг хайрстай. Сүүлний сэлүүр нь ухлаадасгүй тэгш. Нуруугаараа хүрэн шаргал, биеийн хоёр хажуугаар алтлаг шаргал, хэвлий цайвар. Цээж, нуруу болон сүүлний сэлүүрүүд уртааш сунасан бараан хүрэн толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Тархалт хязгаарлагдмал, тоо толгой, хандлага, үржлийн биологийн талаарх үнэлгээнд шаардлагатай судалгааны баримт, дүн хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Зөвхөн Монгол орны Завхан голын сав газарт тархсан (Prokofiev, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Завхан голын цутгал Богд, Чигэстэй голд тархсан (Prokofiev, 2016). Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Өндөр уулын хүйтэн, түргэн урсгалт, голын жирэлзсэн хайрга, чулуурхаг хурдас бүхий хэсэгт амьдарна. Завхан аймгийн Улиастай хот дундуур урсах Завхан голын цутгал Богд, Чигэстэй голд хязгаарлагдмал тархацтай тохиолддог зүйл юм (Prokofiev, 2016).



Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн тоо толгой, хандлагын талаарх баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь далан, суваг шуудуу, зам барилгын ажлууд (4.1.6) зэргээс улбаалсан амьдрах орчны алдагдал, доройтол, ахуйн гаралтай усны бохирдол (6.3.2) болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Завханы сахалт эрээлж загас 2,800 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх нэн шаардлагатай.

4.28. КАРАБАНОВЫН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula karabanowi (Prokofiev, 2018)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Karabanowi stone loach



Ангилал зүйн тойм. Монгол орны Хойд мөсөн далайн ай савын Булган голоос 2018 онд олж, шинжлэх ухаанд тэмдэглэсэн (Prokofiev, 2018).

Таних шинж. Бие урт 8.6-11.4 см, мунархуу хэлбэртэй. Толгой хавтгай, шөвгөр хошуутай ба гурван хос сахалтай. Ам нь хагас доош эргэсэн ба саран хэлбэртэй. Завханы сахалт эрээлжтэй нэлээд төсөөтэй ч ялгаатай нь гөлгөр уруултай, дээд уруулын хөндлөн ухлаадас нь богино. Нуруундаа өвөрмөц хээжсэн жижиг хар толботой. Хайрс цөөтэй эсвэл хайрсгүй, зарим тохиолдолд зөвхөн нуруу болон сүүлний сэлүүрийн хооронд цөөн хайрстай. Хажуугийн шугам бүрэн, 75-88 хайрстай (Prokofiev, 2018). Нуруу шаргал бор хүрэн. Биеийн хажуу болон хэвлий элсэн шаргалдуу.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт хязгаарлагдмал ба тархац, амьдрах

орчин, үржил, популяцийн хэмжээ, төлөв байдлын талаар үнэлгээнд шаардлагатай судалгаа хангалтгүй учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Монгол оронд Ховд аймгийн Булган голд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Булган голд тархсан ба тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Өндөр уулын ширүүн урсгалтай голын хайрга, чулуун хурдас бүхий хэсэгт амьдарна.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд болон манай орны хувьд популяцийн хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Мэдээлэл байхгүй.



Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн ихэнх хэсэг Мөнххайрхан болон Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газруудад хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх нэн шаардлагатай.

4.29. КЕССЛЕРИЙН ЗАНТГАР

Leocottus kesslerii (Dybowski, 1874)

Баг: Алгана (Perciformes)

Овог: Живэрт (Cottidae)

Англи нэр: Kessler's sculpin

Ижил нэр: *Cottus kesslerii*, *Cottus kesslerii kesslerii*, *Cottus trigonocephalus*, *Cottus kessleri* var. *nudus*, *Cottus kessleri bauntovi*, *Paracottus* (*Leocottus*) *kessleri lubricus*, *Paracottus pelagicus*, *Paracottus kessleri arachlensis*, *Paracottus kessleri gussinensis*.



Таних шинж. Бие уртавтарт, сүүлний бариул богино. Бие саарал, биеийн хажуу хар толботой. Арьс маш жижигхэн цөөн өргөслөг товгороор хучигдсан. Бусад зантгар загастай харьцуулахад сүвний сэлүүр урт. Толгой том, өргөнтэйгөө бараг тэнцүү. Доод эрүү бага зэрэг дээш. Ам жижиг, нүдний наад зах хүрнэ. Нуруу, сүүл, цээжний сэлүүрүүд хөндлөн судалтай. Хэвлийн сэлүүр урт ба сүвний нүх хүрнэ. Заламгайн өргөс 4-6. Хажуугийн шугам бүтэн.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осочко *et al.*, 2006). 2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Популяцийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, баримт хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг (2025).


Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Оросын Байгаль нуур, түүний сав газрын жижиг нуур, голууд, Ангарт мөрний усан сангуудад, Монголын Сэлэнгэ мөрний адаг орчмоор тархсан (Решетникова, 2003; Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин.

Сэлэнгэ мөрөнд тэмдэглэгдсэн (Мэндсайхан нар, 2017; Аюушсүрэн нар, 2024). Тогтмол урсгалтай (5.1) харьцангуй хүйтэн устай гол, байнгын цэнгэг уст нуурын (5.5) эргийн чулуу, элсэнд шурган амьдарна.

Амьдралын онцлог. Биеийн урт 14 см. 7 нас хүрнэ. 2-4 насандаа бэлгэ боловсорч, 1,400-10,000 түрсийг хайрга чулуунд шахна. Атуух түрсээ хамгаална. Өсвөр насны загас нь гол төлөв усны ёроолын шавж, багшраа ялааны авгалдай, хоовгоно, цөөн өргөст хорхой, зөөлөн биетэн, загасны түрс, ургамлын үлдэгдлээр хооллоно (Базикалова нар, 1956).



Ховордлын шалтгаан. Дэд бүтцийн хөгжил (1.4), далан, суваг шуудуу татах (1.4.6), хүн амын суурьшил (1.4.2), ахуйн гаралтай (6.3.2) органик бохирдол, бохир ус (6.3.8), хог хаягдал (6.3.9) зэргийн улмаас амьдрах орчин нь доройтож, хомсдон сөрөг нөлөө үзүүлнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Кесслерийн зантгар загас 2,100 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.30. КОНИЛОБУСЫН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula conilobus (Prokofiev, 2016)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Conilobus's stone loach



Ангилал зүйн тойм. Монгол орны Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Завхан голын цутгал Богд, Чигэстэй голоос 2016 онд олж, шинжлэх ухаанд тэмдэглэсэн (Prokofiev, 2016).

Таних шинж. Биеийн урт нь 10-18 см, жин нь 15-18 г. Бие урт, шөвгөр хошуутай ба гурван хос сахалтай. Ам нь хагас доош эргэсэн ба саран хэлбэртэй. Дээд эрүүнд шүд шиг ургацагтай. Нуруугаараа хөндлөн тод эгнээлсэн толботой, биеийн хажуугийн толбо бүдэг. Сүүлний сэлүүрийн орчим цөөн тооны жижиг хайрстай эсвэл бараг хайрсгүй. Нуруу шаргалдуу бор хүрэн, биеийн хажуу ногоовтор шаргал, хэвлий цайвар шаргал. Цээж, нуруу болон сүүлний сэлүүрүүд уртааш сунасан, бараан хүрэн толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Хязгаарлагдмал тархацтай, тоо толгой, популяцийн төлөв байдал, хандлагын талаарх судалгааны баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Монгол орны Завхан голын сав газарт тархсан (Prokofiev, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгорын Завхан голын сав газрын эндемик зүйл. Завхан голын цутгал Богд, Чигэстэй голд бүртгэгдсэн (Prokofiev, 2016). Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Өндөр уулын хүйтэн түргэн урсгалт, голын хайрга, чулуурхаг хурдас бүхий жирэлзсэн хэсэгт амьдарна (Prokofiev, 2016; Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийд болон Монгол орны популяцийн тоо толгой, хандлагын талаарх судалгааны баримт хомс.

Ховордлын шалтгаан. Хүний үйл ажиллагаанаас улбаатай амьдрах орчны алдагдал, доройтол, дэд бүтцийн хөгжил, далан, суваг шуудуу, зам барилгын ажлууд (4.1.6), мөн ахуйн гаралтай усны бохирдол



(6.3.2) зэрэг нь энэ зүйлийн тоо толгойд сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Конилобусын сахалт

эрээлж загас 2,690 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.31. ЛАГОВСКИЙН ВАРЛАН

Rhynchocypris lagowskii (Dybowski, 1869)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Eastern Siberian minnow

Ижил нэр: *Phoxinus lagowskii* (Dybowski, 1869), *Lagowskiella lagowskii* (Dybowski, 1896), *Moroco yamamotis* (Jordan & Hubbs, 1925), *Pseudaspis bergi* (Jordan & Metz, 1913), *Rhynchocypris variegata* (Dybowski, 1869).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийн ангилал зүйн асуудал өнөөг хүртэл маргаантай хэвээр. Зарим судлаач *R. lagowskii* нь *R. steindachneri* болон *R. costata* гэх зүйлийн өөр насны бүлэг эсвэл үнэхээр бие даасан зүйл гэдэгт эргэлздэг (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 17-25 см ба бусад зүйлийн варланаас биеэр том. Биеийн жин нь 70-110 г. Бусад зүйлүүдээс ялгарах гол шинж нь биеийн хажуугаар үргэлжлэх өргөн бараан судал юм. Том нүдтэй. Хэвлий бүхэлдээ хайрсаар хучигдсан. Хажуугийн шугам нь бүтэн. Биеийн зүс тухайн амьдрах орны нөхцөлөөс хамааран хувьсана. Ихэвчлэн мөнгөлөг, нуруу бараавтар бор хүрэн, хэвлий цайвар саарал. Биеийн хажуу цайвар судалтай. Нуруу болон хажуу хэсэг жижиг толбоор бүрхэгдсэн. Усны температурын хэлбэлзлийг даган өнгө нь хувирна (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock et al., 2006).


2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Ангилал зүй, тоо толгой, түүний хандлага, үржил, экологийн чиглэлээр үнэлгээнд шаардлагатай мэдээ, баримт хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Монгол, Оросоос Шар мөрний сав хүрнэ. Хятад болон Японд өөр зүйлүүд тохиолддог байх талтай (Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ, Туул, Хэрлэн, Онон, Улз, Халх, Оршуун гол болон Буйр нуурт тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Нуур, голын урсгал бүхий эх хэсгээр байрших ба харьцангуй хүйтэн усыг шүтдэг. Жарамгай нь зундаа голын урсгал багатай тогтуун хэсгээр сүрэглэн идээшилнэ. Өвлийн улиралд хүчилтөрөгчөөр баялаг харз гарсан хэсгээс доош мөсөн доогуур урсгал бараадан амьдарна.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтвортой ба ямар нэгэн буурах хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Монгол орны хувьд популяцийн тоо толгой, төлөв байдал, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн хүрээнд ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын

загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Лаговскийн варлан загас 2,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн ангилал зүй, тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх нь нэн чухал.

4.32. МАНЖУУРЫН СУГАСАН ГҮРЦ

Gnathopogon strigatus (Regan 1908)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрцийнхэн (Gobionidae)

Англи нэр: Manchurian gudgeon

Ижил нэр: *Leucogobio strigatus* (Regan, 1908), *Gobio strigatus* (Regan, 1908), *Paraleucogobio strigatus* (Regan, 1908), *Paraleucogobius strigatus* (Regan, 1908).



Таних шинж. Биеийн урт 46-119 мм, дунджаар 63.6 мм, жин 1.14-19 г, дунджаар 3.6 г. Жилд дунджаар 12.3 мм, 2.75 г өснө. Урт, хавчиг биетэй. Ам нь тэгш, дээд, доод эрүүний урт тэнцүү. Богино сахалтай. Бусад гүрцүүдтэй харьцуулахад харьцангуй бараан. Нуруу шаргалдуу ногоон саарал, биеийн хажуу ногоовор алтлаг шаргалдуу, хэвлий шаргалдуу саарал. Биеийн хажуу өргөн судал ихтэй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Oscock *et al.*, 2006). 2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Зүйлийн тархац, популяцийн хэмжээ, хандлага, үржил, хөгжлийн талаарх судалгааны баримт хомс тул энэхүү зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний сав газар (Хятад, Орос, Монгол), Лиаохэ мөрний сав (Хятадын Хойд хэсэг, Солонгос)-д тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур, Халх голд тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуур, голд сүрэглэн амьдрах бөгөөд хайрга чулуун ёроолтой хэсгийг даган байршина. Зарим жил нуурын эрэг орчмын бүлээн усанд олон тоотойгоор сүрэглэн тааралддаг. Амьдрах орчны хувьд урсгал тогтуун хэсгүүдээр зонхилон идээшилнэ. Ёроолын амьдралын хэлбэртэй.



Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн тоо хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн хүрээнд ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Манжуурын сугасан гүрц 1,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж

зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.33. МОНГОЛЫН УЛААН ДАЛБААТ

Chanodichthys mongolicus (Basilewsky, 1855)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Зүүн Азийн мөрөг (Xenocyprididae)

Англи нэр: Mongolian culter

Ижил нэр: *Leptocephalus mongolicus* (Basilewsky, 1855), *Culter mongolicus* (Basilewsky, 1855), *Erythroculter mongolicus* (Basilewsky, 1855), *Culter rutilus* (Dybowski, 1872), Монгол догтор.



Таних шинж. Биеийн урт нь 20-60 см, дунджаар 30-33 см. Жин нь 1-2 кг хүрэх ба ихэнх тохиолдолд 500-600 г. Эр нь эмээсээ биеэр жижиг. Бие хажуугаасаа хавчгар, дунд зэргийн хэмжээтэй хайрсаар бүрхэгдсэн. Нуруу бөгтөр. Том, тэгш амтай. Доод эрүү бага зэрэг дээш өлгөр. Хэвлийн болон сүвний сэлүүрийн хооронд дугуйрсан хэсэгтэй, хянгагүй. Эрийн сүвний сэлүүр эмийнхээс урт. Нуруу ногоовор саарал юм уу хүрэн саарал. Биеийн хажуу мөнгөлөг. Нурууны сэлүүр болон сүүлний сэлүүрийн дээд илтэсийн ирмэг нь бараан. Хэвлий, сүүлний сэлүүрийн доод ирмэг болон сүвний сэлүүр улаан. Цээжний сэлүүр бараан (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн


тархац, популяцийн хэмжээ, хандлага, үржил, хөгжлийн талаарх судалгааны баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Зүүн Ази, Оросын амар мөрний сав газар болон түүний зүүн эргийн цутгалууд, Хятадын Шар мөрөнд тархсан. Амар мөрний сав газрын популяци харьцангуй салангид шинжтэй. Амар мөрний доод хэсгийн өмнөд цутгалууд, Тир мөрний эх болон цутгал хүртэлх доод урсгалууд, түүнчлэн Ханх нуурт ч тохиолдоно (Antonov et al., 2019).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур болон Халх голд тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Нуур, голын гүний амьдралтай махчин загас. Залуу бодгалиуд нь зуны улиралд эргийн гүехэн хэсгээр идээшилнэ. Намартаа өвөлжих газар буюу гол нуурын гүн рүү шилжинэ.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд өсөж байгаа (IUCN, 2024) боловч Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүнсэнд хэрэглэх (3.1) болон ахуйн гаралтай усны бохирдол (6.3.2) зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монголын улаан далбаат загас 28,300 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.34. МОРИН ТАВХАРАЛ

Hemibarbus labeo (Pallas, 1776)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Barbel steed

Ижил нэр: *Cyprinus labeo* (Pallas, 1776), *Gobio barbus* (Temminck & Schlegel, 1846), *Barbus schlegelii* (Günther, 1868), *Acanthogobio oxyrhynchus* (Nikolski, 1904), *Pseudogobio chaoi* (Evermann & Shaw, 1927), *Hemibarbus longianalis* (Kimura, 1934).



Таних шинж. Биеийн урт 60 см, жин 1-2 кг. Ихэвчлэн 20-25 см урт, жин нь 100-200 г, заримдаа 600-800 г. Том хэмжээтэй гүрцтэй төсөөтэй. Бие нь урт, бага зэрэг хавчиг. Духан дээрээ мэдэгдэхүйц ховилтой. Хошуу нь сунасан урт шөвгөр. Ам доош эргэсэн, хоёр сахалтай. Залгиурын шүд нь 3 эгнээ. Нурууны сэлүүр том, хурц өргөстэй. Том мөнгөлөг хайрстай. Нуруу ногоовор хүрэн, биеийн хажуу мөнгөлөг, хэвлий цайвар. Хэвлий, цээж, сүвний болон сүүлний сэлүүр нь шаргалдуу саарал. Биеийн өсөлт нь идэш тэжээл, орчны температур болон бусад хүчин зүйлсээс их хамааралтай (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац, популяцийн хэмжээ, хандлага, үржил, хөгжлийн талаарх судалгааны мэдээ,

баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний саваас Тингжианг мөрний сав хүртэл (Орос, Монгол, Хятад, Солонгос) болон Тайван хүртэл тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэрлэн, Халх, Оршуун гол болон Буйр нуурт тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуурын гол хэсгээр байршин амьдардаг идэвхтэй хөдөлгөөнтэй загас. Дулааны улиралд ургамалтай хэсгээр зонхилж, өвөл гүнд өвөлжинө. Голын цутгалын чулуурхаг, шаварлаг, элсэрхэг хурдас бүхий хэсгээр байнга идээшилнэ. Буйр нуурт нэлээд элбэг тархсан.



Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн тоо толгой, хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Монгол орны популяцийн тоо толгой, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын үндсэн шалтгаан нь хүнсэнд хэрэглэх юм.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр морин тавхарал загас 11,300 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.35. НУУРЫН ВАРЛАН

Rhynchocypris percunurus (Pallas, 1814)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Lake minnow

Ижил нэр: *Cyprinus percunurus* (Pallas, 1814), *Phoxinus percunurus* (Pallas, 1814), *Eupallasella percunurus*.



Ангилал зүйн тойм. Нуурын варланыг Европын зарим эрдэмтэд *Eupallasella* төрөлд хамааруулдаг. Судлаачид энэ зүйлийн нэршлийн хувьд нэгдсэн саналтай бус. *Phoxinus* төрлөөс их ялгаатайг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг нэг төрөлд нэгтгэх боломжгүй гэдэгтэй санал нэгдсэн (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 8-12 см, жин 15-20 г. Бие хавчгар. Ам жижиг, тэгш. Дээд эрүү богино. Жижиг хайрстай. Залгиурын шүд нь хоёр эгнээ. Сэлүүрүүд нь богино, нурууны сэлүүрийн үзүүр дугуйрсан, сүүлний сэлүүр их биш ухлаадастай. Бие нь ногоовор туяатай алтлаг шаргал, нуруу буюу хажуугийн шугамаас дээш жижиг хар цэгэн толботой. Нуруу, цээж, хэвлийн сэлүүрүүд нь дугуйрсан, улаавтар заримдаа улбар шаргал. Биеийн зүс нь нуур, голын усны тунгалагшилтаас хамааран өөр өөр байх нь бий. Тухайлбал, тунгалагшилт багатай усанд амьдрах загас цайвар, харин тунгалаг усанд бараан зүстэй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Ocock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн популяцийн хэмжээ, төлөв байдлын талаар үнэлгээнд шаардлагатай судалгааны баримт, үр дүн хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хойд мөсөн далайн ай савд Оросын баруун хэсгээс Колым хүртэл, Номхон далайн ай савд Амар мөрний ай саваас Солонгос, Япон хүртэл тархсан ба Италид нутагшуулсан.

Монгол орны тархац, амьдрах орчин.

Сэлэнгэ мөрөн, түүний цутгал, Эг, Үүр, Туул, Орхон, Сэлбэ гол болон Өгий, Хөвсгөл нуур, Номхон далайн ай савын Буйр нуур болон Хэрлэн, Онон, Улз, Халх голуудад тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Ердийн варланаас ялгаатай нь тогтуун, урсгал зөөлөнтэй, шаварлаг хурдастай, ургамал шигүү ургасан усанд сүрэглэн амьдарна. Зуны улиралд гол төлөв идэш тэжээлээ хайн усны гадарга, усны ургамалтай хэсгээр идээшлэх ба өвөл ялзмаг ихтэй хурдсанд шигдэн өвөлжинө.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн тоо толгой болон хандлагын хувьд тогтмол буурч байна (IUCN, 2024). Монгол орны хувьд популяцийн тоо хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын үндсэн шалтгааны тухай баримт бараг байхгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын

загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Нуурын варлан загас 2,300 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь нэн чухал.

4.36. ӨЛГӨР ЦАГААН

Culter alburnus (Basilewsky, 1855)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Зүүн Азийн мөрөг (Xenocyprididae)

Англи нэр: Topmouth culter

Ижил нэр: *Erythroculter aokii* (Oshima, 1919), *Culter recurviceps* (non-Richardson, 1846), *Culter brevicauda* (non Günther, 1868).



Таних шинж. Биеийн урт 30-35 см, жин нь 500 г. Ихэвчлэн 20-22 см, 100-160 г хүрнэ. Маш хавчгар биетэй учраас урдаасаа их хавчиг харагдана. Хар хайрсаар хучигдсан. Ам дээш өлгөр, амны заадал бараг босоо. Доод эрүү нэлээд дээш өлийж, дээд эрүүгээ давсан. Хэвлийн болон сүвний сэлүүрийн хооронд хянгатай ба уг хэсэгтээ хайрсгүй. Цээж болон хэвлийн сэлүүрийн хооронд хянгагүй, дугуйрсан бүтэцтэй. Нуруу ногоовтор саарал ба нурууны сэлүүр, сүүлний сэлүүрийн дээд илтэс нь мөн ижил өнгөтэй. Сул шаргал туяа бүхий мөнгөлөг зүстэй. Биеийн хажуу болон хэвлий мөнгөлөг цайвар. Үржлийн үед өнгө нь илүү тодордог. Эм нь эрээсээ илүү бараан зүстэй болно (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Oscock *et al.*, 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац нутаг, үржил, популяцийн

хэмжээ, төлөв байдлын талаар үнэлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгаа хангалтгүй тул уг зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Оросын Амар мөрний сав болон Зүүн хойд Хятадаас Солонгосын гол, мөрнүүд ба Улаан мөрний өмнөд хэсэг, Хайнан, Тайван, Хятад хүртэл тархсан (Bushuev *et al.*, 2012).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуурт тэмдэглэгдсэн. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуур болон цутгал голуудаар тархан амьдрах бөгөөд өдөр усны гүний ёроол хавиар, шөнө нь булан тохой, халиа хэсгээр идээшилнэ. Өвөл усны гүнд өвөлжинэ (Аюушсүрэн нар, 2024).



Тоо толгой, нягтшил. Дэлхийд тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтвортой ба буурах хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Монгол орны бүс нутагт популяцийн чиг хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын үндсэн шалтгаан нь хүнсэнд хэрэглэх болон ахуйн гаралтай усны бохирдол (6.3.2) зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн

засгийн үнэлгээ”-ээр Өлгөр цагаан загас 15,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь нэн чухал.

4.37. САВАДИГИЙН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula sawadai (Prokofiev, 2007)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Sawadai stone loach

Ижил нэр: *Orthrias sawadai* (Prokofiev, 2007)



Ангилал зүйн тойм. Энэ зүйл шинжлэх ухаанд анх 2007 онд тэмдэглэгдсэн (Dgebuadze, 2009).

Таних шинж. Биеийн урт тодорхойгүй боловч зарим эх сурвалжид 15 см хүрнэ гэсэн бий. Бие уртаашаа сунасан ба биеийг бүрхсэн жижиг дугуй толбонуудтай. Толгойдоо жижиг толботой. Эрийн цээжний сэлүүр нэлээд сайн хөгжсөн. Ерөнхийдөө цайвар хүрнээс саарал зүстэй. Бүх биеэр тодорхой хэлбэр, дүрсгүй олон толботой.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт хязгаарлагдмал ба популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлагын талаар үнэлгээнд шаардлагатай мэдээлэл, судалгааны дүн хангалтгүй тул уг зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав болон Енисейн савд тархсан (Dgebuadze, 2009).

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэлэнгэ мөрний савын Тээл болон Ерөө голд тэмдэглэгдсэн. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Өндөр уулын маш ширүүн урсгалтай голын хайрга чулуу, элсэрхэг хурдас бүхий хэсэгт амьдарна.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол оронд дахь популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага тодорхойгүй (IUCN, 2024).

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь далан, суваг шуудуу, зам барилгын ажлуудаас (4.1.6) үүдэлтэй хүний үйл ажиллагаагаар бий болсон амьдрах орчны алдагдал, доройтол, газар тариалан (6.3.1), хөдөө аж ахуй (6.3.2), алт олборлолтын (6.3.7) гаралтай усны бохирдол зэрэг болно.



Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон (1.1-ээс харна уу).

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь нэн чухал.

4.38. САХАЛТ ГҮРЦ

Romanogobio tenuicarpus (Mori 1934)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Eastern white fin

Ижил нэр: *Gobio gobio tenuicarpus* (Mori, 1934), *Gobio albipinnatus tenuicarpus* (Mori, 1934), *Gobio coriparoides tenuicarpus* (Mori, 1934), *Gobio tenuicarpus* (Mori, 1934).



Ангилал зүйн тойм. *Gobio albipinnatus tenuicarpus* (Holcik et al., 1969, Соколова, 1983) салбар зүйлийг *Gobio albipinnatus* (Mori, 1934) гэж үздэг (Баасанжав нар, 2001). *Gobio albipinnatus* нь Волга болон Урал голын савд амьдрах өөр зүйл бөгөөд *Romanogobio* төрөлд багтдаг (Bogutskaya et al., 2004).

Таних шинж. Биеийн урт 7-12 см, жин нь 20 г. 5 нас хүрэх үедээ 8-14 см урттай, 8-20 г жинтэй болно. Бие нь өндөр бус, нэлээд урт. Толгой нь нэлээд сунасан хэлбэртэй. Урт сахалтай, хажуугийн шугам нь 42-46 хайрстай. Хайрс нь том. Хүзүү хэсгээрээ хайрсгүй ба ам доош эргэсэн. Нуруу шаргал, саарал ба биеийн хоёр хажуу мөнгөлөг, 7-13 гүн хөх толботой. Хэвлий цайвар. Нуруу болон сүүлний сэлүүр жижиг хар толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Ангилал зүй, тархалт, үржлийн биологи, популяцийн хэмжээ, хандлага, нөлөөлөх хүчин зүйлс тодорхойгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний сав (Хятад, Орос болон Монгол), Хятадын зүүн хойд хэсэг болон Амар мөрнөөс урагш тохиолдоно.

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуурт тэмдэглэгдсэн. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Цэнгэг усны чанарыг тодорхойлогч зүйл. Гол мөрөн, нуурын



хүчилтөрөгчөөр баялаг, ширүүн урсгалтай хэсгийн ёроол хавиар идээшилнэ. Олноороо сүрэглэн амьдардаг онцлогтой. Зуны улиралд тунгалаг голын элсэрхэг болон хайргархаг хурдсанд, харин намар усны гүн рүү шилжинэ. Харин өвөл хонхорт орж, хавар мөс хайлсны дараа гарч ирнэ.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд популяцийн тоо толгой, хандлага тодорхойгүй (IUCN, 2024). Мөн манай орны хувьд ч энэ зүйлийн популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан одоогоор тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр сахалт гүрц загас 1,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.39. СОЛДАТОВЫН УРУУЛТ ГҮРЦ

Sarcocheilichthys soldatovi (Abbott 1901)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Amur marble gudgeon

Ижил нэр: *Chilogobio soldatovi* (Berg, 1914)



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг өмнө нь *Sarcocheilichthys nigripinnus czerckii* гэсэн дэд зүйл болгон ангилж (Соколова, 1983; Баасанжав нар, 2001) байсан бол хожим бие даасан зүйл болгон тодорхойлсон (Bogutskaya et al., 2004).

Таних шинж. Биеийн урт 8-12 см. Гадаад шинжээрээ шивэр гүрцтэй нэлээд төсөөтэй ба түүнээс ялгарах гол шинж нь өндөр, мунархуу биеийн хэлбэртэй, харьцангуй жижиг амтай. Ам хагас доош эргэсэн, уруул махлаг. Сахалгүй. Хажуугийн шугамын дагуу 6-7 бараан толботой. Нуруу хүрэн бор, биеийн хоёр хажуу цайвар. Нуруу болон биеийн хажуугийн заагт өргөн тод судал бий. Заримдаа тусгаар толбонууд мэт харагддаг. Нуруу болон сүүлний сэлүүр хар толботой. Хос ба сүвний сэлүүр нь толбогүй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл


Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006). 2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт, үржлийн биологи, популяцийн хэмжээ, хандлага, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдээ, баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний доод урсгал, Хятад, Оросын хил дагуу болон Монголтой хиллэх хэсэгт Буйр нуурын дээд хэсгийн эргэн тойрны голуудад тохиолдоно.



Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур, Халх голд тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Гол төлөв нуурт амьдардаг загас бөгөөд зундаа голын ус бүлээсэж, идэш тэжээл элбэгшсэн үед голын цутгал хавиар идээшилнэ. Шируун урсгалаас зайлсхийдэг ба ёроолын амьдралтай.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой болон популяци өсөх хандлагатай (IUCN, 2024) ба Монгол орны популяцийн тоо хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Солдатовын уруулт гүрц загас 2,300 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.40. СЭЛЭНГИЙН АЛТАЙН СУГАС

Oreoleuciscus manchin

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Selenge's Altai osman



Ангилал зүйн тойм. Хойд мөсөн далайн Сангийн далай нуур, Тэс гол, Увс нуурт тархдаг хэлбэр (Соколова, 1983) нь молекул генетикийн судалгаагаар, *Oreoleuciscus manchin* хэмээн тодорхойлогдсон (Слынько и др., 2009). *Oreoleuciscus manchin* нь олон морфологи шинжээр *Oreoleuciscus humilis*-ээс эрс ялгаатай (Мироновский и др., 2019) хэмээжээ.

Таних шинж. Биеийн урт 11-15 см, жин 10-40 г. Бие уртассан, ам тэгш ба жижиг, дээд болон доод эрүүний урт тэнцүү. Нуруу болон хажуу хэсэг жижиг хайрсаар хучигдсан, хэвлий хайрсгүй. Нуруу болон толгойн хэсгээрээ бараан саарал, хоёр хажуу мөнгөлөг бөгөөд биеийн дундаас хойш нэлээд бараан үргэлжилсэн толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлэх боломжгүй (NA).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт, үржлийн биологи, популяцийн хэмжээ, хандлага, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдээ, баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Тодорхойгүй.

Монгол орны тархац, амьдрах орчин. Увс нуурын цутгал Нарийн, Тэсийн гол, Сангийн далай нуур, Хүйтний гол, Тарна, Шилүүт болон Хар бухын голд тархсан. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуурын цутгал голууд, эрэг орчмын шаварлаг хурдас болон усны ургамал дунд амьдарна.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн тоо хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйл загасны тархац нутгийн хүрээнд ховордлын шалтгаан тодорхойгүй ч ганд (7.1) өртөж байж болзошгүй.



Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Увсын нуурын дархан цаазат газар болон Тэсийн голын байгалийн нөөц газарт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.41. ТАЧАНОВЫН ГҮРЦ

Ladislavia taczanowskii (Dybowski, 1869)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Tachazanovsky gudgeon

Ижил нэр: *Gobio taczanowskii* (Dybowski, 1869), *Gobio amurensis* (Dybowski, 1869), *Gobio amurensis* (Dybowski, 1869).



Таних шинж. Биеийн урт голчлон 7-10 см байх ба зарим бодгалиуд 15 см хүрнэ. Биеийн жин 15-22 г. Ам доош эргэсэн, богино сахалтай. Доод эрүү богино. Залгиурын шүд хоёр эгнээ. Хавтгай духтай. Нүд нь дагзны дээр шахам байрлах ба солонгон бүрхүүл мөнгөлөг. Нүдний өмнө хоншоор дээрээ жижиг цайвар товруутай. Том хайрстай. Нуруу, биеийн хажуугийн хайрс бараан эмжээртэй. Цээж, хэвлий, сүвний сэлүүрүүд дугуйвтар, эхний нэг цацраг тод ягаан. Нурууны сэлүүр биеийн дунд хэсгээс өмнөхөн байрлана. Биеийн зүс нь нуруугаараа ногоовтор хүрэн шаргал, хажуу нь алтлаг шаргал, хар хөндлөн толботой, хэвлий цайвар шаргал. Үржлийн үедээ эр загасны хэвлий, сүвний сэлүүрийн цацраг улаан болж толгой дээр цагаан эвэрлэг товгор үүснэ (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 он Мэдээлэл дутмаг (DD) (Осcock et al., 2006).


2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт, үржлийн биологи, популяцийн хэмжээ, хандлага, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдээ, баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний сав газар (Хятад, Орос, Монгол)-аас Ялу мөрний сав (Солонгос) хүртэл тархсан. Солонгосын хойгийн хойд хэсгийн голуудаас Оросын Амар мөрний савын зүүн хойд хэсэг хүртэл үргэлжлэн тархах ба Сунгар болон Уссури гол, Ханх нуурт тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Онон, Балж, Хурхын гол, түүний цутгал голуудаар тохиолдоно. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.



Амьдралын онцлог. Уулын голын урсгал ширүүн хэсэг, харгиа ихтэй хэсгийн доод урсгалд, гол төлөв цэнгэг уст горхиор амьдарна.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтвортой ба буурах хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн хүрээнд тухайлсан ховордлын шалтгааны тухай баримт байхгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн

болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Тачановын гүрц загас 3,600 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй.

4.42. ТОГТМОЛЫН ЦООХЛОЙ

Perccottus glenii (Dybowski, 1877)

Баг: Бүвэр (Gobiiformes)

Овог: Цоохлой (Odontobutidae)

Англи нэр: Amur sleeper, Chinese sleeper

Ижил нэр: *Eleotris pleskei*, *Eleotris dybowskii*



Таних шинж. Заламгайн хавхлаг цэнхэр ногоон, толгой дээр нүдний ард 2 эгнээ бараан судалтай. Бие урд хэсгээрээ зузаан бөөрөнхийдүү төгсгөл хэсэгтээ нарийссан. Нүд толгой дээр байрласан, доод эрүү уртсан дээд эрүүг давсан. Толгой нь дээрээсээ хавтгайвтар. Ам том. Сахалгүй. Доод эрүү дээр 3 эгнээ шүдтэй. Бие циклоид хэлбэрийн хайрсаар бүрхэгдсэн. Заламгайн хавхлаг дээр өргөс хатгуургүй. Хэвлийн сэлүүр хоорондоо нийлээгүй бөгөөд үүгээрээ бүвэр загаснаас ялгагдана. Хоёр дахь нурууны сэлүүр, сүвний сэлүүрүүд дугуйрч төгссөн, бүвэр загасныхаас богино, сүүлний сэлүүр бас дугуй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Oscock *et al.*, 2006).


2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт, үржлийн биологи, популяцийн хэмжээ, хандлага, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдээ, баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, А.Түвшинлхагва, Б.Мөнхзориг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Солонгосын хойд, зүүн арлууд, Хятадын хойд хэсэг, Алс Дорнод, Оросын Амар мөрний адаг ба дунд хэсэг, түүний цутгал Сунгар, Уссур болон Ханх нуур, Амар мөрний бэлчрээс Агнуурын тэнгист цутгах Тугур гол, өмнөө Владивостокоос Суйфун гол хүртэл тархжээ (Берг, 1948; Никольский, 1956).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуурын сав, Оршуун, Халх голд тархсан. Монгол-Оросын хилийн ойролцоо Сэлэнгэ мөрнөөс 8 бодгаль баригдсан (Түвшинлхагва нар, 2016). Тогтмол урсгалгүй гол (5.2), намаг, намгархаг газар (5.4), цэнгэг уст нуур (5.5), улирлын чанартай байнгын бус цэнгэг устай нуур (5.6), байнгын цэнгэг устай намаг, цөөрөмд (5.7) шаварт шигдэн амьдарна. Тогтмолын цоохлой нь янз бүрийн нөхцөлд тэсвэртэй, амархан дасан зохицох чадвартай загас юм (Мэндсайхан нар, 2017).



Амьдралын онцлог. Биеийн урт 25 см, жин 250 г хүрнэ. 2 насандаа бэлгэ боловсорч, 6-р сараас 7-р сар хүртэл усны хэм $+15+20^{\circ}\text{C}$ болоход усны гүехэн хэсэгт ургамал дунд 1,000 орчим түрс гаргаж, атуух түрсээ хамгаална. Шавж, тэдгээрийн авгалдай болон жижиг хавч хэлбэртэн, загасны жараахай, ялангуяа агнуурын ач холбогдолтой загасны түрсийг иднэ. Энэ зүйл загас элдэв идэштэй, ховдог тул уугуул зүйлд ихээхэн хохирол учруулдаг ачаарал татдаг.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн тоо толгой болон хандлага тогтвортой ба буурах хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Манай орны популяцийн хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэн жижиг нуур, цөөрмүүд хатаж ширгэх, хөдөө аж ахуй (6.3.1), ахуйгаас (6.3.2) үүсэх бохирдол бол энэ зүйлийг ховордоход нөлөөлөх үндсэн шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны

өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Тогтмолын цоохлой загас 2,300 төгрөг. Холбогдох хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.43. ТОЛБОТ МОРИН ЗАГАС

Hemibarbus maculatus (Bleeker, 1871)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүр (Gobionidae)

Англи нэр: Spotted steed

Ижил нэр: *Barbus semibarbus* (Günther, 1889), *Acanthogobio paltischevskii* (Nikolskii, 1904), *Hemibarbus joiteni* (Jordan & Starks, 1904), *Hemibarbus longibarbis* (Fang, 1938).



Таних шинж. Биеийн урт 27 см, жин 390 г. Ам доош эргэсэн, амны захад сахалтай. Нурууны сэлүүр өндөр, гөлгөр өргөстэй. Морин тавхралаас ялгаатай нь уруул нимгэн, богино мохоо хошуутай. Хайрс бүр нь сууриараа тод толботой. Мөрөгийн овгийн бусад загаснаас ялгагдах нэг онцлог бол эр нь эмээсээ биеэр том. Зүс нь гүрцтэй төсөөтэй. Нуруу сааралдуу шаргал, жижиг хар толбо ихтэй ба биеийн хажуу биеийн дагууд том хар толботой. Нуруу болон сүүлний сэлүүр нь нуруу хэсэгтэйгээ ижил ба толборхог. Цээжний болон сүвний сэлүүр нь өнгөгүй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Ососк *et al.*, 2006). 2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт, үржлийн биологи, популяцийн хэмжээ, хандлага, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдээ, баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хятадын Шар мөрний саваас Амар мөрний сав газар хүртэл (Хятад, Орос, Монгол) тархана. Амар мөрний өмнөд хэсгээс дунд руу болон баруун хойд Сахалин, Сладкой, Успенковский нууруудыг багтаасан Амар Лиман, Лангри, Чингай голын адаг хүртэл тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэрлэн, Халх, Оршуун гол болон Буйр нуурт тархан амьдарна. Ус намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуурын булан, тохойн эрэг орчмын гүехэн хэсгээр, бие гүйцэхээрээ гүнд амьдарна. Хавар, зундаа нуураас гарч, голын урсгал бүхий хэсэг орчим бөөгнөрөн үржлийн сүрэг үүсгэнэ. Бие гүйцсэн бодгалиуд нуурын аль ч хэсэгт амьдрах чадвартай.



Тоо толгой, нягтшил. Дэлхийд тоо толгой болон популяцийн хандлагын хувьд буурах хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэн жижиг нуур, цөөрмүүд хатаж ширгэх, хөдөө аж ахуйгаас (6.3.1) үүсэх бохирдол нь энэ зүйлийг ховордоход нөлөөлөх үндсэн шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх

хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр толбот морин загас 3,500 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу).

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.44. ТЭСИЙН ЭРЭЭЛЖ

Triplophysa gundriseri (Prokofiev, 2002)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Эрээлж (Nemacheilidae)

Англи нэр: Gundriseri's spotted thicklip loach

Ижил нэр: *Triplophysa gundriseri chandagaitensis* (Prokofiev, 2002)



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг *Triplophysa gundriseri chandagaitensis* (Prokofiev, 2002) гэсэн салбар зүйлийн түвшинд ангилж байсан бөгөөд одоо *T. gundriseri* гэх бие даасан зүйл болгон ангилах (Prokofiev, 2016; Sheiko, 2013) болсон.

Таних шинж. Биеийн урт нь 20-25 см, жин нь 80-100 г. Бие нь урт, хажуугаасаа хавчгар. Толгой цилиндр хэлбэртэй. Уруул нь атираатсан, эрүү нь гол төлөв жижигхэн гурвалжин арьсан ургацагтай. Ам нь гурван хос сахлаар хүрээлэгдсэн ба нүдний хойд зах хүрнэ. Бие нүцгэн. Хамрын сүв хоорондоо ойрхон. Сүүлний сэлүүрийн ухлаадас бага (Мэндсайхан нар, 2017). Нуруу бор хүрэн, хажуу бөөрөнхий бараан толботой. Нуруу болон сүүлний сэлүүрүүд нэг эгнээ хар толботой.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock *et al.*, 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт хязгаарлагдмал ч популяцийн төлөв

байдлын талаар үнэлгээнд шаардлагатай мэдээ, баримт хангалтгүй учир уг зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).


Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Тува, Орос, Монгол орны баруун хойд хэсгийн Тэс, Нарийн гол, Хоят, Үхэг, Хандгайт гол болон Увс нуурын ай савын цутгал голуудад тархсан (Kottelat, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Тэсийн гол, Хөвсгөл аймгийн Сангийн далай нуурт тохиолддог. Ус намгархаг газар (5), цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Хүйтэн, хурдан урсгалт голд амьдардаг. Зундаа нуур, голын гүехэн устай, ургамалтай хэсгээр идээшилнэ. Өвөлдөө нуурын гүн рүү шилжинэ (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн тоо толгой болон чиг хандлага тогтвортой (IUCN,



2024). Харин манай орны хувьд популяцийн тоо хэмжээ, хандлага тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаар мэдээ, баримт хомс.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн

засгийн үнэлгээ”-ээр Тэсийн эрээлж загас 2,530 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Тэсийн голын байгалийн нөөц газарт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.45. УЛААН ЖИВЭРТ

Pseudaspius leptocephalus (Pallas, 1776)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Cyрас (Leuciscidae)

Англи нэр: False asp

Ижил нэр: *Cyprinus leptocephalus* (Pallas, 1776), *Aspius leptocephalus* (Pallas, 1776), *Leuciscus leptocephalus* (Pallas, 1776).



Таних шинж. Биеийн урт 60 см, жин 1.9 кг. Бие нь уртассан, хажуугаасаа хавчгар, жижиг зөөлөн мөнгөлөг хайрсаар бүрхэгдсэн. Толгой урт, нарийн духтай, хошуу нь шөвгөр, том амтай. Доод эрүү, дээд эрүүг үл мэдэг давсан урт. Залгиурын шүд хоёр эгнээ. Жижиг шаргал нүдтэй. Нүдний солонгон бүрхүүлийн дээд хэсэгт ногоон толботой. Энэхүү загасны хамгийн өвөрмөц шинж нь улаан уруултай. Хос бус сэлүүрүүд нь жижиг. Жижиг хайрстай. Нуруугаараа цэнхэрдүү-саарал, нурууны сэлүүр саарал, цээжний сэлүүр улаан шаргал, хэвлий, сүв болон сүүлний сэлүүр улаан өнгөтэй. Нурууны сэлүүр ягаавтар, бусад сэлүүрүүд улаан (Аюушсүрэн, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бус нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock *et al.*, 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт хязгаарлагдмал ч популяцийн төлөв байдлын талаар үнэлгээнд шаардлагатай

мэдээ, баримт хангалтгүй учир уг зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).


Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Орос, Хятад, Монголын Амарын мөрний сав, Ханх нуурын дээд эхээс Амарын цутгал хүртэл тархана. Уда, Өгүт гол, Сахалины баруун хойд голуудад мөн тохиолдоно.

Монгол орны тархац, амьдрах орчин.

Буйр, Хэрлэн, Онон, Оршуун, Халх голд тохиолдоно. Ус, намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Голын урсгал ихтэй хэсэгт амьдрахад зохилдсон. Зун Халх голын адаг болон Оршуун голын эхээр идээшилж, өвөлдөө Буйр нуурт ирж өвөлжинө. Өвлийн улиралд гүн цүнхээл, нүхэнд орж бараг хооллохгүй тайван байдалд ордог.



Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн тоо толгой, хандлагын хувьд буурах хандлага ажиглагдаагүй (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Энэ загасыг хүнсэнд өргөн хэрэглэдэг бөгөөд үүний улмаас ховордох магадлалтай.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг

удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр улаан живэрт загас 20,100 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.46. ХАДААСАН ГҮРЦ

Saurogobio dabryi (Bleeker, 1871)

Баг: Мөрөг (Cypriniforme)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Lizard gudgeon

Ижил нэр: *Armatogobio dabryi* (Bleeker, 1871), *Gobiosoma amurensis* (Dybowski, 1872), *Longurio athymius* (Jordan & Starks, 1905), *Pseudogobio amurensis* (Dybowski, 1872), *Pseudogobio drakei* (Abbott, 1901), *Pseudogobio productus* (Peters, 1881), *Saurogobio drakei* (Abbott, 1901), *Saurogobio longirostris* (Wu & Wang, 1931), *Saurogobio productus* (Peters, 1881), *Saurogobio dabryi chenghaiensis* (Dai & Yang, 2002).



Таних шинж. Бие урт, нарийхан, 10-20 см хүрнэ. Бие сүүл хэсэгтээ илүү нарийсдаг. Хайрс бүрийн захаар хар хүрээтэй. Нурууны сэлүүр биеийн өмнөд хагаст байрладаг. Хайрс том биш. Хошуу мохоо, ам доош эргэсэн, амны ирмэгт сахалтай, уруул махлаг. Залгиурын шүд нэг эгнээ. Хамрын нүхний урд хоншоорт гүн хонхортой. Дух бага зэрэг хонхойсон. Хийт цуух нь хавтгай ясан капсулд байрлана. Хажуугийн шугам 46 хайрстай. Нуруу шаргал саарал. Биеийн хажуу нэг эгнээ сунасан бараан толботой ба нурууны сэлүүр хар толботой. Хос болон сүвний сэлүүр толбогүй. Хэвлий мөнгөлөг (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархалт хязгаарлагдмал ч популяцийн төлөв байдлын талаар үнэлгээнд шаардлагатай

мэдээ, баримт хангалтгүй учир уг зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Хятад, Орос, Монголын Амар мөрний ай саваас өмнө тийш Хятадын Шар мөрний сав, Солонгосын хойг, Сувдан гол болон Хайнан арал хүртэл тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур, Халх голд тохиолдоно. Ус, намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Цэнгэг уст нуур, голд тархах жижиг загас бөгөөд голын үндсэн голдиролд байршилттай. Нуурт ховор тохиолддог. Ширүүн урсгалаас зайлсхийдэг ба ёроолын амьдралын хэлбэртэй.



Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн хэмжээ, хандлага буураагүй (IUCN, 2024) гэж үзсэн. Харин Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн хүрээнд ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хадаасан гүрц

загас 2,300 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.47. ХАЛБАГАН ЖАРАА

Rhodeus sericeus (Pallas, 1776)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Харваа (Acheilognathidae)

Англи нэр: Amur bitterling

Ижил нэр: *Cyprinus sericeus* (Pallas, 1776), *Rhodeus amarus sericeus* (Pallas, 1776), *Rhodeus mantschuricus* (Mori, 1934), *Rhodeus sericeus sinensis* (Günther, 1868).



Ангилал зүйн тойм. *Rhodeus amarus* гэх зүйлийг урьд нь Зүүн Азийн *R. sericeus* хэмээх зүйлийн дэд зүйл гэж үзэж байсан ч сүүлийн үеийн судалгаагаар, бие даасан хоёр зүйл болгосон. *R. amarus* нь газарзүйн хувьд Төв, Зүүн Европ, Умард Азид, *R. sericeus* нь Амар мөрний сав газар болон Сахалин орчимд тархсан (Kottelat *et al.*, 2007) гэжээ.

Таних шинж. Биеийн урт 10.5-12.6 см, жин 20-50 г. Бие өндөр, хажуугийн шугам бүрэн бус, 5-11 хайрстай. Хайрс харьцангуй том. Нурууны сэлүүрийн урт сүвний сэлүүрийн урттай тэнцүү. Сүвний сэлүүр нь нурууны сэлүүрийн доороос эхэлнэ. Нүдний солонгон бүрхүүл шар. Биеийн хажуу хөхвөр туяа бүхий мөнгөлөг цайвар ба нуруугаараа нэлээд бараан. Биеийн хойд хагасын хажуугаар өргөн биш бараан судалтай. Сэлүүрүүд шаргал ягаан туяатай (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock *et al.*, 2006).


2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс, түүний авгалдайн хөгжлийн үе шатаа өнгөрөөдөг дунгийн тархалт, тоо толгойн талаарх мэдээ, баримт хангалтгүй учир уг зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Амар мөрний сав газрын уугуул бөгөөд Петр, Удэ болон Сахалины голууд, Орос, Монгол, Солонгос, Хятадын хойд хэсэгт тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэрлэн, Онон, Улз, Оршуун, Халх гол болон Буйр нуурт тохиолдоно. Ус, намгархаг газар (5), тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.



Амьдралын онцлог. Цэнгэг усны хос хавтаст хясаатай хам амьдрах тул энэ хясаа бүхий нуур, голд тархана. Гол төлөв гол, нуурын зөөлөн урсгалтай, тогтуун хэсэгт олноороо сүрэглэнэ.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн тоо толгой, хандлага тодорхойгүй (IUCN, 2024).

Ховордлын шалтгаан. Ховордлын гол шалтгаан нь уугуул зүйл болох хясааны тоо толгойн динамик өөрчлөлт (8) болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх

хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр халбаган жараа загас 2,460 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.48. ХАНХЫН ГҮРЦ

Squalidus chankaensis (Dybowski, 1872)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Chanka gudgeon

Ижил нэр: *Gnathopogon chankaensis* (Dybowski, 1872), *Gobio chankaensis* (Dybowski, 1872), *Leucogobio chankaensis* (Dybowski, 1872), *Squalidus biwae* (Jordan & Snyder, 1900), *Squalidus chankaensis biwae* (Jordan & Snyder, 1900), *Squalidus ussuriensis* (Berg, 1914).



Ангилал зүйн тойм. Энэхүү зүйлийг урьд нь *Gnathopogon ussuriensis*, *Gobio ussuriensis*, *Gobio chankaensis*, *Gnathopogon chankaensis* зэрэг ижил нэрээр нэрлэж байсан (Берг, 1948).

Таних шинж. Биеийн урт 8-13 см, жин 10-15 г. Урт, хавчиг биетэй. Доош эргэсэн жижиг амтай. Амны угт маш богино сахалтай. Залгиурын шүд нь хоёр эгнээ. Том нүдтэй, биеийн хажуу нарийн мөнгөлөг судалтай. Хайрс нь дундаж хэмжээтэй. Сүүлний сэлүүр нэлээд гүн ухлаадастай буюу сэрээлсэн сүүлний хэлбэртэй. Нуруу шаргалдуу хөх саарал, хоёр хажуу мөнгөлөг бөгөөд нарийн хөх саарал судалтай. Нурууны хасын захаар хүрэн эмжээртэй. Бүх сэлүүрүүд цайвар, толбогүй (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Ocock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс тул уг зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Орос, Хятад, Монголд тархсан Амар мөрний сав газрын эндемик зүйл.

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуурт тархсан ба цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Голын тогтуун хэсэг, нуурт байршина. Усны гүн ёроолын хэсгээр амьдарна. Зун Буйр нуурын эргийн 1-2 м гүнд сүрэглэн идээшилнэ.



Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн хэмжээ, хандлага тодорхойгүй (IUCN, 2024).

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн хүрээнд ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Ханхын гүрц загас 2,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж

зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.49. ХЯТАДЫН ХУУРАМЧ ГҮРЦ

Abbottina rivularis (Basilewsky, 1855)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Chinese false gudgeon

Ижил нэр: *Gobio rivularis* (Basilewsky, 1855), *Pseudogobio rivularis* (Basilewsky, 1855), *Tylognathus sinensis* (Kner, 1867), *Abbottina psegma* (Jordan & Fowler, 1903).



Таних шинж. Биеийн урт нь 4-12 см, жин 5 настайдаа 14 г хүрнэ. Бие нь урт, хажуугаасаа хавчиг. Хайрс дунд зэргийн хэмжээтэй. Эрүүний доод хэсгээр хайрсгүй. Ам нь доош болон хагас доош эргэсэн ба доод эрүүнд богино сахалтай. Уруул махлаг. Нүд толгойн дээд хэсэгт байрлалтай. Нуруу бор хүрэвтэр саарал. Биеийн хажуу том биш толботой, сүүлний сэлүүрийн угаар тод хар толботой. Энэ шинж нь залуу бодгалиудад илүү тод илэрнэ. Нуруу болон сүүлний сэлүүр цоохор (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс тул уг зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээ хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Хятадын өмнөд, зүүн хэсэг, Оросын зүүн хэсэг, Солонгосын хойг, Вьетнам болон Японы уугуул зүйл (Kottelat, 2001).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуурт тохиолдоно. Тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Голын тогтуун, гүехэн хэсэг, нуурын элсэрхэг, шаварлаг хурдас бүхий хурдан халж бүлээсдэг хэсгийг шүтэж амьдарна.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн тоо толгой, хандлага тодорхойгүй (IUCN, 2024).

Ховордлын шалтгаан. Ховордлын гол шалтгаан нь уугуул зүйл болох хясааны тоо толгойн динамик өөрчлөлт (8) болно.



Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хятадын хуурамч гүрц загас 3,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ

зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.50. ЦАГААН АМАР

Ctenopharyngodon idella (Valenciennes 1844)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Зүүн Азийн мөрөг (Xenocyprididae)

Англи нэр: Grass carp

Ижил нэр: *Leuciscus idella* (Valenciennes, 1844), *Ctenopharyngodon idellus* (Valenciennes, 1844), *Ctenopharyngodon laticeps* (Steindachner, 1866), *Sarcocheilichthys teretiusculus* (Kner, 1867), *Pristiodon siemionovii* (Dybowski, 1877), Ердийн цагаан-амар.



Таних шинж. Биеийн урт 100 см, жин 16 кг. Бөөрөнхий, хажуугаасаа хавчгар биш биетэй. Толгой нь харьцангуй жижиг. Залгиурын шүд хоёр эгнээ. Сахалгүй, хошуу богино буюу нүдний диаметрээс бага эсвэл тэнцүү. Дух өргөн. Ам хагас доош эргэсэн. Заламгайн хавтас дээр тойрог хэлбэрийн судалтай. Нуруу ногоовтор шаргалдуу саарал. Биеийн хажуугаараа бараан алтлаг. Хайрсны эрмэгээр хар. Нурууны болон сүүлний сэлүүр бараан ба бусад сэлүүр цайвар. Заламгайн хавтас цацраг судалтай (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн

хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс тул уг зэрэглэлээр үнэлэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Оросын Амар мөрний саваас Хятадын Шиньжан хүртэл тархсан. Номхон далайн ай савын ихэнх нуур голд тохиолдоно. Амарын савын зүүн хойд цутгал, Влагавешеншгээс Уссур, Ханх нуураас олдсон (Kottelat et al., 2007).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуурт тэмдэглэгдсэн. Цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Нуур болон цутгал голуудаар амьдрах бөгөөд өдөр усны гүний



ёроол орчмоор, шөнө нь булан тохой, халиа хэсгээр идээшилнэ. Өвөл усны гүнд өвөлжинө (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн хэмжээ, хандлага тодорхойгүй (IUCN, 2024).

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүнсэнд хэрэглэх (3.1) болон ахуйн (6.3.2) гаралтай усны бохирдол болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цагаан амар загас

24,900 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), ашиглалт, хэрэглээний түвшин (3.6) зэрэг чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.51. ЦАГААН ДОГТОР

Chanodichthys erythropterus (Basilewsky, 1855)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Зүүн Азийн мөрөг (Xenocyprididae)

Англи нэр: Red fin culter

Ижил нэр: *Culter aokii* (Oshima, 1919), *Culter brevicauda* (Günther, 1868), *Culter erythropterus* (Basilewsky, 1855), *Culter ilishaeformis* (Bleeker, 1871), *Culter sieboldii* (Dybowski, 1872), Улаан далбаат догтор.



Ангилал зүйн тойм. Хятадын болон Зүүн Өмнөд Азийн хэвлэлийн зарим эх сурвалжид *Culter erythropterus* (эсвэл *Cultrichthys erythropterus*) болон *Culter alburnus* гэх зүйлийг хольж хэрэглэж байв. Оросын судлаачдын *Erythroculter* төрөлд хамааруулсан зүйлүүдийг *Chanodichthys* төрөлд ангилах нь зүйтэй. Учир нь *Chanodichthys* нь *Erythroculter* гэх төрлөөс илүү эрт оноогджээ (Kottelat, 2006).

Таних шинж. Биеийн урт 100-127 см, жин 8-10 кг. Тархсан бүс нутгаас хамааран биеийн урт болон хэмжээ нь хэлбэлзэнэ. Жишээлбэл, Ханх нуурын хэлбэр 4+ насандаа 40-42 см урт бол голын хэлбэр нь 7-8 насандаа 45-55 см хүрнэ. Бие хажуугаасаа хавчгар, дунд зэргийн хэмжээтэй хайрсаар бүрхэгдсэн. Хайрсны ирмэг хар. Доод эрүү дээш өлийж, дээд эрүүг давна. Хэвлийн сэлүүрийн ард хянгатай ба энэ хэсэг хайрсгүй. Хажуугийн шугам нумраагүй. Нуруу мөнгөлөг шаргал, заримдаа мөнгөлөг ногоон ба нуруу болон сүүлний сэлүүрийн дээд илтэс нь мөн ижил өнгөтэй. Биеийн хажуу болон хэвлий

мөнгөлөг, цээжний сэлүүр шаргал. Хэвлийн болон сүвний сэлүүр нь заримдаа цайвар ягаан туяатай. Доод эрүүний үзүүр хэсэг заримдаа улаавтар (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс тул уг зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Улаан мөрний саваас (Вьетнам болон Тайван) Амар мөрний сав газар хүртэл (Хятад, Орос, Монгол, Солонгос, Япон) тархсан (Antonov et al., 2019).



Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуурт тархсан ба цэнгэг уст нуурт (5.5) амьдардаг зүйл.

Амьдралын онцлог. Нуурын 3-10 м гүнд байршина. Усны гүнд амьдрахад дасан зохилдсон онцлогуудтай. Тухайлбал, нуурын гүнээс олзоо отож, харахад зохилдож түүний нүд толгойн орой дээр байрлана. Нуурын 2-3 м гүнд өвөлжинө (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн хэмжээ өсөж байгаа гэж үздэг (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын гол шалтгаан нь хүнсэнд хэрэглэх (3.1) болон ахуйн (6.3.2) гаралтай усны бохирдол болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), арван ширхгээс

илүүгүй (28.4) загас агнаж, барих нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цагаан догтор загас 45,700 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.52. ЧЕКАНОВЫН ВАРЛАН

Rhynchocypris czekanowskii (Dybowski, 1869)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Сугас (Leuciscidae)

Англи нэр: Czekanowski's minnow

Ижил нэр: *Phoxinus czekanowskii* (Dybowski, 1869), *Lagowskiella czekanowskii* (Dybowski, 1869).



Ангилал зүйн тойм. *Rhynchocypris* төрлийн зүйлүүдийг өмнө нь *Phoxinus* төрөлд хамааруулан ангилж байсан. *Phoxinus* нь бүтэц, гарал үүсэл, гадаад шинжийн хувьд ихээхэн ялгаатай зүйлүүдийг багтаасан төрөл бөгөөд олон судлаач уг төрлийн доторх удам төрлийн холбоотой бүлгүүдийг (төрөл эсвэл дэд төрлийн түвшинд) ангилахыг оролдож ирсэн. Сүүлийн үеийн молекул биологи, генетикийн судалгаагаар, *Eupallasella* төрлийг *Rhynchocypris*-т багтаах нь зүйтэй (Sakai et al., 2006) гэж үзэх болсон. Монгол орны хувьд энэ зүйлийг анх Онон голын саваас тэмдэглэсэн. Гэхдээ ангилал зүйн асуудал нь бүрэн шийдэгдээгүй.

Таних шинж. Биеийн урт 8-13 см, заримдаа 15 см хүрэх ба биеийн жин 10-25 г. Бие уртассан, ээрүүл хэлбэртэй. Хагас доош эргэсэн, жижиг амтай. Дээд эрүү доод эрүүнээс урт. Гадаад байдлаараа нуурын варлантай төсөөтэй ч биеийн хэмжээ, зүсээрээ ялгаатай. Биеийн хоёр хажуу жижиг хар толботой, нэлээд өргөн бараан судалтай.

Толгойн урт биеийн өндрөөс урт. Хайрс жижиг ба өөр хоорондоо нягт суугаагүй. Хажуугийн шугам бүрэн бус. Нуруу, сүв, цээжний сэлүүр богино, дугуйрсан. Сүүлний сэлүүр бага зэрэг ухлаадастай. Нуруу бор хүрэн, хоёр хажуу алтлаг хүрэн, хэвлий цайвар. Нуруу, цээж, хэвлийн сэлүүрүүд нь дугуйрсан ба хүрэн (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл


Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс тул тус зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).



Дэлхийн тархац. Иртыш, Лена болон Сахалин голын савд (Орос, Хятад, Монгол, Казакстан) тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэрлэн, Онон, Балж, Улз, Халх гол, Буйр нуурт тохиолдоно. Тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Голын урсгал ихтэй хэсгийг бараадан байршижтай. Мөн түүнчлэн нуур, цөөрөм, голын салаануудын тогтуун хэсгээр сүрэглэнэ. Өвөл хөлддөггүй хүчилтөрөгчөөр баялаг, харзны ёроол мөсөн доор тархдаг харьцангуй хүйтэн усны зүйл юм.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд тоо толгой болон популяцийн чиг хандлагын хувьд тогтвортой (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, хандлага тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Чекановын варлан загас 2,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.53. ЧОЯ ЧИМХҮҮР ЗАГАС

Cobitis choii (Kim et Son, 1984)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Яралж (Cobitidae)

Англи нэр: Choi's spiny loach

Ижил нэр: *Cobitis lebedevi* (Vasil'eva & Vasil'ev, 1985)



Ангилал зүйн тойм. Өмнө нь *Cobitis lebedevi* (Vasil'eva & Vasil'ev, 1985) гэж тодорхойлж байсан зүйлийг *Cobitis choii* гэх зүйлийн ижил нэр гэж үзсэн (Fricke et al., 2023). Монголд өмнө тэмдэглэгдэж байсан *Cobitis lebedevi* (Vasil'eva & Vasil'ev, 1985) нь *Cobitis choii* (Kim et Son, 1984)-тэй ижил болох нь генетикийн судалгаагаар тогтоогдсон (Perdices et al., 2012; Dyldin et al., 2023).

Таних шинж. Биеийн урт 9 см, жин 10 г. Урт нарийн, хатгуур хутгыг санагдуулам биетэй. Сүүлний бариул нь толгойн уртаас богино. Толгой хавчгар, гөлгөр гадаргуутай. Амандаа 3 хос сахалтай. Жижиг нүдтэй, нүд нь арьсаар бүрхэгдсэн. Нүдний доор сунадаг өргөслөг хатгууртай. Жижиг амтай, хажуугийн шугам нь бүрэн бус бөгөөд цээжний сэлүүр хүрнэ. Эрийн цээжний сэлүүр доор шүдлэг хөгжсөн. Нуруу шаргалдуу бор хүрэн, хэвлий цайвар шаргал. Биеийн хоёр хажуугаар нэг эгнээ 12-17 дугуй хар хүрэн толботой. Нуруу дагуу 14-19 толбо бүхий судалтай. Сүүлний сэлүүрийн угийн дээд, доод хэсэгт 2 тод хар толботой (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Эмзэг Vulnerable (VU) B1ab (iii)+2ab (iii). Дэлхийд харьцангуй бага тархацтай. Нийт 1,895 км² нутагт тархсан бөгөөд түүний тоо толгойд нөлөөлөх хүчин зүйлс ихтэй, ялгаатай 6 газарт байх ба уг нутгуудад энэ зүйлийн амьдрах орчны чанар буурсаар байгааг харгалзан Эмзэг (VU), B1ab (iii)+2ab (iii) зэрэглэлээр үнэлсэн (IUCN, 2024)


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс тул тус зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Өмнөд Солонгосын эндемик зүйл бөгөөд Солонгосын хойгийн өмнөд хэсэг болон Оросын Амар мөрний савд тархсан (Froese et al., 2025).



Монгол орны тархац, амьдрах орчин. Онон голд тэмдэглэгдсэн (Аюушсүрэн нар, 2024) ба тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээг (5.1) шүтэж амьдарна.

Амьдралын онцлог. Цэнгэг усны жижиг ёроолын загас бөгөөд голын салаа, жижиг горхи, булаг, нуурын эргийн гүехэн, хурдан халдаг булан тохойн элсэрхэг болон шаварлаг хурдас бараадан байршина. Элсэрхэг хурдсанд шурган орж, удаан хугацаанд хөдөлгөөнгүй байх чадвартай (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийд популяцийн тоо толгой нь 50-90%-аар буурах чиг хандлагатай (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь мал аж ахуйгаас (1.1.4) улбаатай амьдрах орчны алдагдал, доройтол, загас агнуураас (1.3.2) хамаарсан үйл ажиллагаа зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй.

4.54. ШИВЭР ГҮРЦ

Gobio cynocephalus (Dybowski, 1869)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Dog-faced gudgeon

Ижил нэр: *Gobio fluviatilis cynocephalus* (Dybowski, 1869), *Gobio gobio cynocephalus* (Dybowski, 1869).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг *Gobio macrocephalus* гэх зүйлийн ижил нэр гэж үзэж байсан ч толгойн уртын стандарт уртад харьцах харьцаагаар нь бие даасан зүйл болохыг тогтоосон (Kottelat, 2006) and a further two are introduced species which have become established. Nine species are known from immediately adjacent waters in China and Russia and might be present, either as permanent inhabitants or vagrant individuals. The systematic status and nomenclature of all species have been reevaluated. Compared to the last synthesis of the fishes known from the same area (Baasanjav & Tsendayush, 2001).

Таних шинж. Биеийн урт 7-12 см, хааяа 16 см хүрнэ. Жин 30-80 г байх нь элбэг. Бие урт, ээрүүл хэлбэртэй. Том толгойтой. Ам доош эргэсэн. Завжиндаа богино, хос сахалтай. Зузаануруултай. Хажуугийн шугамын дээгүүр уртааш тод шар судалтай. Хайрс дундаж хэмжээтэй. Хоолой хэсгээрээ хайрсгүй, нүцгэн. Сүүлний сэлүүр гүн ухлаадастай ба дээд далбан доод далбангаас арай урт. Нүдний диаметр духны өргөнөөс их. Биеийн хажууд 6-10, ихэвчлэн 8 бараан толботой.

Нуруу ногоовтор бор хүрэн, биеийн хажуу мөнгөлөг саарал ба хөхвөр болон бараан толботой. Нуруу болон сүүлний сэлүүр хар толботой. Бусад сэлүүр саарал (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).


Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Осcock et al., 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орон дахь энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээ, баримт хомс тул тус зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Казакстан болон Сибирийн зүүн хэсгийн Орос, Хятад, Монгол, Солонгосын хойгт тэмдэглэгдсэн (Tserkin, 2003; Мамилов и др., 2013).



Монгол орны тархац, амьдрах орчин. Онон, Хэрлэн, Буйр нуур, Сэлэнгэ мөрөн, түүний цутгал голууд, Булган голд тархсан. Тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээ (5.1) болон цэнгэг уст нуурт (5.5) амьдарна.

Амьдралын онцлог. Дөлгөөн, дунд зэргийн урсгалын хурдтай голын салааны элсэрхэг эсвэл хайргархаг хурдастай ёроол орчмоор сүрэглэнэ. Заримдаа нуурын эргийн элсэрхэг хурдас бүхий гүехэн хэсгээр ч тохиолдоно. Ёроолын амьдралын хэлбэртэй ч маш хурдан хөдөлгөөнөөр усны дээд гадаргуу руу шилждэг. Цэнгэг усны индикатор зүйл болох Амарын зантгар, Лаговскийн варлан зэрэг жижиг загастай хамт тархана.

Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн тоо толгой, хандлага тогтвортой (IUCN, 2024). Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Газар тариалан (6.3.1), хөдөө аж ахуй (6.3.2), алт олборлолтын (6.3.7) гаралтай усны бохирдол бол түүний тоо толгойд сөргөөр нөлөөлөх үндсэн шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, мөн (9.2.4) Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр гүрц загас 1,170 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй.

4.55. АЛТЛАГ ХЭЛТЭГ

Carassius carassius (Linnaeus, 1758)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Мөрөг (Cyprinidae)

Англи нэр: Crucian carp

Ижил нэр: *Carassius moles* (Agassiz, 1835), *Cyprinus carassius* (Linnaeus, 1758), *Cyprinus moles* (Agassiz, 1835), *Carassius* (Humilis Heckel, 1837), *Cyprinus charax* (Lesniewski, 1837), *Carassius charax* (Lesniewski, 1837), *Carassius vulgaris* (Nordmann, 1840), *Carassius linnaei* (Bonaparte, 1845), *Carassius oblongus* (Heckel & Kner, 1858), *Carassius linnei* (Malm, 1877).



Ангилал зүйн тойм. Зөвхөн Хойд мөсөн далайн ай савын Булган голд байх магадлалтай (Соколова, 1983, Баасанжав нар, 2001). Гэвч энэ зүйлийн ангилал зүйн асуудал тодорхойгүй бөгөөд молекул генетикийн судалгаагаар тодруулах шаардлагатай.

Таних шинж. Биеийн урт 45 см, жин 3.0 кг. Бие өргөн, нуруу хэсгээрээ өндөрссөн ба сүүлний бариул өргөн, богино. Толгой хайрсгүй ба өргөн гурван өнцөгт хэлбэртэй. Нүд хоорондын зай өргөн. Сахалгүй. Хажуугийн шугам бүрэн. Нуруу болон сүвний сэлүүрүүд нь шүдлэг өргөстэй. Хэвлийн сэлүүр богино, өргөн. Нуруу бор ногоовтор туяа бүхий гялтгар хүрэн. Хэвлий цайвар.

Биеийн хажуу алтлаг. Сэлүүрүүдийн үзүүр бараавтар улбар туяатай (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл


Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Осcock *et al.*, 2006).

2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Монгол орны хувьд зөвхөн Булган голд тэмдэглэгдсэн бөгөөд судалгааны мэдээ, баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).



Дэлхийн тархац. Хойд, Балт, Цагаан, Варенц, Хар болон Каспийн тэнгисийн уугуул зүйл бөгөөд Марица, Колима голын савын зүүн хэсэг, Рине мөрний савын баруун хэсгээр тархсан (Kottelat *et al.*, 2007). Итали, Англи, Франц, Өмнөд Америк, Африк, Зүүн Өмнөд Ази болон Энэтхэгт нутагшуулсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Булган голд тархсан ба тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Гүехэн голын тохой, цүнхээл хэсгээр амьдрах ба усны температур харьцангуй өндөр байхад дуртай. Ургамал ихтэй урсгал тогтуун орчинд илүү их идээшилнэ (Аюушсүрэн нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн популяцийн хэмжээ буурч байгаа (IUCN, 2024) ба Монгол орны популяцийн хэмжээ, хандлагын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, суваг шуудуу, зам барилгын ажлуудаас (4.1.6) үүдэлтэй амьдрах орчны алдагдал, доройтол, газар тариалангийн (6.3.1) гаралтай усны бохирдол, өрсөлдөгчид

(8.1) болон уугуул зүйлийн динамик өөрчлөлт, тархалт хязгаарлагдах (9.1), нөхөн үржил буурах (9.2), тархац нутаг хумигдах (9.9) зэрэг болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр алтлаг хэлтэг загас 14,500 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

4.56. АМАРЫН БҮВЭР

Rhinogobius lindbergi (Berg, 1933)

Баг: Бүвэр (Gobiiformes)

Овог: Бүвэр (Gobiidae)

Англи нэр: Amur goby



Таних шинж. Биеийн урт 4-5 см. Бие уртавтарт, хажуугаасаа бага зэрэг хавчигдуу. Биеийн хажууд 6-8 том бараан толботой. Нурууны сэлүүр салангид. Хошуу богино. Нүд том.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Ососк *et al.*, 2006). 2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаар мэдээ, баримт хангалтгүй тул үнэлэх боломжгүй гэж үзэв.

Үнэлгээ хийсэн: Б.Мэндсайхан, Б.Мөнхзориг (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).


Дэлхийн тархац. Орос, Хятадын Амар мөрний савын адаг, Казакстан, Оросын баруун хэсэгт тархах ба Иранд мөргийн овгийн зарим зүйл загасыг нутагшуулах үед санамсаргүйгээр нутагшсан (David *et al.*, 2008).

Монгол орны тархац, амьдрах орчин. Буйр нуур, Халх голын адагт тэмдэглэгдсэн (David *et al.*, 2008; Мэндсайхан нар, 2017). Тогтмол урсгалтай (5.1) голын салаа, тогтуун урсгалтай хэсэг, байнгын цэнгэг уст нуурын (5.5) эргийн элсэрхэг, шаварлаг хурдас бүхий хэсэгт амьдарна (Аюушсүрэн нар, 2024).

Амьдралын онцлог. Агнуурын бус жижиг загас ба 2 насандаа үржилд орно. Салаа сахалт хавч, сэлүүр хөлт хавч, багшраа ялааны авгалдайгаар хооллоно.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан нь бохир ус (6.3.8), хог хаягдал (6.3.9) зэргээс амьдрах орчин нь доройтох болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-д зааснаар Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.



Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын бүвэр загас 2,400 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн үндсэн тархац нутаг болох Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар нь “Олон улсын ач холбогдол бүхий ус,

намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-д бүртгэгдсэн, мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх нь зүйтэй.

4.57. НАЙМАН САХАЛТ ГҮРЦ

Gobiobotia rappenheimeri (Kreyenberg, 1911)

Баг: Мөрөг (Cypriniformes)

Овог: Гүрц (Gobionidae)

Англи нэр: Eightbarbel gudgeon

Ижил нэр: *Gobio rappenheimeri* (Kreyenberg, 1911)



Таних шинж. Биеийн урт 7.2 см. Биеийн уртын дагуу хар толботой. Ам доош эргэсэн, хагас саран хэлбэртэй. Амны угт 3 хос сахалтай. Цээжний сэлүүр том бөгөөд энэ нь зөвхөн голын ёроолын хурдсанд бэхлэгдэх үүрэг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, хөхлөг маягийн бүтэцтэй болсон байдаг. Цээж болон хэвлийн сэлүүрийн хоорондох зайд хайрсгүй. Сүүлний сэлүүрийн доод далбан нь дээдхээсээ бага зэрэг урт. Хажуугийн шугам нь 39 хайрстай ба түүний дээгүүр урт ховилтой. Ерөнхийдөө шаргал зүстэй ба хэвлий цайвар. Нуруу өөр өөр хэлбэр хэмжээ бүхий бүдэг толботой. Хажуугийн шугам дагасан 12 цувраа тод хар толботой. Сэлүүрүүд тунгалаг (Аюушсүрэн нар, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (IUCN, 2024).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Энэ зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаар мэдээ, баримт хангалтгүй тул үнэлэх боломжгүй гэж үзэв.


Үнэлгээ хийсэн: Ч.Аюушсүрэн, А.Цолмон, Г.Ганбилэг (2025).

Үнэлгээ хянасан: С.Гомбобаатар, Г.Баасанжав, Д.Нарангарвуу (2025).

Дэлхийн тархац. Оросын Амар мөрний сав газраас Хятадын Шар мөрөн хүртэл тархана. Амар мөрний сав газрын хүрээнд зөвхөн Амар мөрний доод хэсэгт Константиновкаас Софиенск хүртэл тохиолдох ба Сунгар, Уссур, Ханх нуурын цутгалуудад тархсан (Antonov et al., 2019).

Монгол орны тархац, амьдрах орчин. Номхон далайн ай савын Халх голоос 2022 онд тэмдэглэсэн (Аюушсүрэн нар, 2024). Тогтмол урсацтай гол, горхи, хүрхрээнд (5.1) амьдарна.

Амьдралын онцлог. Голын цутгал хэсгүүдийн ёроол хэсгээр байршина. Зундаа голын цутгал орчмоор идээшилнэ. Намар Халх голын салаалсан хэсгийн түргэн урсгалт 10-30 см гүнтэй, түргэн халдаг, хайргархаг хурдас бараадна.



Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орны популяцийн хэмжээ, хандлага тодорхойгүй (IUCN, 2024).

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8-д зааснаар жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд

ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

Хамгааллын арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, амьдрах орчин, үржил, нүүдэл шилжилт, популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

- Алексеев, С.С., Кириллов, А.Ф. (1985). *К вопросу о морфологии и распространении двух форм ленков рода Brachymystax Gunther (Salmonidae) в бассейне Лены*. Вopr. Ихтиологии, 25(4): 597–602
- Алексеев, С.С. (1983). *Морфо-экологическая характеристика ленков (Salmonidae, Brachymystax) из бассейна Амура и из р. Уды*. Зоол. Журн., 62(7): 1057–1067
- Аюушсүрэн, Ч., Мэндсайхан, Б. (2019). *Загас (Vertebrata: Pisces)*. Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт. Тэргүүн боть (Редактор: С.Гомбобаатар, С.Шар, У.Айбек, Г.Гэрэлмаа, С.Баярхүү). МУИС, БОАЖЯ, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар. х.194-201
- Аюушсүрэн, Ч., Ганбилэг, Г., Жаргалсайхан, Л. (2024). *Монгол орны загас (зурагт хөтөч)*. Адмон принт ХХК. Улаанбаатар
- Баасанжав, Г. (1975). *Монгол хадран загасны биологийн судалгаанаас*. Биологийн ухааны хүрээлэнгийн бүтээл. 9:169–184
- Баасанжав, Г. (1979). *Хэрлэн, Онон голын (Thymallus arcticus grubei Dyb) амарын хадран*. Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнгийн бүтээл. 13:34-41
- Баасанжав, Г. (1980). *Хар нуурын Монгол хадрангийн морфологи экологийн судалгаа*. Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнгийн бүтээл. 15:66-78
- Баасанжав, Г., Цэнд-Аюуш, Я. (2001). *Монгол орны загас*. Улаанбаатар. х.51-53
- Базикалова, А.Я., Вилисова, И.К. (1956). *Питание бентосоядных рыб Малого моря*. Труды. Байгал. Лимн. Станции АН СССР. 17:328–417
- Базов, А.В., Базова, Н.В. (2016). *Селенгинская популяция Байкальского омуля: Прошное, настоящее, будущее*. In РАН Сибирское отделение. Федеральное государственное бюджетное учреждение науки, Институт общей и экспериментальной биологии. Издательство БНЦ СО РАН.
- Берг, Л.С. (1948). *Рыбы пресных вод и сопредельных стран* (Том I). АН СССР.
- Вронский, Б.Б. (1960). *Материалы по биологии сомов р. Амур*. Вopr. Ихтиологии. 14:34–58
- Гениатулин, Р.Ф. (2009). *Малая энциклопедия Забайкалья: Природное наследие*. Наука, Новосибирск. стр.698
- Гомбобаатар, С., Шар, С., Айбек, У., Гэрэлмаа, Г., Баярхүү, С. (2019). *Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт*. Тэргүүн боть. МУИС, БОАЖЯ, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар. 317 х.
- Дашдорж, А., Цэндсүрэн, А., Дулмаа, А. (1970). *Монгол орны усны амьтдыг тодорхойлох түлхүүр*. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. Улаанбаатар
- Дашдорж, А., Тугарина, П.Я., Тютрина, Л.И. (1976). *Рыбы оз. Хубсугул и перспективы их хозяйственного использования*. Природные условия и ресурсы Прихубсугуля в МНР. стр.268–284

- Дашдорж, А., Демин, А.И. (1977). *Зоографический анализ ихтиофауны Монголии*. Природные условия и ресурсы Прихубсугуля (5th ed.). Иркутск. Гос.ун-т. стр.141–154
- Дашдорж, Л. (2005). *Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ан агнуур, цаа бугын аж ахуйн түүхэн хөгжил*. Монгол Алтай-Соёны эко бүсийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах төсөл. Улаанбаатар
- Дгебуадзе, Ю.Ю., Рыбов, И.Н. (1978). *Биология Алтайского османа*. География и динамика Фауна и Флоры Монгольской Народной Республики. Наука. стр.174–182
- Дгебуадзе, Ю.Ю. (1986). *К изучению состава рыбного населения водоемов Монгольской Народной Республики*. Зоографическое районирование МНР. стр.52–90
- Дулмаа, А. (1967). *Дархадын хотгорын нууруудын гидробиологийн асуудал*. Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэр. Улаанбаатар
- Дулмаа, А. (1973). *К биологии Coregonus lavaretus pidschian (Gemlin) из озер Дархатской котловины*. Природные условия и ресурсы Прихубсугуля
- Дулмаа, А., Нансалмаа, Б. (1977). *Монгол орны томоохон нуурын гидробиологийн зарим асуудал*. Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэр. Улаанбаатар
- Карасев, Г.Л. (1987). *Рыбы Забайкалья*. Новосибирск. 295 стр.
- Кифа, М.И. (1974). *Материалы по экологии нереста ленка (Brachymystax lenok) и тайменя (Hucho taimen) в бассейне Амура*. Тр.ТИНРО. 5:105–108
- Книжин, И.Б., Дж, Вайс, С., Антонов, А.Л., Фруфе, Э. (2004). *Морфологическое и генетическое разнообразие амурских хариусов (Thymallus, Thymallidae)*. Вопросы Ихтиологии. 44:52–69
- Крыхтин, М.Л. (1979). *Современное состояние и перспективы развития осетрового хозяйства в бассейне Амура*. In Биологические основы развития осетрового хозяйства в водоемах СССР. Наука. стр.68–74
- Лапин, В.И., Баасанжав, Г. (1982). *Эколого-физиологическая характеристика монгольского хариуса*. Тез. Докл. V Всесоюз. Конф. По Экол. Физиологии и Био-Химии Рыб. 81–82
- Мамилов, Н.Ш., Хабибуллин, Ф.Х., Акбердина, Г.Ж., Салимбаева, А.С. (2013). *Разнообразие ихтиофауны рек Центрального Казахстана*. Selevinia. 21:87–91
- Мироновский, А.Н., Дгебуадзе, Ю.Ю., Мэндсайхан, Б., Слынько, Ю.В. (2019). *Морфологическая дифференциация алтайского османа Oreoleuciscus humilis (Cyprinidae) в реке Туун, Долина Озёр, Монголия*. Вопросы Ихтиологии. 59 (1):105–109. <https://doi.org/10.1134/s0042875219010077>
- Мэндсайхан, Б. (2010). *Рыбное население Центрально-Азиатского бессточного бассейна (Монголия)*. Москва
- Мэндсайхан, Б., Даш, Д., Жавзан, Ч., Чантуу, Х., Тэнгис, Э., Солонго, Д. (2012). *Баянхонгор аймгийн Биндэръяа Хөх нуурт хийсэн гидробиологийн судалгааны дүнгээс*. Монгол орны геоэкологийн асуудал. 9:222–241
- Мэндсайхан, Б., Цогтсайхан, П. (2013). *Монгол орны загас агнуурын өнгөрсөн, одоо, ирээдүй*. Монголын ШУА-ийн 50 жилийн ойн бүтээл. Улаанбаатар

- Мэндсайхан, Б., Жансагсодном, М., Цогтсайхан, П., Бямбабаяр, С. (2017). *Монгол орны нууруудын загасны бүрэлдэхүүнд агнуурын үзүүлэх нөлөө*. Нийгэм эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан үзэх нь. Олон улсын 3 дугаар бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. 1:269–276
- Мэндсайхан, Б., Дгебуадзе, Ю.Ю., Пүрэвдорж, С. (2017). *Монгол орны загасны лавлах*. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. Улаанбаатар
- Мэндсайхан, Б., Алтансүх, Д., Дорж, С. (2019). *Монгол хадран (Thymallus brevirostris) загасны шилжилт хөдөлгөөнийг судалсан дүнгээс*. Баруун Монгол, түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, түүх, хэл, соёл сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. х.239–243
- Мэндсайхан, Б., Крылов, А.В., Прокин, А.А., Баттуяа, Б., Дгебуадзе, Ю.Ю. (2019). *Үечилэн ширгэдэг Таацын цагаан нуурын гидробиологийн олон янз байдал*. Нийгэм эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан үзэх нь. Олон улсын 4 дүгээр бага хурлын эмхэтгэл. х.171–177
- Мэндсайхан, Б., Алтансүх, Д., Бурмаа, З., Пүрэвдорж, С. (2021). *Монгол хадран Thymallus brevirostris (Thymallidae) загасны судалгааны зарим дүнгээс*. Монгол орны геоэкологийн асуудалд. х.42
- Мэндсайхан, Б., Болорцэцэг, Э., Галиндэв, Б. (2022). *Хөвсгөл хадран загасны идэш тэжээлийн анализ. (Thymallidae: Thymallus nigrescens)*. Монгол орны газарзүй-геоэкологийн сэтгүүл. МОГГС. 43:204–209. <https://doi.org/10.5564/mjgg./59;43.2528>
- Никольский, Г.В. (1956). *Рыбы бассейна Амура*. Изд-во АН СССР.
- Осоек, J., Баасанжав, Г., Baillie, J.E.M., Эрдэнэбат, М., Kottelat, М., Мэндсайхан, В., Smith, К (Эмхэтгэсэн, Редактор). (2006). *Монгол орны загасны Улаан данс*. Бүс нутгийн Улаан дансны цуврал. Боть. 3. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон (Монгол)
- Осоек, J., Баасанжав, Г., Baillie, J.E.M., Эрдэнэбат, М., Kottelat, М., Мэндсайхан, В., Smith, К (Эмхэтгэсэн, Редактор). (2006). *Монгол орны загас хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл*. Бүс нутгийн Улаан дансны цуврал. Боть. 4. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон (Монгол)
- Подушко, М.В. (1967). *К распространению и биологии сига хадары Coregonus chadary Dybowski*. Изд. ТИНРО. 31:322–327
- Рачковская, Е.И. (1993). *Растительность гобийских пустынь монголий*. Наука, СанктПетербург. 132 стр.
- Расса, Т.С. (Ed.). (1983). *Жизнь животных* (В 7 т. Т.). Просвещение. Наука
- Решетников, Ю.С., Богуцкая, Н.Г., Васильева, Е.Д. (1997). *Список рыбообразных и рыб пресных вод России*. Вопр. Ихтиологии. 37 (6):723–771
- Решетникова, Ю.С. (Ed.). (2003). *Атлас пресноводных рыб России*: В 2 т. Т.1. Наука.
- Слынько, Ю.В., Дгебуадзе, Ю.Ю. (2009). *Популяционно-генетический анализ Алтайских османов (Oreoleuciscus, Cyprinidae) из водоёмов Монголии*. Вопр. Ихтиологии. 48 (3):315–323
- Соколова, В.Е. (Ed.). (1983). *Рыбы Монгольской Народной Республики*. Наука

- Соколова, В.Е. (Ed.). (1985). *Экология и хозяйственное значение рыб Монгольской Народной Республики*. Наука
- Слынько, Ю.Ю., Мэндсайхан, Б., Касьянов, А.Н. (2010). *К вопросу о внутривидовых формах Монгольского хариуса (Thymallus brevirostris Kessl.) озера Хотон нур (Западная Монголия)*. Вопросы Ихтиологии. 50 (1):28–37. <https://doi.org/10.1134/S0032945210010042>
- Терещенко, Л.И., Терещенко, В.Г., Мэндсайхан, Б., Слынько, Ю.В., Карабанов, Д.П. (2009). *Пространственное распределение эндемичного вида Алтайского османа Oreoleuciscus potanini (Kessler, 1879) в двух озерах Западной Монголии*. Труды Института Биологии Внутренних Вод РАН, Брок. 5:45–48
- Тугарина, П.Я., Дашдорж, А. (1972). *Монгольский хариус (Thymallus brevirostris) в бассейне р. Дзабхан*. Вопр. Ихтиологии. 5 (76):844–856
- Тугарина, П.Я. (2002). *Экология рыб озера Хубсугул и их рыбохозяйственный потенциал*.
- Түвшинлхагва, А., Ариунболд, Ж., Мөнхбаяр, Х., Мөнхбаатар, М., Эрдэнэтүшиг, П. Мэндсайхан, Б. (2016). *Сэлэнгэ мөрөнд шинээр тэмдэглэгдсэн харь зүйл тогтмолын цоохлойн Percocottus glenii dybowskii, 1877 (Perciformes: Odontobutidae) экосистемд үзүүлэх нөлөө*. Монгол орны геоэкологийн асуудалд. Улаанбаатар
- Цогтсайхан, П. (2020). *Монгол орны ердийн тул загас (Hucho taimen Pallas, 1773)-ны биологи, экологи, хамгааллын асуудал*. Докторын зэрэг горилсон бүтээл. МУИС. Улаанбаатар
- Цэгмид, Ш. (1969). *Монгол орны физик газарзүй*. Монголын ШУА-ийн хэвлэлийн газар, Улаанбаатар
- Цэнд-Аюуш, Я. (1968). *Өгий нуурын агнуурын загасны насны тэдгээрийн агнуурын ач холбогдол*. Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 10 (3):117–126
- Цэнд-Аюуш, Я. (1969). *Өгий нуурын агнуурын (улаан нүдэн, алгана, цурхай) загасны насны бүрэлдэхүүн, өсөлтийн хурд, агнуурын холбогдол*. Биологийн ухааны хүрээлэнгийн бүтээл. 3:125–141
- Чимэддорж, Б., Пүрэвсүрэн, С., Тэрбиш, Х., Гомбобаатар, С., Одхүү, Б., Төвшин, Ү., Гэрэл, Н., Суран, Д. (2018). *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн лавлах*. БОАЖЯ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар. МУИС, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Улаанбаатар. 448 х.
- Чимэддорж, Б., Пүрэвсүрэн, С., Тэрбиш, Х., Гомбобаатар, С., Нарангарвуу, Д., Онолрагчаа, Г., Жамъянхүү, Н., Булган, Т. (2021). *Монгол орны нэн ховор, ховор амьтад, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хэрэглээ, худалдаа ба хуулийн хариуцлага*. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, БОАЖЯ, ХЗДХЯ, МУИС, МУБИС. Улаанбаатар. 542 х.
- Эрдэнэбат, М., Мэндсайхан, Б. (1996). *Тул загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх асуудал*. Ой, ан судлалын хүрээлэнгийн бүтээл. 3:76–79
- Эрдэнэбат, М. (1998). *Байгалийн нөхцөлд үүссэн эрлийз загас олдов*. ШУА-ийн Эрдэм сонин. 7
- Эрдэнэбат, М. (2006). *“Монголын Алтай-Соёны экобүс нутгийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотой хамгаалах” төслийн тайлан*. Улаанбаатар

- Эрдэнэбат, М. (2010). *Дархадын хотгор, Шишхэдийн савын нуур, голуудад тархан амьдрах тул (Hucho taimen) загасны популяцийн судалгаа*. Монгол орны геоэкологийн асуудалд. 5:82–93
- Andrew, Kaus., Olaf, Buttner., Michael, Schaeffer., Gankhuyag, B., Purevdorj, S and D. Borchardt. (2016). *Seasonal home range shifts of the Siberian taimen (Hucho taimen Pallas 1773): Evidence from passive acoustic telemetry in the Onon River and Balj tributary (Amur River basin, Mongolia). Seasonal Home Range Shifts of the Siberian Taimen (Hucho Taimen Pallas 1773): Evidence from Passive Acoustic Telemetry in the Onon River and Balj Tributary (Amur River Basin, Mongolia).* 101:1–13
- Antonov, A.L. (2012). *Diversity of fishes and structure of ichthyocenoses in mountain catchment areas of the Amur Basin*. Journal of Ichthyology. 52 (2):149–159
- Antonov, A.L., Barabanshchikov, E. I., Zolotukhin, S. F., Mikheev, I. E and Shapovalov, M.E. (2019). *Fishes of Amur*. World Wide Fund for Nature (WWF)
- Baillie, J.E.M. and Groombridge, B. (Compilers and Editors) (1996). *1996 IUCN Red List of Threatened Animals*. IUCN, Gland and Cambridge
- Bogutskaya, N.G and Naseka, A.M. (2004). *Catalogue of agnathans and fishes of fresh and brackish waters of Russia with comments on nomenclature and taxonomy*.
- Bogutskaya, N.G., Naseka, A.M., Shedko, S.V., Vasil'eva, E.D and Chereshnev, I.A. (2008). *The fishes of the Amur River: Updated check-list and zoogeography*. Ichthyological Exploration of Freshwaters. 19 (4):301–366
- Bushuev, V.P and Barabanshchikov, E.I. (2012). *Freshwater and estuarine fish of Primorye*. Technical Fisheries University.
- Chen, Y.Y (Ed.). (1998). *Fauna sinica. Osteichthyes. Cypriniformes II*. Science Press
- Chen, H., Zhang, H., Chen, Y.X and Freyhof, J. (2019). *A review of the Barbatula loaches from north-eastern China, with the description of four new species (Teleostei, Nemacheilidae)*. Zootaxa. 4565:36
- Convention on the Conservation of Migratory Species of Wild Animals-CMS. (2015). <http://www.cms.int/en/species>
- Choi, Ki-Chul., Leon, Sang-Rin., Kim, Ik-Soo., Son, Y.M. (1990). *Colored illustrations of Fresh water Fishes of Korea*.
- David, A. Neely., Mark, H., Sabaj Perez and Mendsaikhan, B. (2008). *First Records of Rhinogobius lindbergi (Teleostei: Gobiidae) and Abbottina rivularis (Teleostei: Cyprinidae) in the Lake Buyr Drainage, Mongolia*. Journal of Great Lakes Research. 34 (2):334–341. [https://doi.org/10.3394/0380-1330\(2008\)34](https://doi.org/10.3394/0380-1330(2008)34)
- Dgebuadze, Yu.Yu. (1995). *The land/inland-water ecotones and fish population of Lake Valley (West Mongolia)*. Hydrobiologia. 303:235–245
- Dgebuadze, Yu.Yu. (2009). *Aquatic Ecosystems of Selenge River Basin*. Rosselikhosacademia
- Dgebuadze, Yu.Yu., Mironovsky, A.N., Mendsaikhan, B., Slyn'ko, Yu. V. (2020). *Rapid morphological diversification of the cyprinid fish Oreoleuciscus potanini (Cyprinidae) in the course of formation of a reservoir in a river of the semiarid zone*. Dokl. Biol. Sci. 490:12–15. <https://doi.org/10.1134/S0012496620010019>

- Dulmaa, A and Milan, Penaz. (1983). *On the reproduction and growth of Coregonus lavaretus pidschian from Darchatsk valey (Norethern Mongolia)*. Folia Zoologica. 34 (1):89–96
- Dulmaa, A. (1999). *Fish and fisheries in Mongolia*. In T.Petr (Ed.), Fish and fisheries at higher altitudes. Asia. FAO Fisheries technical paper. 385:28-38
- Dyldin, Yu.V., Orlov, A.M., Hanel, L., Romanov, V.I., Fricke, R and Vasil'eva, E.D. (2023). *Ichthyofauna of the Fresh and Brackish Waters of Russia and Adjacent Areas: Annotated List with Taxonomic Comments*. 2. Order Cypriniformes, Suborders Catostomoidei, Cobitoidei and Cyprinoidei. Journal of Ichthyology. 63:636–686. <https://doi.org/DOL: 10.1134/S0032945223040045>
- Fricke, R., Eschmeyer, W.N., R. Van der Laan. (2023). *Eschmeyer's Catalog of Fishes: Genera, Species, References*. Electronic Version. https://researcharchive.calacademy.org/research/ichthyology/catalog/SpeciesByFamily.asp?fbclid=IwAR3fW7KAfr_kZQHYTOtmz06TLeynSyh1sWKxdwFQ9CLvfEWaQS9CmhCx3yE
- Froese, R and Pauly, D. (2025). *FishBase*. World Wide Web Electronic Publication
- Gilroy, D.J., Jensen, O.P., Allen, B.C., Chandra, S., Ganzorig, B., Hogan, Z., Maxted, J.T. Vander, Zanden, M.J. (2010). *Home range and seasonal movement of taimen, Hucho taimen, in Mongolia*. Ecology of Freshwater Fish. 19:545–554. <https://doi.org/10.1111/j.1600-633.2010.00434>
- Grubov, V.I. (1982). *Key to the vascular plants of Mongolia (with an atlas)*. Nauka Press, Leningrad. 443 pp.
- Holcik, J and Povnicka, K. (1969). *Notes on a collection of fishes from Mongolia with description of Microphysogobio tungtingensis anudarini ssp. n. and discovery of some new or little known fishes*. Annotationes Zoologicae et Botanicae. 56:1–25
- IUCN. (2001). *The IUCN Categories and Criteria (Version 3.1)*. IUCN SSC, Gland and Cambridge.
- IUCN. (2012). *Guidelines for Application of IUCN Red List Criteria at Regional and National Levels: Version 4.0*. Gland, Switzerland and Cambridge, UK: IUCN. iii + 41pp. <https://portals.iucn.org/library/node/10336>
- Kimura, S., Mori, T., Kataoka, T., Hosoya, K., Wu, H. L. and Suzuki, K. (1992). *Preliminary report on a collection of freshwater fishes from the Altai district, Northern Xinjiang, China*. Bulletin of the Faculty of Bioresources Mie University. 7:91–105
- Kirk, W. Olson., Trevor, J. Krabbenhoft., Thomas, R. Hrabik. Mendsaikhan, B., Olaf, P. Jensen. (2019). *Pelagic–littoral resource polymorphism in Hovsgol grayling Thymallus nigrescens from Lake Hovsgol, Mongolia*. Ecology of Freshwater Fish 6 1–13. <https://doi.org/10.1111/eff.12464>
- Knizhin, I.B., Weiss, S.J. (2009). *A New Species of Grayling Thymallus svetovidovi sp. Nova (Thymallidae) from the Yenisei Basin and Its Position in the Genus Thymallus*. J. Ichthyol. 49 (1):1–9
- Koch, F and Paepke, H.J. (1998). *Zur Kenntnis der Gattung Leuciscus Cuvier in der Mongolei mit Beschreibung einer neuen Art (Pisces, Cyprinidae)*. Mitteilungen Aus Dem Zoologischen Museum in Berlin, Zoologie. 74 (2):157–171. <https://doi.org/https://doi.org/10.1002/mmzn.19980740202>

- Koskinen, M.T., Knizhin, C.R., Primmer, C. Schlottere., Weiss, S. (2002). *Mitochondrial and nuclear DNA phylogeography of Thymallus spp. (grayling) provides evidence of ice-age mediated environmental perturbations in the world's oldest body of Baikal*. Molecular Ecology. 11:2599–2611
- Kottelat, M. (2001). *Freshwater Fishes of Northern Vietnam. A preliminary check-list of the fishes known or expected to occur in northern Vietnam with comments on systematics and nomenclature* (E. A and P. Region (Ed.); Environmen). The World Bank
- Kottelat, M. (2006). *Fishes of Mongolia: a check-list of the fishes known to occur in Mongolia with comments on systematics and nomenclature*. World Bank. 103 pp.
- Kottelat, M., Freyhof, J. (2007). *Handbook of European freshwater fishes* (i–xiii). Publications Kottelat
- Lamoreux, J., Akcakaya, H.R., Bennun, L., Collar, N.J., Boitani, L., Brackett, D., Brautigam, A., Brooks, T.M., da Fonseca, G.A.B., Mittermeier, R.A., Rylands, A.B., Gardenfors, U., Hilton-Taylor, C., Mace, G., Stein, B.A and Stuart, S. (2003). *Value of the IUCN Red List*. Trends in Ecology and Evolution 18 (5):214-215
- Maitland, P.S., Herdson, D and Coates, S. (2009). *Key to the marine and freshwater fishes of Britain and Ireland: A guide to the identification of more than 370 species*.
- Manu, Esteve., David, Gilroy., Deborah, Ann. McLennan. (2009). *Spawning behavior of taimen (Hucho taimen) from the Uur River, Northern Mongolia*. Environ Biol Fish. 84:185–189. <https://doi.org/10.1007/s10641-008-9407>
- Ocock, J., Baasanjav, G., Baillie, J.E.M., Erbenabat, M., Kottelat, M., Mendsaikhan, B and Smith, K (compilers and editors). (2006). *Mongolian Red List of Fishes*. Regional Red List Series Vol. 3. Zoological Society of London, London (In English)
- Olaf, P. Jensen., David, J., David, Zeb Hogan, Brant C. Allen. (2009). *Evaluating recreational fisheries for an endangered species: a case study of taimen, Hucho taimen, in Mongolia*. Can. J. Fish. Aquat. Sci. 66:1707–1718
- Perdices, A., Vasil'ev, V and Vasil'eva, E. (2012). *Molecular phylogeny and intraspecific structure of loaches (genera Cobitis and Misgurnus) from the Far East region of Russia and some conclusions on their systematics*. Ichthyol Res 59:113–123. <https://doi.org/10.1007/s10228-011-0259-6>
- Ponomareva, E.V., Volkov, A.A., Ponomareva, M.V., Shubina, E.A. (2022). *MtDNA Analysis of the Upper Yenisei Grayling (Thymallus svetovidovi) and the Mongolian Grayling (Thymallus brevirostris) and clarification of their ranges*. Biology Bulletin. 49 (6):721–726. <https://doi.org/10.1134/s1062359022060139>
- Prokofiev, A.M. (2003). *A new species of the loach genus Barbatula (Teleostei, Balitoridae) from the Amur River basin*. Zootaxa. 237:1–9
- Prokofiev, A. M. (2016). *Loaches of the genus Barbatula (Nemacheilinae) of the Zavkhan River basin (Western Mongolia)*. Journal of Ichthyology. 56 (6):818–831. <https://doi.org/10.1134/S0032945216060084>
- Prokofiev, A.M. (2018). *A new species of Barbatula from the headwaters of the Bulgan River in western Mongolia (Teleostei: Nemacheilidae)*. Zootaxa. 4407 (2):267–274. <https://doi.org/10.11646/zootaxa.4407.2.7>

- Pronin, N.M and Afanasyeva, V. G. (1988). *Acipenser baerii baikalensis*. The Red Data Book of the Republic of Buryatia
- Ride, W.D.L. (Ed.). (1999). *International Code of Zoological Nomenclature* (Fourth Edi). Tipografia La Garangola
- Rylková, K., Kalous, L., Bohlen, J., Lamatsch, D.K and Petrtyl, M. (2013). *Phylogeny and biogeographic history of the cyprinid fish genus Carassius (Teleostei: Cyprinidae) with focus on natural and anthropogenic arrivals in Europe*. Aquaculture. 380–383, 13–20. <https://doi.org/10.1016/j.aquaculture.2012.11.027>
- Sakai, H., Ito, Y., Shedko, S.V., Safronov, S.N., Frolov, I.A., Chereshnev, S.R. Jeon and Goto, A. (2006). *Phylogenetic and taxonomic relationships of northern far eastern minnows, Phoxinus and Rhynchocypris (Pisces, Cyprinidae), as inferred from allozyme and mitochondrial 16S rRNA sequence analyses*. Zoological Science. 23:323– 331
- Sheiko, B.A. (2013). *On family-group names of extant fishes and fish-like vertebrates of the World* (Vol. 74, Issue 82).
- Sokolov, L.I., Vasil'ev, V.P. (1989). *Acipenser nudiventris Lovetsky, 1928. Acipenser ruthenus Linnaeus, 1758. Acipenser baeri Brandt, 1869*. The Fishes of Europe Wiesbaden: AULA-Verl. 1 (2):201–284
- The IUCN red list of threatened species*. (2024). <https://www.iucnredlist.org/>
- Travers, R.A. (1989). *Systematic account of a collection of fishes from the Mongolian People's Republic: with a review of the hydrobiology of the major Mongolian drainage basins*. Bulletin of the British Museum (Natural History), Zoology. 55:173–207
- Tsepkin, E.A. (2003). *Gobio gobio (Linnaeus, 1758) - gudgeon*. In Yu.S. Reshetnikov (Ed.), Atlas of Russian freshwater fishes. Nauka, Moscow. p.249–251
- Tsogtsaikhan, P., Mendsaikhan, B., Jargalma, G., Ganzorig, B., Weidel, C., Filosa, C.M., Free C.M., Young, T., Jensen, O.P. (2016). *Age and growth comparisons of Hovsgol grayling (Thymallus nigrescens Dorogostaisky, 1923), Baikal grayling (T. baicalensis Dybowski, 1874), and lenok (Brachymystax lenok Pallas, 1773) in lentic and lotic habitats of Northern Mongolia*. Journal of Applied Ichthyology. 33:105–118. <https://doi.org/10.1111/jai.13247>
- Tuvshinzhargal, N., Nickolai, B., Dmitry, V.P., Lyubov, V.S. (2024). *Origin and Relationships of Humpback Whitefishes of Mongolia (Corigoninae)*. Geography and Natural Resources. 44 (1):114–119. <https://doi.org/10.1134/S1875372823050189>
- Tyler, D. Ahrenstorff., Olaf, P. Jensen., Brian, C. Weidel., Mendsaikhan, B., Thomas, R. Hrabik. (2012). *Abundance, spatial distribution, and diet of endangered Hovsgol grayling (Thymallus nigrescens)*. Environ Biol Fish. 94:465–476. <https://doi.org/10.1007/s10641-011-9961-5>
- UN Environmental Programme - World Conservation Monitoring Centre. (2017). *Checklist of CITES Species Website*. CITES Secretariat, Geneva, Switzerland. <https://checklist.cites.org/>
- Weiss, S.J., Gonçalves, D.V., Secci-Petretto, G., Englmaier, G.K., Gomes-Dos-Santos, A. Denys, G.P.J., Persat, H., Antonov, A., Hahn, C., Taylor, E.B., Froufe, E. (2021). *Global systematic diversity, range distributions, conservation and taxonomic assessments of graylings (Teleostei: Salmonidae; Thymallus spp.)*. Organisms Diversity & Evolution, published online on 25 Nov. 2020
- Zhang, T., Li, Z. (2007). *Fish resources and fishery utilisation of Lake Poyang*. Journal of Lake Sciences. 19 (4):434–444

Олон улсын конвенц ба албан ёсны вэбсайт

The International Union for Conservation of Nature (IUCN) Red List of Threatened Species. <https://www.iucnredlist.org/>

Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora (2013). "Appendices I, II and III. <https://cites.org/eng>

Convention on the Conservation of European Wildlife and Natural Habitats (Bern Convention). <https://www.coe.int/en/web/bern-convention/>

The Habitats of the European Union Habitats Directive. https://ec.europa.eu/environment/nature/legislation/habitatsdirective/index_en.htm

The Ramsar Convention on Wetlands of International Importance especially as Waterfowl Habitat. <https://www.ramsar.org/>

Ашигласан вэбсайт:

<http://www.legalinfo.mn>

<http://checklist.cites.org>

<https://trade.cites.org>

<http://www.cms.int/en/species>

<http://www.iucnredlist.org>

<https://portals.iucn.org/library/node/10336>

<https://mongolia.panda.org>

<https://www.eic.mn/>

<https://mpa.gov.mn>

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Дэлхийн байгаль хамгаалах холбооны ховордлын зэрэглэлийн үнэлгээний товч тайлбар (IUCN, 2012)
(Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг зүйлийн ховордлын зэрэглэлийг үнэлэхэд ашигладаг А-Е хүртэлх шалгуур)

А-В-ийн аль ч шалгуурыг ашиглах	Устаж байгаа	Устаж болзошгүй	Эмзэг
А. Популяцийн тоо толгойн бууралт. 10 жил эсвэл 3 үеэс дээш хугацаанд ажиглалтаар буурах хандлагатай			
A1	≥ 90 хувь	≥ 70 хувь	≥ 50 хувь
A2, A3, A4	≥ 80 хувь	≥ 50 хувь	≥ 30 хувь
A1. Популяцийн бууралтын шалтгаануудыг урьд нь судалж үнэлгээ, дүгнэлт өгсөн буюу эргэлзсэн дүгнэлтүүдийг доор өгөгдсөн жагсаалтууд дээр тулгуурлан популяцийн доройтлын шалтгаануудыг буцаад хуучиндаа орох магадлал нь баттай буюу тодорхой эсэхийг тогтоох			
	(a) шууд ажиглалт		
	(b) тухайн таксонд нийцсэн элбэгшлийн индекс		
	(c) эзлэн амьдрах талбай болон орших нутгийн хэмжээ, амьдрах орчны тааламжтай байдал		
	(d) ашиглалтын өнөөгийн болон боломжит түвшин		
	(e) нутагшуулсан зүйл, эрлийзжил, эмгэг үүсгэгч, бохирдол, өрсөлдөгч ба паразит нөлөө		
A2. Популяцийн бууралтын шалтгаануудыг урьд нь судалсан, үнэлсэн, дүгнэсэн болон эргэлзсэн дүгнэлтүүдийг A1-ийн (a)- (e) хооронд өгөгдсөн үнэлгээнүүд дээр тулгуурлан бууралтын явц зогсоогүй, бууралтын шалтгаан тодорхой бус буюу магадгүй буцаад анхны байдалдаа эргэн орох боломжтойг тогтоох			
A3. A1-ийн (b)-(e) хүртэлх шалгуур ирээдүйд популяци нь тодорхой буурах эсвэл магадлалтай тулгарвал (хамгийн их нь 100 жил)			
A4. Өнгөрсөн үе буюу ирээдүйдээ (хамгийн их нь 100 жил) популяцийн доройтлын шалтгаануудыг судалж, үнэлгээ, дүгнэлт өгсөн, тооцоолон боловсруулсан буюу эргэлзээ төрүүлсэн дүгнэлтүүдийг A1-ийн (a)-(e) хүртэлх шалгуурууд дээр тулгуурлан популяцийн бууралтын шалтгаан нь тодорхойгүй, ойлгомжтой бус буюу буцаад хуучин байдалдаа эргэн орох боломжтойг тогтоох			
В. В1 болон В2-ын Газарзүйн тархалтын хилийн хэлбэр, хэмжээ			
В1. Тархац нутгийн хэмжээ	< 100 км ²	< 5,000 км ²	< 20,000 км ²
В2. Эзлэн амьдрах талбай	< 10 км ²	< 500 км ²	< 2,000 км ²
Дараагийн 3-ийн 2 нь			
(a) Хэд хэдэн тасархайтсан эсвэл тасархайтсан газар нутгийн тоо	= 1	≤ 5	≤ 10

(b) Тоо толгойн байнга буурах хандлага нь (i) тархац нутгийн хэмжээ; (ii) эзлэн амьдрах талбай; (iii) амьдрах орчны тааламжтай байдал, талбай болон хэмжээ; (iv) байршил эсвэл салбар популяцийн тоо; (v) үржлийн насны бодгалиудын тоо			
(c) Эрс хэлбэлзэл нь: (i) тархац нутгийн хэмжээ; (ii) эзлэн амьдрах талбай; (iii) байршил, эсвэл салбар популяцийн тоо; (iv) үржлийн насны бодгалиудын тоо			
С. Жижиг популяцийн хэмжээ болон бууралт			
Үржлийн насны бодгалиудын тоо	< 250	< 2,500	< 10,000
Дараагийн С1 эсвэл С2 :			
С1. Тоо толгой үргэлжлэн буурах Хандлагын үнэлгээ нь:	1 үе эсвэл 3 жилд 25 хувь	2 үе эсвэл 5 жилд 20 хувь	3 үе эсвэл 10 жилд 10 хувь
Хамгийн их нь 100 жил			
С2. Тоо толгойн үргэлжлэн буурах хандлага болон (a) эсвэл (b):			
A (i) бүх салбар популяциудын бие гүйцсэн бодгалиуд:	< 50	< 250	< 1,000
A (ii) нэг салбар популяцид байгаа бодгалиудын хувь:	90 хувь	95 хувь	100 хувь
(b) Үржлийн насны бодгалиудын эрс хэлбэлзэл			
D. Маш бага буюу хязгаарлагдмал популяци			
Аль нэгийг нь:			
(1) Үржлийн насны бодгалийн тоо, эсвэл	< 50	< 250	< 1,000
(2) Эзлэн амьдрах талбай			Эзлэн амьдрах талбай < 20 км ² , эсвэл байршил нутаг ≤ 5 км ²
E. Тооны анализ			
Байгальд устах магадлалын илэрхийлэл:	3 үе (хамгийн их нь 100 жил), эсвэл 10 жилд ≥ 50 хувь	5 үе (хамгийн их нь 100 жил), эсвэл 20 жилд ≥ 20 хувь	100 жилд ≥ 10 хувь

Хавсралт 2. Монгол орны загасны зүйлүүдийн үнэлгээний нэгтгэл

№	Монгол нэр	Шинжлэх ухааны нэр	Бүс нутгийн үнэлгээ (2025)
УСТАЖ БАЙГАА (CR)			
1	Амарын хилэм	<i>Acipenser schrenckii</i> (Brandt, 1869)	A2bd, B2ab (ii,iii,v)
2	Шивэр хилэм	<i>Acipenser baerii</i> (Brandt, 1869)	B2ab(iii,v)
УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN)			
3	Алтайн давжаа сугас	<i>Oreoleuciscus humilis</i> (Warpachowski, 1889)	B2ab(ii,iii,iv,v)
4	Амарын хадран	<i>Thymallus grubii</i> (Dybowski, 1869)	B2ab (iii,v)
5	Говийн сахалт эрээлж	<i>Barbatula dgebuadzei</i> (Prokofiev, 2003)	B2ab(iii)
6	Дархадын цагаан загас	<i>Coregonus pidschian</i> (Gmelin, 1789)	B2ab (iii,v)
7	Ердийн тул	<i>Hucho taimen</i> (Pallas, 1773)	A2de, A3de, B2ab (iii,v)
8	Зүүн гарын сугас	<i>Leuciscus dzungaricus</i> (Koch et Paepke, 1998)	B1ab (v), B2ab (v)
9	Хөвсгөл хадран	<i>Thymallus nigrescens</i> (Dorogostaisky, 1923)	B2ab (i,ii,iii,iv,v)
ЭМЗЭГ (VU)			
10	Енисейн хадран	<i>Thymallus svetovidovi</i> (Knizhin et Weiss, 2009)	B2ab (i,ii)
11	Монгол хадран	<i>Thymallus brevirostris</i> (Kessler, 1879)	B2ab (iii, v)
12	Монхор хоншоорт зэвэг	<i>Brachymystax tumensis</i> (Mori, 1930)	B2ab (iii, v)
13	Шаргал үхэрдээ	<i>Tinca tinca</i> (Linnaeus, 1758)	B2b(i)
14	Шивэр хадран	<i>Thymallus baicalensis</i> (Dybowski, 1874)	A3d
15	Шөвгөр хоншоорт зэвэг	<i>Brachymystax lenok</i> (Pallas, 1773)	B3d
ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (NT)			
16	Бух сугас	<i>Leuciscus idus</i> (Linnaeus, 1758)	NT
17	Хатгуурт харваа	<i>Acheilognathus asmussi</i> (Dybowski, 1872)	NT
18	Хорхой загас	<i>Lethenteron reissneri</i> (Dybowski, 1869)	NT
19	Цагаан хадир	<i>Coregonus chadary</i> (Dybowskii, 1862)	NT
АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (LC)			
20	Амарын моголзой	<i>Misgurnus mohoity</i> (Dybowski, 1869)	LC
21	Амарын цулбуурт	<i>Silurus asotus</i> (Linnaeus, 1758)	LC
22	Амарын цурхай	<i>Esox reichertii</i> (Dybowski, 1869)	LC
23	Арнолдын эрээлж	<i>Triplophysa arnoldii</i> (Prokofiev, 2002)	LC

№	Монгол нэр	Шинжлэх ухааны нэр	Бүс нутгийн үнэлгээ (2025)
24	Голын алгана	<i>Perca fluviatilis</i> (Linnaeus, 1758)	LC
25	Ердийн варлан	<i>Phoxinus phoxinus</i> (Linnaeus, 1758)	LC
26	Ердийн цурхай	<i>Esox lucius</i> (Linnaeus, 1758)	LC
27	Мөнгөлөг хэлтэг	<i>Carassius gibelio</i> (Bloch, 1782)	LC
28	Наймас эрээлж	<i>Lefua costata</i> (Kessler, 1876)	LC
29	Потанины алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i> (Kessler, 1879)	LC
30	Шивэр сахалт эрээлж	<i>Barbatula toni</i> (Dybowski, 1869)	LC
31	Шивэр сугас	<i>Leuciscus baicalensis</i> (Dybowski, 1874)	LC
32	Шивэр чимхүүр загас	<i>Cobitis melanoleuca</i> (Nichols, 1925)	LC
33	Эгэл улаан нүдэн	<i>Rutilus rutilus</i> (Linnaeus, 1758)	LC
МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD)			
34	Амарын зантгар	<i>Mesocottus haitej</i> (Dybowski, 1869)	DD
35	Амарын сугас	<i>Leuciscus waleckii</i> (Dybowski, 1869)	DD
36	Амарын хавчигас	<i>Hemiculter varpachovskii</i> (Nikolskii, 1903)	DD
37	Амарын хөөлөнхэй	<i>Pseudorasbora parva</i> (Temminck & Schlegel, 1846)	DD
38	Амарын эрээн живэрт	<i>Cottus szanaga</i> (Dybowski, 1869)	DD
39	Байгалийн омуль	<i>Coregonus autumnalis</i> (Pallas, 1776)	DD
40	Буйрын монхор гүрц	<i>Microphysogobio tungtingensis</i> (Nichols, 1926)	DD
41	Булуу цагаан	<i>Cyprinus rubrofusculus</i> (Lacepède, 1803)	DD
42	Голубцовын сахалт эрээлж	<i>Barbatula golubtsovi</i> (Prokofiev, 2003)	DD
43	Дух давхаа	<i>Hypophthalmichthys molitrix</i> (Valenciennes, 1844)	DD
44	Ердийн гутаарь	<i>Lota lota</i> (Linnaeus, 1758)	DD
45	Ердийн гүрц	<i>Gobio acutipinnatus</i> (Menschikov, 1939)	DD
46	Завханы сахалт эрээлж	<i>Barbatula dsapchynensis</i> (Prokofiev, 2016)	DD
47	Карбановын сахалт эрээлж	<i>Barbatula karabanowi</i> (Prokofiev, 2018)	DD
48	Кесслерийн зантгар	<i>Leocottus kesslerii</i> (Dybowski, 1874)	DD
49	Конилобусын сахалт эрээлж	<i>Barbatula conilobus</i> (Prokofiev, 2016)	DD
50	Лаговскийн варлан	<i>Rhynchocypris lagowskii</i> (Dybowski, 1869)	DD
51	Манжуурын сугасан гүрц	<i>Gnathopogon strigatus</i> (Regan 1908)	DD
52	Монголын улаан далбаат	<i>Chanodichthys mongolicus</i> (Basilewsky, 1855)	DD
53	Морин тавхарал	<i>Hemibarbus labeo</i> (Pallas, 1776)	DD

№	Монгол нэр	Шинжлэх ухааны нэр	Бүс нутгийн үнэлгээ (2025)
54	Нуурын варлан	<i>Rhynchocypris percunurus</i> (Pallas, 1814)	DD
55	Өлгөр цагаан	<i>Culter alburnus</i> (Basilewsky, 1855)	DD
56	Савадигийн сахалт эрээлж	<i>Barbatula sawadai</i> (Prokofiev, 2007)	DD
57	Сахалт гүрц	<i>Romanogobio tenuicorpus</i> (Mori 1934)	DD
58	Солдатовын уруулт гүрц	<i>Sarcocheilichthys soldatovi</i> (Abbott 1901)	DD
59	Сэлэнгийн алтайн сугас	<i>Oreoleuciscus manchin</i>	DD
60	Тачановын гүрц	<i>Ladislavia taczanowskii</i> (Dybowski, 1869)	DD
61	Тогтмолын цоохлой	<i>Perccottus glenii</i> (Dybowski, 1877)	DD
62	Толбот морин загас	<i>Hemibarbus maculatus</i> (Bleeker, 1871)	DD
63	Тэсийн эрээлж	<i>Triplophysa gundriseri</i> (Prokofiev, 2002)	DD
64	Улаан живэрт	<i>Pseudaspius leptcephalus</i> (Pallas, 1776)	DD
65	Хадаасан гүрц	<i>Saurogobio dabryi</i> Bleeker, 1871	DD
66	Халбаган жараа	<i>Rhodeus sericeus</i> (Pallas, 1776)	DD
67	Ханхын гүрц	<i>Squalidus chankaensis</i> (Dybowski, 1872)	DD
68	Хятадын хуурамч гүрц	<i>Abbottina rivularis</i> (Basilewsky, 1855)	DD
69	Цагаан амар	<i>Ctenopharyngodon idella</i> (Valenciennes 1844)	DD
70	Цагаан догтор	<i>Chanodichthys erythropterus</i> (Basilewsky, 1855)	DD
71	Чекановын варлан	<i>Rhynchocypris czekanowskii</i> (Dybowski, 1869)	DD
72	Чоя чимхүүр загас	<i>Cobitis choii</i> (Kim et Son, 1984)	DD
73	Шивэр гүрц	<i>Gobio cynocephalus</i> (Dybowski, 1869)	DD
ҮНЭЛЭХ БОЛОМЖҮЙ (NA)			
74	Алтлаг хэлтэг	<i>Carassius carassius</i> (Linnaeus, 1758)	NA
75	Амарын бүвэр	<i>Rhinogobius lindbergi</i> (Berg, 1933)	NA
76	Найман сахалт гүрц	<i>Gobiobotia pappenheimi</i> (Kreyenberg, 1911)	NA
ЗҮЙЛИЙН МЭДЭЭЛЭЛ НЭН ХАНГАЛТГҮЙ ТУЛ ҮНЭЛЭЭГҮЙ ЗҮЙЛ			
77	Охор хоншоорт хадран	<i>Thymallus brevicephalus</i> (Svetovidov, 1931)	-
ҮНЭЛЭГДЭЭГҮЙ ХАРЬ ЗҮЙЛ			
78	Цагаан зарам	<i>Coregonus peled</i> (Gmelin, 1789)	-
79	Зоодой загас	<i>Abramis brama</i> (Linnaeus, 1758)	-
80	Шивэр зантгар	<i>Paracottus knerii</i> (Dybowski, 1874)	-



Монгол Улсын Их Сургуулийн
Шинжлэх ухааны сургуулийн Биологийн тэнхим
Цахим шуудан: gomboo@num.edu.mn
<https://www.num.edu.mn>

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн
Монгол дахь хөтөлбөрийн газар
Цахим шуудан: info@wwf.mn
<https://mongolia.panda.org>

